

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2023.12.13

ТАВИН

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр нь 5 бүлэг 11 хэсэг 185 заалт нь 2023 онд 84,33 хувийн хэрэгжилттэй байна.

Зорилт	Заалтын тоо	Үүнээс						хэрэгжилтийн хувь
		100	90	70	50	30	0	
НЭГ. НИЙГМИЙН БОДЛОГО. ЭРҮҮЛ ХҮН-ХӨГЖЛИЙН ҮНДЭС								80.67
1.1 Боловсролын салбарын бодлогын хүрээнд	29	18	2	3	3	3		83.79
1.2 Эрүүл мэндийн салбарын бодлогын хүрээнд	13	5	2	4	1	1		80.00
1.3 Соёл урлаг, спортын салбарын бодлогын хүрээнд	18	10		1	4	2	1	73.89
1.4 Нийгмийн халамжийн бодлого- Нэг өрх-Нэг ажлын байр	16	11		3	1		1	85.00
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО. ХӨГЖИЛД ТЭМҮҮЛСЭН ЕРӨӨЧҮҮД	26	13	3	4	2	3	1	78.46
ГУРАВ. ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСАГ ХӨГЖЛИЙН ТҮЛХҮҮР	6	3	2	1				91.67
ДӨРӨВ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГО								82.61
4.1 Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд	18	12	2	2	1	1		88.89
4.2 Үйлдвэрлэл худалдаа, үйлчилгээний бодлогын хүрээнд	11	3	5	1		2		80.00
4.3 Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд	19	9		6	3	1		78.95
ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО								88.22
5.1 Мэргэшсэн ёс зүйтэй төрийн алба	13	7	3	2		1		87.69
5.2 Иргэнд ээлтэй төр	16	11	2	2			1	88.75
Нийт:	185	102	21	29	15	14	4	84.33

№	Зорилт	Биелэлт	Хувиар																																									
НЭГ. НИЙГМИЙН БОДЛОГО. ЭРҮҮЛ ХҮН ХӨГЖЛИЙН ҮНДЭС																																												
1.1 БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД																																												
1	1.1 Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, 5 настай хүүхэд бүрийг сургуульд бэлтгэж, сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, чанарыг нэмэгдүүлнэ.	<p>Сумын нийт 5 настай хүүхдээс ердийн сургалтаар 151 хүүхэд, хувилбарт сургалтаар 16 хүүхэд суралцаж, 18 хүүхэд өөр орон нутагт суралцаж байна. 100% хамрагдсан. Энэ хичээлийн жилд Хувилбарт сургалтын багштай болсноор хамрагдаж чадахгүй байгаа малчин өрхийн хүүхдэд сургуулийн өмнөх боловсролыг зайнаас 14 хоног тутам сурах бичгийг бэлтгэн хэвлэж эцэг эхэд зөвлөгөө өгч хамтран ажилласан.</p> <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <thead> <tr> <th></th> <th>Ерөө 356</th> <th>Бугант (326)</th> <th>Хамрагдсан хүүхдийн тоо</th> <th>Хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>2 нас</td> <td>44</td> <td>50</td> <td>94</td> <td rowspan="3"></td> </tr> <tr> <td>3 нас</td> <td>64</td> <td>57</td> <td>121</td> </tr> <tr> <td>4 нас</td> <td>81</td> <td>62</td> <td>143</td> </tr> <tr> <td>5 нас</td> <td>93/76</td> <td>92/75</td> <td>185/151</td> <td rowspan="3">100%</td> </tr> <tr> <td>Хувилбарт сургалт</td> <td>35/10</td> <td>10/6</td> <td>45/16</td> </tr> <tr> <td>Өөр орон нутагт суралцдаг</td> <td>20/7</td> <td>18/11</td> <td>38/18</td> </tr> <tr> <td>Хамрагдсан хүүхдийн тоо</td> <td>320</td> <td>272</td> <td>592</td> <td>86.8%</td> </tr> <tr> <td>огт хамрагдаагүй /5 нас/</td> <td>0</td> <td>0</td> <td></td> <td>0%</td> </tr> </tbody> </table>		Ерөө 356	Бугант (326)	Хамрагдсан хүүхдийн тоо	Хувь	2 нас	44	50	94		3 нас	64	57	121	4 нас	81	62	143	5 нас	93/76	92/75	185/151	100%	Хувилбарт сургалт	35/10	10/6	45/16	Өөр орон нутагт суралцдаг	20/7	18/11	38/18	Хамрагдсан хүүхдийн тоо	320	272	592	86.8%	огт хамрагдаагүй /5 нас/	0	0		0%	100%
	Ерөө 356	Бугант (326)	Хамрагдсан хүүхдийн тоо	Хувь																																								
2 нас	44	50	94																																									
3 нас	64	57	121																																									
4 нас	81	62	143																																									
5 нас	93/76	92/75	185/151	100%																																								
Хувилбарт сургалт	35/10	10/6	45/16																																									
Өөр орон нутагт суралцдаг	20/7	18/11	38/18																																									
Хамрагдсан хүүхдийн тоо	320	272	592	86.8%																																								
огт хамрагдаагүй /5 нас/	0	0		0%																																								
2	1.2 Сумын хүүхэд багачуудыг эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Ерөө суманд “200 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулж”, шаардлагатай ор, ширээ сандал, тоглоом зэрэг хэрэглэгдэхүүнээр хангаж, урсгал зардал, багшлах орон тооны асуудлыг холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлж ажиллана.	<ul style="list-style-type: none"> Сэлэнгэ аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас сургалтын хэрэгцээнд 3.554.798 төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 суурин компьютер; Эцэг эхийн хандивын (7 бүлгийн) 7.113.000 төгрөгөөр 3 бүлэгт зурагт, тоос сорогч, хөшиг тогтоогч, хөшиг, нойлын өрөөний шалавч, аяганы тавиур, аяга, хогийн сав зэргийг авч, цэцгийн сав хийх бүтээн байгуулалтын ажлууд; Мон жим ХХК ны хөрөнгө оруулалтаар 1.644.000 төгрөгийн хөшиг, тюльтэй боллоо. Үүнд багш хөгжлийн төв, урлаг заал, коридорын цонхнууд; БЕГгазраас 16.147.444,20 төгрөгийн өртөг бүхий хүүхдийн ширээ, тавиур морин хуур, ус цэвэршүүлэгч, аяга таваг угаагч автомат машин, гурил зуурагч, шарах шүүгээ, багш ширээ; Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаар 8 бүлэгт 20.000.000 төгрөгийн өртөг бүхий 137 м хивс; БШУЯамнаас 220.000 төгрөгийн өртөг бүхий хэт ягаан туяаны кварц; Засгийн газрын тогтоолоор Багшийн ажлын үр дүнгийн урамшууллын 2.004.700 төгрөгөөр 8 бүлгийн хүлээн авах өрөөнд буйдан сандал; Засгийн газрын тогтоолоор Багшийн ажлын үр дүнгийн урамшууллын 2.372.500 төгрөгөөр 36.5 хивсэнцэр; Эцэг эхчүүдтэй хамтран тэдний дэмжлэг туслалцаатайгаар анги бүлгүүдийн сургалтын тавилга, хэрэгсэл, тоглоом наадгай зэргийг нийлүүлэн 6627000 төгрөгийн хөрөнгө оруулалттайгаар ангиудыг тохижуулсан. /2-р цэцэрлэг/ 1 болон 2-р цэцэрлэг багшлах боловсон хүчнээр бүрэн хангагдсан. 	100%																																									

3	1.3 Сумын төвийн 1-р цэцэрлэгийн шинэ барилгын ундны болон хэрэглээний усыг хангах эрүүл ахуйн шаардлага хангасан “ Гүний худаг” –ийг гаргаж ашиглалтад оруулна.	1-р цэцэрлэгийн шинэ барилгын ундны болон хэрэглээний усыг хангах эрүүл ахуйн шаардлага хангасан гүний худаг, бохирын цэвэрлэх байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ТАВАН ХАН ХХК 170.000.000 төгрөгийн өртгөөр гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Хэвийн ажиллаж байна.	100%
4	1.4 Сум , тосгоны сургууль цэцэрлэгийн “ Багш хөгжлийн төв”-үүдийг шаардлагатай техник хэрэглэгдэхүүнээр хангаж багш нарыг ажлын байран дээрээ хөгжих боломжийг бүрдүүлэн “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.	<p>Т.Бямбаагийн нэрэмжит ЕБСургууль:</p> <ul style="list-style-type: none"> • Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 159.700.000 төгрөгийн өртөг бүхий багш хөгжлийн төвийг тохижуулснаар багш ажлын байран дээрээ хөгжих боломж бий болсон. • Төсвийн шинэчлэлийн цахим худалдан авалтаар цахим танхимтай болох бэлтгэл ажил хангагдаж 25 ширхэг 39.975.000 төгрөгийн таблет /Android 64GB/, толгой компьютер, сүлжээ цацагч зэргийг захиалаад байна. Цахим сургалтын танхимтай болсноор суралцагчид ухаалаг төхөөрөмж дээр ажиллах чадвар нь сайжрах юм. • Багш нарынхаа мэдээллийн технологийн мэдлэг чадварыг сайжруулах, цахим сургалтын арга барилыг амжилттай нэвтрүүлэхэд нь туслах зорилготойгоор “Эрдмийн уран нар” ТББ-аас “Багш таны хөгжилд” сургалтыг захиалан танхимаар зохион байгуулсан бөгөөд сургуулийн нийт 36 багш, 3 удирдах ажилтан амжилттай хамрагдлаа. • СБ-4 сургуулийн зохион явуулсан medle.mn цахим платформ дээр ажиллах, ээлжит хичээлийн цахим контент боловсруулах сургалтад 39 багш, 4 удирдлага хамрагдсан. Багш нар paint, publisher, excel, word, earth pro, share it, moody, kinemaster, keynote, Photoshop, Reamark Office OMR, GeoGebra, Scratch, Edraw Maxword, power point, world map, Samtasia зэрэг программ хангамжуудыг хичээл сургалтдаа ашиглаж байна. Мөн Эдмодо платформ дээр дунд, ахлах ангийн багш нар цахим хичээлийн сантай болсон. 15 багш цахим хичээл боловсруулан medle.mn сайтад байршуулснаас С.Энхболор Г.Дүүмаа, Д.Батжаргал нарын хамтран бэлтгэсэн 10-р ангийн уран зохиолын хичээлээр "Монголын нууц товчооны шүлгүүд" сэдэвт хичээл 2-р шатандаа шалгарч дараагийн хичээлүүдээ боловсруулан илгээлээ. <p>1-р цэцэрлэг:</p> <ul style="list-style-type: none"> • СӨБ багш нар ажлын байранд тасралтгүй хөгжих боломж, нөхцөлийг бүрдүүлэн БМДИ-ээс зохион байгуулж буй үндсэн болон 5,10 жил, удирдах ажилтан багш нарын сургалтад арга зүйч хамрагдсан. Мөн цэцэрлэгийн туслах багш Ж.Энхжаргал, С.Сарангоо нарыг Дархан дээд сургууль суралцах нөхцөл боломжоор хангаж хамтран ажиллаж байна. Мөн цэцэрлэгийн багшдаа баярлалаа, Ерөө СӨБ багш групп чат гэх мэт багш мэргэжлийн тасралтгүй хөгжүүлэх боловсролын чанарыг сайжруулах ялангуяа суралцагчийн хөгжлийн хэрэгцээг хангасан, бүтээлч чадварлаг багшийг бэлтгэх, уян хатан хэлбэрээр тасралтгүй хөгжүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэн, түүнд дижитал технологи ашиглах зэрэг зорилт үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна. • Тогтвортой хөгжлийг дэмжигч Эко цэцэрлэгийн хөтөлбөр Анхан шатны 4 дэх танхимын сургалтад хамрагдсан 3 сард Сургалтад эрхлэгч, багш нар хамрагдлаа. Сургалтын төлбөр 250.000 төг төсвөөс зарцуулсан. • БЕГазраас зохион байгуулсан модуль сургалтад нийт 9 багш арга зүйч, эрхлэгч нийт 21 төрлийн сургалтад хамрагдсан. 1 сард . Нийт 960.000 төгрөгийн төсөв зарцуулсан. • БЕГазраас зохион байгуулсан Хүүхдийн хөгжлийн үнэлгээний арга зүй цахим сургалтад 10 багш хамрагдсан. 3 сард • Ажлын байран дээрх сургалт 5 удаа зохион байгуулсан. • Туслах багш М.Алтантуяа МУИС ийн Дорнод аймаг дахь салбар сургууль туслах багшийг мэргэшүүлэх 18 цагийн сургалт • Ажлын байран дээрээ интернэт орчноос болон мэргэжил нэгт багш нараасаа харилцан суралцаж байна. 	100%

Бугант ЕБС: Багш хөгжлийн төв нь тогтмол үйл ажиллагаатай.Багш хөгжлийн төвд хоног бүр шуурхай хурал, зарим сургалт, үйл ажиллагаа явуулдаг.Багш хөгжлийн төв нь дараах тоног төхөөрөмжтэй.Үүнд 32 инчийн телевизтэй, мэдээллийн самбартай, принтертэй. Цаашид багш хөгжлийн төвд багш нарын хөгжлийг дэмжих сургалт зохион байгуулахад ухаалаг дэлгэц шаардлагатай байна.

2-р цэцэрлэг:

Багш нарын дунд нээлттэй үйл ажиллагааг явуулсан ба бүлгийн 8 багш, хөгжмийн багш нар өөрсдийн боловсруулсан төлөвлөлтийн дагуу үйл ажиллагааг явуулж багш багшаасаа суралцаж бусдадаа арга туршлагаа түгээн дэлгэрүүлсэн. Багш О.Ганчимэг нь “Математикийн энгийн төсөөлөл чиглэлийн сургалтын үйл ажиллагаагаар цэцэрлэгийн багш нартаа туршлага түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан. Мөн бүлгийн эцэг эхийг сургалтдаа суулгаж хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаагаа нээлттэй явуулсан.

“Хүүхдийн хөгжлийн үнэлгээний арга зүй” онлайн сургалтад эрхлэгч, арга зүйч, хөгжмийн багш, бүлгийн 8 багш ажлын байран дээрээ дадлага хийн хамрагдаж багш нар батламжаа авсан. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад эхний болон 5 ,10 дахь жилдээ ажиллаж байгаа багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад 4 багш цахим болон танхимаар хамрагдаж батламжаа авсан. Боловсрол дахь ёс зүйн асуудал, шийдэл илтгэлийн уралдааныг байгуулга дээрээ зохион байгуулж 9 багш оролцсон. Ерөө бүсийн ерөнхий боловсролын сургууль,сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарын дунд зохион явуулсан шилдэг илтгэл шалгаруулах уралдаанд багш Г.Сарантуяа,О.Ганчимэг нар дэд байр эзэлсэн. Туслах багш нарын дунд хүүхэд хөгжүүлэх Хөгжөөн баясгах үйл ажиллагааг нээлттэй зохион явуулж 8 бүлгийн туслах багш нар амжилттай оролцож бие биенээсээ туршлага судлан хамтарч ажилласан. 2023-2024 оны хичээлийн жилд Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан Сургуулийн өмнөх боловсролын бэлтгэл бүлгийн багш нарт зориулсан сургалтад 2 багшийг хамруулж мэдлэг боловсролыг нь дээшлүүлэн ажилласан. Ерөө суманд болсон Ерөө бүсийн цэцэрлэгүүдийн багш нар , удирдах ажилтанд зориулсан сургалтад 9 багш 2 удирдах ажилтан хамрагдсан.

	ЕРӨӨ		БУГАНТ		Нийт
	ЕБС	1-р цэцэрлэг	ЕБС	2-р цэцэрлэг	
“Хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэгжүүлэх арга зүй” сургалтыг 12 судлагдахуунаар БМДИ-ээс цахимаар зохион байгуулсан	23	15	12	11	61
APLUS цахим сургалт /132 төрөл/	212	48	266	13	539
Ажлын байран дээрх сургалт 13	17	15	449	18	499
Бүсийн хэмжээний сургалт 9	12	8	42	5	67
Аймгийн хэмжээний сургалт 10	10	64	34	7	115
Үндэсний хэмжээний сургалт 3	8	21	35	4	68
	282	171	838	58	1349

5 1.5 Тосгоны сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилгоор хуучин цэцэрлэгийн барилгад их засварын ажлыг хийж, “Шинээр хоёр бүлэг”-ийг нэмж байгуулна.

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийг СӨБ-д хамруулан 1 бүлгийг шинээр нээн ажиллуулж 30 хүүхдийг цэцэрлэгт хамруулсан. Хуучин цэцэрлэгийн барилгад аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 80,0 сая төгрөгийн их засварын ажлыг Талхун арал ХХК гүйцэтгэж, сургуулийн өмнөх насны хүүхдийн хамран сургалтыг нэмэгдүүлж, хүүхдийн

100%

		сурч хөгжих ая таатай орчин бүрдсэн. /2022/																				
6	1.6 Ерөө сумын Ерөнхий боловсролын сургуулийн 960 хүүхдийн суудал бүхий олон улсын стандартад нийцсэн “ Шинэ сургуулийн барилга”-ыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулна.	“Монгол Алт ХХК”-н 11.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ерөө суманд 960 хүүхдийн шинэ сургуулийн барилга 2022 оны 9-р сарын 16-нд бүрэн ашиглалтад орсон бөгөөд 2023 онд сургалтын үйл ажиллагаагаа хэвийн явагдаж байна.				100%																
7	1.7 Бугант тосгоны сургуулийн барилгад их засварын ажлыг хийж, шинэ сургууль барьж , “Сургалтын орчныг сайжруулна”.	Сургуулийн их завсар хийх төсөв батлагдаагүй. Шинэ сургууль барих ажлыг шат дараатайгаар зохион байгуулан ажиллаж байна. Шинэ сургууль барих газрын гэрчилгээг гаргуулах ажлыг шийдвэрлэсэн. Мөн шинэ сургууль барих шаардлагатай байгаа болон өнөөгийн нөхцөл байдлын талаарх албан хүсэлтийг МУ-ын ерөнхий сайдад уламжлаад байна.				30%																
8	1.8 Хүн амын хэтийн төлөв, шилжилт хөдөлгөөн, хүүхдийн ердийн өсөлтийг харгалзан бодит хэрэгцээнд тулгуурлан “150 хүүхдийн дотуур байр”-тай болох асуудлыг шийдвэрлэж , суралцагчдыг эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлж өрөө тасалгааг тохижуулна.	Жил ирэх бүр дотуур байранд орох хүүхдийн тоо нэмэгдэж байгаа бөгөөд 150 хүүхдийн дотуур байр шинээр барих ажлын зураг төсвийг гарган Боловсролын газраар уламжлан 2023 оны улсын төсөвт суулгахаар явуулсан боловч төсөвт суугдаагүй. Шинээр төсөв хийлгэхээр уламжилсан. Эцэг эхийн хөрөнгө оруулалтаар 6 тасалгааг тохижуулсан. Сургуулийн захиргаанаас багш нарын өрөө болон угаалгын өрөө, шинээр агуулах байсан 2 өрөө, үүдний хонгилын хэсгийг засч шинэчилж тохижуулсан. Энэ хичээлийн жилд дотуур байранд 78 хүүхэд 2 багш, 2 тогооч, 1 үйлчлэгч 1 жижүүр ажиллаж байна. Хичээл 1 ээлжээр ордог болсонтой холбоотойгоор бага ангийн хүүхдүүд хөгжих боломж нь нээгдэж дугуйлан секцэнд бүрэн хамрагдаж байна Дотуур байрны гадна талын болон коридор, хүүхэд хөгжлийн өрөө, угаалгын өрөөний гэрэлтүүлгийг сайжруулж шинэчилсэн.				30%																
9	1.9 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийг боловсролын үйлчилгээнд хамруулж , хөгжлийг дэмжих зорилгоор “ Тусгай танхим”-ыг шинээр байгуулж сурч хөгжих боломжийг бүрдүүлнэ.	Ерөө сумын сургууль, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй нийт 21 хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулж байна. Үүнд: Ерөө ЕБСургуульд хөгжлийн бэрхшээл нь оношлогдсон 8 сурагч суралцдаг. сурагч М.Мөнхцэцэг “эсгий урлал, хавтгайн зохиомж” бүтээлийн дугуйланд хамрагдан хөгжиж байгаа бөгөөд хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр 4 сурагчийн хамтаар “Бид хамтдаа урлахуй” бүтээлийн үзэсгэлэнгээ сумандаа гаргасан. 5 сурагч урлагийн наадмын найрал дуундаа оролцсон бол 1 сурагч гоцлол дуугаар, 3 сурагч шинэ жилийн хамтлаг бүжигтээ тус тус оролцон үе тэнгийнхэнтэйгээ тэгш хамрагдан хөгжиж оролцож байна. 1 суралцагчийн өвчний байдал, гаргаж байгаа эрсдэлтэй үйлдлээс шалтгаалан зайны сургалтын хэлбэрийг сонгон суралцуулж байна. Сургууль олон улсын стандартад нийцсэн, тусгай хэрэгцээт хүүхэд сурах хөгжих бүрэн боломжтой. Зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ашиглах цахилгаан шаттай. Давхар бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөөг гаргаж тусгай тоноглолоор тоногдсон. Сургуулийн гадна талд стандартын налуу замтай бөгөөд тэргэнцэртэй хүүхэд саадгүй орох, гарах боломжтой. Бугант ЕБС-д Хөгжлийн бэрхшээлтэй 7 сурагч суралцаж байна.Үүнээс бие эрхтний 2, зүрхний хүнд гажиг 1, F71 оюуны хүнд хомсдолтой 1, хөлийн тавхайн гажиг 1, тагнай цоорхой 1, зүрхний цоорол 1 суралцаж байна. Цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй 6 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамрагдаж байна. Тус 6 хүүхдийг үндсэн болон хувилбарт сургалтад хамруулж хүүхдийн бие бялдар, хэл яриа танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжилд ахиц гаргасан. Бүлгийн багш тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийг цэцэрлэгт хамруулахад бусад хүүхэд, тэдний эцэг эхийн ойлголт, оролцоог дээшлүүлэх зорилгоор сургалт явуулж 36 эцэг эх асран хамгаалагчийг хамруулсан.				100%																
		<table border="1"> <thead> <tr> <th rowspan="2">Хөгжлийн бэрхшээлийн төрөл</th> <th colspan="2">Ерөө</th> <th colspan="2">Бугант</th> <th rowspan="2">Нийт</th> </tr> <tr> <th>ЕБС</th> <th>1-р</th> <th>ЕБС</th> <th>2-р</th> </tr> </thead> <tbody> <tr> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>				Хөгжлийн бэрхшээлийн төрөл	Ерөө		Бугант		Нийт	ЕБС	1-р	ЕБС	2-р							
Хөгжлийн бэрхшээлийн төрөл	Ерөө		Бугант		Нийт																	
	ЕБС	1-р	ЕБС	2-р																		

				цэцэрлэг		цэцэрлэг	
		Эр	3	3	7	2	15
		эм	5	1	-		6
		Харааны		0	-		0
		Сонсголын		0	-		1
		Хэл ярианы		1	1		3
		Тулгуур эрхтний		0	1		2
		Оюун ухаан, сэтгэц	5	1	1		7
		Хавсарсан	3	2	4		6
		Аутизм		0	-	2	2
		Үндсэн сургалтаар /өдрийн/	8	2	7	1	18
		Хувилбарт сургалт	-	2	-	1	3
		Нийт	8	4	7	2	21
10	1.10 Чадварлаг, мэргэжлийн боловсон хүчнийг түшиглэн “Төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалттай анги бүлэг” болох эх суурийг тавин, сургалтын орчин бүрдүүлнэ.	<p>Сэлэнгэ аймагт сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлсэн багш Б.Эдуард болон Ерөө сумын спорт цогцолборын арга зүйч, сагсан бөмбөгийн дасгалжуулагч багш Ж.Энхжаргал нарыг гэрээгээр ажиллуулсны үр дүнд сагсан бөмбөгийн спорт хөгжиж тэдний бэлтгэсэн эрэгтэй эмэгтэй тамирчин сурагчид аймаг улсын чанартай тэмцээн уралдаанаас олон медаль хүртсэн амжилтыг үзүүлээд байна.</p> <p>Улсын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнээс алтан медаль хүртсэн 2 сурагч, Төвийн бүсийн сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнээс 1 эрэгтэй сурагч алтан медаль, 4 эмэгтэй сурагч хүрэл медаль хүртэж Монголын хүүхдийн спортын 7-р наадамд оролцох эрх авч шилдэг 8-д үлдсэн, 3х3 U15 сагсан бөмбөгийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс багаараа хүрэл медаль, U18 улсын аварга шалгаруулах тэмцээнд эрэгтэй, эмэгтэй бүтэн багаараа оролцсон амжилтыг үзүүлсэн.</p>					70%
11	1.11 Сум, тосгонд мэдээлэл харилцааны технологийг нэвтрүүлж, “Цахим сургалтын орчныг бүрдүүлэх” зорилгоор шаардлагатай техник хэрэгслүүдийг шинэчилж, цахим сургалтад эцэг эхийн оролцоог хангаж багш нартай хамтран ажиллах боломжийг бүрдүүлнэ.	<p>Ерөө ЕБСургууль: Багш нар paint, publisher, excel, word, earth pro, share it, moody, kinemaster, keynote, Photoshop, Reamark Office OMR, GeoGebra, Scratch, Edraw Maxword, power point, world map, Camtasia зэрэг программ хангамжуудыг хичээл сургалтдаа ашиглаж байна. Эдмодо платформ дээр дунд, ахлах ангийн багш нар цахим хичээлийн сантай болсон. Төсвийн шинэчлэлийн цахим худалдан авалтаар цахим танхимд 32 ширхэг таблет /Android 64GB/, 2 ухаалаг самбартай болж сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулж байна. Энэхүү цахим ангид Eduten.Person хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.</p> <p>Бугант ЕБСургууль: Мэдээлэл харилцааны технологийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэн сургалтын цахим анги бүрдүүлэн ажиллаж байна.Нөхөн хангалтын зардлаар хичээлийн жилд 42 таблет, 10 нөтбүүк зэргийг худалдан авч цахим сургалтаа зохион байгуулж байна. Мөн энэ хичээлийн жилээс хэрэгжиж байгаа англи хэлний / 5,6-р анги/ pearson, бага ангийн /3,4-р анги/ eduten хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна.Цаашид сургалтын цахим тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөр бичиж 5 ангид проектор дэлгэц, ухаалаг дэлгэц 1 ийг нэмж авахаар ажиллаж байна.</p> <p>2024 онд мэдээлэл зүйн кабинетыг тохижуулах ажилд аймгийн төсөвт 50,0 сая төгрөгийг тусгуулсан.</p>					90%
12	1.12 Төгсөх ангийн сурагчдын дунд “Мэргэжил сонголт” арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулж, мэргэжлээ сонгоход нь арга зүйн зөвлөгөө, зөвлөмжийг өгч, ажлын байртай танилцах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ	<p>Ерөө ЕБС: Төгсөх 12-р ангийн сурагчдын эцэг эхчүүдтэй танхимын уулзалтыг зохион байгуулсан бөгөөд 8 багш, 28 эцэг эх хамрагдлаа. Уулзалтаар “ЭЕШ-ын бүртгэлийн талаар”, “Сурагчдын мэргэжил сонголын тухай”, “Их дээд сургуулиудын цахим хаягт хандаж элсэлтийн журам болон бүртгүүлэх тухай”, сургууль, багш нарын зүгээс ЭЕШ-нд бэлтгэж буй ажлын явц, үр дүн, мэргэжлийн багш нарын заавар, зөвлөгөө, Монгол хэл, бичгийн</p>					90%

		<p>шалгалтын талаар болон энэ чиглэлээр зохион байгуулж буй давтлага, оношлох үнэлгээний тухай, сурагчдыг ЭЕШ-ндаа амжилттай бэлтгэхэд эцэг эхийн оролцоо болон анхаарах асуудлын талаар дэлгэрэнгүй ярилцаж эцэг эхчүүдэд мэдээлэл өгсөн.</p> <p>ЭЕШ-нд бэлтгэж буй 12-р ангийн 34 сурагчдад УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбат “Шинэ алхам” номыг гардуулан өгсөн. Тус ном нь сурагчдад хэрэгцээтэй олон төрлийн мэдээллийг багтаасан гарын авлага төдийгүй оюутан болоход нь хөтөч болдог ач холбогдолтой юм.</p> <p>Мэргэжил сонголтын хүрээнд “Алхам алхмаар” аяны хүрээнд явагдсан 11 төрлийн сургалт мэдээллийг сурталчлан таниулах зорилгоор түгээхэд нийт 1623 хүн тандалт хийсэн ба ахлах ангийн сурагчдын дунд 4 удаагийн цахим сургалтад 304 сурагч хамрагдсан.</p> <p>Сэлэнгэ аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газраас ахлах ангийн 183 сурагчдад мэргэжил сонголтын талаар сургалт зохион байгуулсан. Мөн Дархан уул аймгийн МСҮТөвийн багш нар 9-р ангийн 78 сурагчдад, ХААИС, ШУТИС-ийн багш нар ахлах ангийн 180 сурагчдад мэргэжил сонголтын талаар мэдээлэл өгсөн байна. Мөн ахлах ангийн 183 суралцагч болон 595 эцэг эхчүүдэд Боловсролын зээлийн сангийн тухай мэдээллийг цахимаар болон танхимаар хүргэсэн.</p> <p>Бугант ЕБСургууль:</p> <p>Төгсөх ангийн 12-р ангийн 22 сурагчид сургууль болон бусад газраас зохион байгуулсан 16 удаагийн мэргэжил сонголтын сургалтад хамрагдсан. Мөн “ Мэргэжил бүхэн сайхан” арга хэмжээний хүрээнд тосгоны 12-р ангийн 22 сурагч алхах ангийн 22 сурагч нийт 44 сурагч 2-р цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллага дээр очиж тухайн байгууллагын үйл ажиллагаатай танилцсан.</p>	
13	1.13 Насан туршийн боловсролын “Сургалтын орчин”-г сайжруулна	<p>Ерөө ЕБСургууль:</p> <p>НТБ-ын багш сумын хүүхэд багачууд, иргэдийн хөгжлийг дэмжих сургалт нөлөөллийн ажил, сургалтуудыг амьдрах ухаан, эрүүл мэнд, гоо зүй, эрх зүй, ёс суртахуун, мэдээллийн технологи, мэргэжлийн чиг баримжаа олгох гэсэн олон талт чиглэлүүдээр мэргэжлийн багш нар болон бусад мэргэжлийн сургагч багш нартай хамтран тогтмол зохион байгуулан явуулж ирсэн.</p> <ul style="list-style-type: none"> • Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрийн хүрээнд 12 удаагийн сургалтад 1164 иргэн • Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд 3 удаагийн сургалтад 108 иргэн хамрагдсан • Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2 удаагийн сургалтад 137 хүн • гэр бүлийн боловсрол олгох 4 удаагийн сургалтад 128 иргэн • Ёс суртахууны боловсрол олгох 2 удаагийн сургалтад 56 иргэн • Тогтвортой хөгжлийн боловсрол олгох 3 удаагийн үйл ажиллагаанд 536 иргэн • Иргэдийн цахим ур чадварыг хөгжүүлэх 2 удаагийн сургалтад 112 хүн • Санхүүгийн боловсрол олгох сургалтад 56 хүнийг тус тус хамруулан мэдлэг мэдээллээр хангах ажлыг хийсэн. <p>Бугант ЕБСургууль:</p> <p>Насан туршийн боловсролын төв бусад мэргэжлийн багш, байгууллагатай хамтран дараах үйл ажиллагаа, сургалтыг зохион байгууллаа.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Насан туршийн боловсролын төвийн багш М.Саясарнай, сургуулийн эмч А.Цэнгүүн, эрүүл мэндийн төвийн эмч Ж.Мөнхдаваа нар хамтран “Гэр бүлийн эрүүл мэндийн боловсрол, гэр бүл төлөвлөлт, Бэлгийн замын халдварт өвчин түүнээс урьдчилан хэрхэн сэргийлэх” талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулж 9-11-р ангийн 62 сурагч хамрагдлаа. • Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт МСҮТ болон Их дээд сургуулийн ялгаа сургалтыг 8-9-р ангийн сурагчдад зохион байгуулж нийт 68 сурагч хамрагдлаа. • Өөрийн сонирхол авьяас чадварт тохируулж мэргэжлээ сонгох сургалтыг 10-11-р ангийн сурагчдад зохион байгуулж нийт 26 сурагч хамрагдлаа. 	100%

		<ul style="list-style-type: none"> Хэрхэн зөв их дээд сургууль сонгох вэ?. Сурагч болон оюутан хоорондын ялгаа сургалтын 12-р ангийн сурагчдад зохион байгуулж нийт 21 сурагч хамрагдлаа. үндэсний хэл бичгээ түгээн дэлгэрүүлэх сарын аяны хүрээнд удирдамж боловсруулан хөтөлбөрийн дагуу ажил үүргээ гүйцэтгэж байна. 	
14	1.14 Боловсролын стандартад суурилсан сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалтын чанарт ахиц гаргах бүх талын хамтын ажиллагааг өргөжүүлж, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэн мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлэх “Гадаад болон дотоодод туршлага судлуулах” ажлыг дэмжиж хамтран ажиллана.	<p>“Туршлагаа түгээ” хэлэлцүүлэгт хичээлийг зохион байгуулж тэргүүлэх, заах аргач зэрэгтэй 4 багш хичээлээ амжилттай зааж бусад багш нартаа арга туршлагаа түгээн дэлгэрүүллээ. Мөн залуу багш нар “Сайн хичээл” хэлэлцүүлэгт хичээлийг зааж арга туршлагаа солилцож хичээл заах арга зүйгээ тогтмол дээшлүүлж байна.</p> <p>АНУ-ын Аризона муж дахь Навахо омгийн Little Singer (Бяцхан Дуучин) дунд сургууль нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Т.Бямбаагийн нэрэмжит ЕБС-ийн сурагчдын хоорондын цахим солилцооны хөтөлбөр хэрэгжээд 3 жил болж байгаа бөгөөд хөтөлбөр нь монгол, индиан хүүхдүүдийн хооронд хоёр ард түмний уламжлалт соёл, зан заншил, мэдээллийн технологийн тухай мэдлэгээ харилцан солилцох, туршлага судлах зорилготой. хоёр орны сурагчид 15 удаа, удирдагч багш нарын 3 удаагийн онлайн уулзалтуудыг тус тус зохион байгуулж, сурагчдын код бичих чадварыг нэмэгдүүлэх, мэдээлэл технологийн мэдлэгийг дээшлүүлэх үүднээс легороботын чиглэлээр хамтран ажиллаж, техник сэтгэлгээгээ хөгжүүлж байна. АНУ-аас ирэх сургалтын хэрэглэгдэхүүний олон улсын агаарын ачаа тээврийн зардлын 360\$-ийн төлбөрийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 2022 онд шийдвэрлэн, хүүхдийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан.</p> <p>Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын гадаад хэлний багш нарт "Зүрх сэтгэлийн боловсролыг гадаад хэлний хичээлээр дамжуулан олгох нь" сургалтыг БШУГ-ын гадаад хэлний мэргэжилтэн Э.Энхмаа чиглүүлэн манай сургууль дээр амжилттай зохион байгуулж, Сэлэнгэ , Ерөө бүсийн 10 сургуулийн гадаад хэлний багш нарыг хамруулж сертификат гардууллаа.</p> <p>Нийслэлийн 80 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцах, ажил мэргэжлийн туршлага солилцох ажил 2023 оны 11 р сарын 9-ны өдөр 12 багш ажилчдын бүрэлдэхүүнтэй явагдлаа. Тус цэцэрлэг нь БҮТ ийн Багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд байгууллага улсад 1,2-р түвшинд үнэлэгдсэн амжилттай ажиллаж байгаа цэцэрлэг юм. Тус цэцэрлэгийн тэргүүн туршлагаас үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Ерөө бүсийн багш нарын туршлага солилцох уулзалт, сургалт 2023 оны 10 р сарын 09 -ны өдөр Ерөө суманд боллоо. Сургалтад Ерөө бүсийн цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш нар хамрагдлаа. Сургалтаар СӨБ-ын багш ажилчдын харилцааны онцлог ба ялгаатай тал сэдвээр Дархан Уул аймгийн Засаг даргын БШУ-ны зөвлөх Р.Батжаргал, СӨБ-ын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт Дархан Уул аймгийн 4 цэцэрлэгийн эрхлэгч Д.Гэрэлт Од, Аюулгүй амьдрах ухааны хөтөлбөр Дархан Уул аймгийн 27 р цэцэрлэгийн зөвлөх багш Ж.Батзаяа нар туршлага түгээлээ. Сургалтад нийт 60 багш нар хамрагдлаа</p>	100%
15	1.15 <i>Багш, сурагч солилцоо</i> ” хөтөлбөр боловсруулан хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.	<ul style="list-style-type: none"> Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын лаборатори 4-р сургуулийн багш нар Medle.mn платформд цахим хичээл байршуулах ажлын хүрээнд "Цахим хичээл боловсруулах арга зүй" сэдэвт сургалтыг 1-р улирлын амралтын хугацаанд манай сургууль дээр зохион байгуулан багш нар харилцан туршлага судалж ажиллалаа. Сүхбаатар сумын спорт сургуульд 11-р ангийн сурагч С.Дэлгэрцэцэг сурагч солилцоо хөтөлбөрт хамрагдан сагсан бөмбөгийн спортын техникүүдээс заалгасан бол Боловсролын ерөнхий газар болон “Дэлхийн мөрөөдлийн сургууль” НҮТББ хамтран хэрэгжүүлж буй 11,12-р ангийн эмэгтэй сурагчдад зориулсан “Дэлхийн Монгол охид”-2023 менторшип хөтөлбөрт Сэлэнгэ аймгаа төлөөлөн 126 ангийн сурагч Б.Анаржингоо шалгарсан. БНСУ-ын "On Happy" ТББ нь хамтын ажиллагаатай сургуулиудтайгаа хамтран Монгол улсад "EGS with UN SDGs -2023" буюу НҮБ-ийн тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд "Байгаль орчин , нийгэм, Засаглалын асуудал -2023 " сэдэвт форумд Сэлэнгэ аймгаас шалгарсан 4 сурагчийн нэг 10а ангийн сурагч Ч.Минжинсор 2023 оны 11-р сард монгол 20 сурагчийн хамтаар БНСУ-д болох уулзалтад оролцох байсан ч ирэх онд болохоор хойшлогдсон. 	100%

		<ul style="list-style-type: none"> • 2000 оноос одоог хүртэл "Иргэний боловсрол" төвтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд 2021 оноос АНУ-ын Аризона мужийн Навахо омгийн "Бяцхан дуучин" бага сургуулийн багш сурагчидтай цахим хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөр Уламжлал ёс заншил - Мэдээлэл технологи гэсэн үндсэн 2 чиглэлтэй бөгөөд 2022 оноос STEAM боловсролыг дунд ангийн түвшинд сурагчдад инженерчлэл, код бичих аргыг зааж туршлага солилцож байгаа бөгөөд 2 багш 13 сурагч цахим солилцоонд хамрагдаж байна. • Англи хэлний багш Н.Энхцэцэг СИИ сургалтын сургагч багшаар Булган аймагт 2023 оны 11-р сарын 8-11 хүртэл ажиллаж туршлагаа түгээн дэлгэрүүлсэн. • Орхон аймгийн Баян-Өндөр сумын 17-р сургуулийн 25 багш манай сургуульд ирж туршлага судлан, 4 цагийн сургалтад хамрагдсан. • Сургуулийн захирал Япон улсын Нагоя хотын их сургуулийн дэргэдэх ахлах сургуулийн байгалийн шинжлэх ухааны тусгай хөтөлбөрт оролцон туршлага судалсан байна. <p>1-р цэцэрлэг 2023 оны 03 дугаар сарын 9-10 хооронд Багш солилцоо" хөтөлбөр амжилттай явагдлаа. Дархан-Уул аймгийн 11 дүгээр цэцэрлэгийн ахлах бэлтгэл бүлгийн багш Б.Нордогсүрэн, Б.Ариунцэцэг нарын 2 өдрийн үйл ажиллагаатай Т.Майцэцэг, Д.Түмэнжаргал, Эрхлэгч Д.Туул нар танилцаж, багшийн хөгжлийг дэмжих, хүүхэд бүрийг хөгжүүлэх сургалтын арга зүйг сайжруулах, багш нар харилцан бие биеэсээ суралцах, туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлэх зорилготойгоор зохион байгуулагдлаа.</p>	
16	1.16 Сумын төвөөс алслагдсан өрхүүдийн хүүхдүүдийг зөөвөрлөх "Сургуулийн автобус"-ыг ажиллуулж, хүүхдүүд сургуульдаа аюулгүй ирж, буцах нөхцөлийг бүрдүүлнэ	<p>Сумын ЗДТГазраас 1-р багийн иргэн Ж.Оюунтөгстэй хариуцлагын гэрээ байгуулан Гэрэлтхайлаастанд амьдардаг 10 өрхийн 22 хүүхдийг сургуульд зөөвөрлөх ажлыг 2023 оны 01-р сарын 30-аас нийт 4 сарын хугацаанд зохион байгуулж, хүүхдүүдийг сургуульд нь аюулгүй ирж буцах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан бөгөөд орон нутгаас жолоочийн цалин, шатахууныг олгох асуудлыг шийдвэрлэж хүүхдийн аюулгүй байдалд анхааран ажилласан. (цалинд 2343875₮, шатахуунд 7841250₮)</p> <p>2023 оны 11.20-оос 12.30 хүртэлх хугацаанд Гэрэлтхайлаастанд 15 өрхийн 30 хүүхдийг зөөвөрлөх ажлыг хийсэн бөгөөд тус ажилд модны үйл ажиллагаа эрхэлдэг "Эгэл нарс ХХК" шатахуун, жолоочийн цалинд 1640000 төгрөгийг шийдсэн. Тус ажлыг 2-р багийн иргэн Л.Эрдэнэболд stimo маркийн машинаар гүйцэтгэж байна.</p>	100%
17	1.17 Сонгон, секц , дугуйланг хөгжүүлэх, клубүүдээр хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлж амжилт гаргасан " Багш, ажилтан, суралцагчдыг дэмжин" урамшуулах сан байгуулах.	<p>Ерөө ЕБСургууль:</p> <p>Бага ангид 18 төрлийн дугуйланд 375 сурагч буюу 86%, Дунд ахлах ангид 23 төрлийн дугуйланд 297 сурагч буюу 74% нь хамрагдан бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй 8 суралцагч 11 төрлийн дугуйлан, сонгон, секц, клубт хамрагдан хөгжсөн байна.</p> <p>Сумын Засаг дарга авьяас чадвараа хөгжүүлэн Сагсан бөмбөгийн спортоор хичээллэн 2023 онд Сэлэнгэ аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцож Алтан медаль хүртсэн 9 сурагчид тус бүрт 100.000 төгрөг нийт 900.000 төгрөг, мэргэжлийн хичээлийн улсын олимпиадын 2-ын даваанд амжилттай оролцож Англи хэлний хичээлээр Мөнгөн медаль, Нийгмийн ухааны хичээлээр Хүрэл медаль хүртсэн 1 сурагчид 100.000 төгрөг, Монгол улсын аварга шалгаруулах U15, U17 насны чөлөөт бөхийн тэмцээнд оролцож Алтан медаль хүртэж улмаар Киргиз улсын Бишкек хотод болох Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авсан 2 сурагчид тус бүрт 2.000.000 төгрөг нийт 4.000.000 төгрөг нийт 5.000.000 төгрөгийн шагналыг олгож суралцагчдын хөгжих боломжийг дэмжсэн.</p> <p>1-р цэцэрлэг: 256 хүүхэд 6 төрлийн дугуйланд хичээллэж байна. үүнээс Хөлөгт тоглоом шатар даамны дугуйлангаар 4 бүлгийн 4-5 насны 140 хүүхэд, шатрын дугуйланд 10 хүүхэд хичээллэж, наамал, хөдөлгөөнт гимнастик бүжиг, сэтгэхүй хөгжүүлсэн дугуйланд тус тус цэцэрлэгийн хүүхдүүд хамрагдан хөгжиж байна.</p> <p>Бугант ЕБС: Хүүхдийг хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар хөгжүүлэх чиглэлээр нийт 15 төрлийн сонгон, секц, дугуйлан, хөтөлбөр хэрэгжиж үүнд нийт давхардсан тоогоор 343 сурагч хамрагдаж байна.Хичээлээс гадуурх үйл</p>	100%

		<p>ажиллагаагаар хүүхдээ хөгжүүлэн ажилласан.</p> <p>2-р цэцэрлэг:</p> <p>Цэцэрлэгийн хэмжээнд хүүхэд багачуудын авьяас чадварыг хөгжүүлэх , тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэн бүжгийн , дууны , уран уншлага , зургийн дугуйлангуудыг хичээллүүлэн цэцэрлэгийн нийт хүүхдийн 80%-ийг хамруулсан.</p> <p>Дугуйлангийн хүүхдүүд аймгийн аварга шалгаруулах Бүжгийн ертөнц наадамд Ахлах А бүлгийн Хишигтэн хамтлаг оролцож Чөлөөт бүжгийн төрөлд Тэргүүн байр алтан медаль, олон үндэстний бүжгийн төрөлд Тэргүүн байр алтан медаль. Ахлах Б бүлгийн Өсөх нахиа хамтлаг бий биелгээ төрөлд Гутгаар байр хүрэл медаль хүртсэн.</p> <p>Аймгийн Уран жиргээ уран уншлагын уралдаанд ахлах А бүлгийн Б.Гэрэлчимэг оролцож дэд байр мөнгөн медаль хүртсэн амжилтуудыг үзүүлсэн. Хүүхдүүдээ уралдаан тэмцээнд амжилттай оролцуулж амжилт үзүүлсэн багш нарт байгууллагын дотоод журмын дагуу цалингийн 15-20 хувиар шагнаж урамшуулан дэмжлэг үзүүлж ажилласан.</p>	
18	1.18 Багшлах боловсон хүчнийг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэн орон байраар хангах, “Эдийн засгийн урамшуулал” олгох зэрэг хөшүүргийг бий болгон хэрэгжүүлж ажиллана.	<p>Ерөө ЕБСургууль Залуу багш нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх, орон байраар бүрэн хангаж чадахгүй байгаа боловч орон нутгийн түрээсийн байранд хямд зардлаар суух асуудлыг түрээслэгчтэй тохиролцон 3 багш, 2 ажилтны түрээсийн зардлыг байгууллагаас шийдвэрлэсэн.</p> <p>Бугант ЕБСургууль ашиглаж байгаа 2 байртай. Багшлах боловсон хүчнийг орон нутагт тогтвортой ажиллах бололцоог бүрдүүлэн сургууль өөрийн байрандаа байрлуулдаг. одоогоор бага ангийн 1 багш байрлаж байна.</p> <p>ЭЭШ-д бэлтгэсэн шавь нар нь улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн 6 багшид цалингийн 20-25%, хүртэл хувиар шагнаж урамшуулж, ур чадварын нэмэгдлийг олгосон.</p>	70%
19	1.19 Хүүхэд багачуудын хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор сум, тосгоны сургуулийн гадаад орчинд “Спорт тоглоомын талбай”, “Дугуйн талбай”-г шинээр байгуулж “Дугуйтай Ерөө “ хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	<p>Шинэ сургуулийн барилга ашиглалтад орж сургуулийн гадаад орчинд хөл бөмбөг, сагсан бөмбөг, волейболын спортын талбай шинээр хийгдэж хүүхдийн сурч, хөгжих таатай орчин бүрдсэн.</p> <p>Багш нар санаачлан “Дугуйтай Ерөө” клубийг байгуулан дугуй унахын ач холбогдол, биед үзүүлэх эерэг нөлөөллийг сурталчлан хүүхэд залуусыг дугуй унах хөдөлгөөнд нэгтгэж байна. сургуулийн орчинд 10м урттай, 2.5м өргөнтэй дугуйн зогсоолтой болох хүсэлтийг “Инфинити Спэйс” ХХК-д тавьж 2023-10-15-нд Хандгайт төмрийн хүдрийн уурхайн хүдэр баяжуулах үйлдвэрийн эцэг эхийн зөвлөлөөс 5.9 сая төгрөгийн дугуйн зогсоолыг хийж өгсөн.</p>	100%
20	1.20 Сум , тосгоны “ Сургууль цэцэрлэгийн орчны нөхцөлийг сайжруулах”, замыг засварлах, хурд сааруулагч тавих, тэмдэг тэмдэглэгээ, гэрлэн дохио гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, хяналтын камер суурилуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.	<p>Ерөө ЕБС:</p> <ul style="list-style-type: none"> • 1-12-р ангийн 847 сурагчийн “Гэр-сургууль-гэр” маршрутын дагуу аюулгүйн зураглалыг эцэг эхийн хамт хийлгэж, нийгмийн орчинд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэн 1-5-р ангийн сурагчдыг гараас гарт өгөх гэрээг хүүхэд нэг бүрээр байгуулан ажилласан. • Сумын ИТХ-ын дэмжлэгээр сургуулийн орчмын замд 350.000 төгрөгийн хүүхдийн дүрс бүхий анхааруулах самбарыг байршуулсан. • Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хүүхдүүдийн гаргасан саналыг харгалзан сургуулийн гадаад орчинд авто зогсоол, дугуйн замыг шийдвэрлэж өгсөн. <p>1-р цэцэрлэг:</p> <ul style="list-style-type: none"> • 4 суурин гэрэлтүүлэг (300вт прожуктор), туузан гэрэлтүүлэг 206м тавьж нийт 2.678 .000 төгрөг зарцууллаа. Орчны 4 талыг тал бүр тийш нь 300 метрт гэрэлтүүлэх бүрэн боломжтой. Гэрэлтүүлэг тавигдсанаар болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, байгууллагын өмчийг хамгаалах боломж нөхцөл бүрдсэн. • Цэцэрлэгийн хойд хэсэгт авто машины зогсоолыг ТАВАН ХАН ХХК, сум орон нутгийн удирдлагууд, багш ажилчид хамтран байгууллаа мөн тэмдэг тэмдэглэгээг байршуулж, 981.500 төгрөг зарцуулсан. • Явган хүний 120м замыг будаж, 487.000 төгрөг зарцуулсан. • Нийт 32 цэгт камер суурилагдсан. (Ангиудын өрөө тасалгаа, коридор, гадаа орчин). Өнөөдрийн байдлаар 	100%

		<p>бүрэн ажиллаж байгаа 22, засвар шаардлагатай 10 байна.</p> <p>Бугант ЕБС: Сургуулийн гадна дотор орчны эрсдэлийн үнэлгээг хавар, намартаа жилд 2 удаа хийж эрсдэлийг бууруулах, арилгах арга хэмжээг авч хэвшсэн. Хүүхдэд аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэхийг зорин ажилладаг.Энэ хичээлийн жилийн 9-р сард сургуулийн урд автомашины замд явган хүний гарцыг шинээр хийсэн.Мөн сургуулийн гадна 3 камер нэмж байршуулсан.</p> <p>2-р цэцэрлэг: Бага насны хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх , байгууллагын бүрэн байдлыг ханган ажиллах үүднээс цэцэрлэгийн 1-р байранд дотор камер – 4 , гадна камер 1 байршуулсан. Цэцэрлэгийн 2-р байранд гадаа 2, дотор 1 камерыг шинээр байрлуулсан.</p>	
21	1.21 Хүүхэд бүрийг бүтээлч сэтгэлгээтэй, нутгийнхаа түүх, байгалийн онцлог, соёл уламжлалаар бахархах эх оронч хүмүүжлийг олгох ажлыг зохион байгуулна.	<p>Ерөө ЕБС:</p> <ul style="list-style-type: none"> Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 2-р баг Энхталд НТӨ 200-аад оны үед холбогдох ХҮННҮ гүрний үеийн суурин олдсон бөгөөд Хүннүгийн үеийн он тооллыг урагшлуулах боломжтой энэхүү соёлын үнэт туурийн гадна хэсэг нь бороо уснаас хамгаалах суваг бүхий шороон хэрэм, дотор хэсэг нь утаагаар дамжуулан өрөөг халаах халаалтын системтэй чулуун өрлөг бүхий чулуун зуух, барилгын болон ахуйн хэрэгслийн зориулалт бүхий ваар зэргээс бүрдсэн байжээ. Одоогийн байдлаар археологчид тухайн газар нутгаас 96 орчим ижил бүтэц бүхий туурийг илрүүлээд байгаа юм байна. Сурагчид анхны эд өлгийн аяллаа хийхийн хажуугаар хэмжилт хийх багаж, туурийг дүрсэлсэн схем зураг гээд бүхий л баримттай танилцан эх орныхоо үнэт түүх соёлоос суралцлаа. “Монгол бахархлын өдөр” Монгол өв соёлоос суралцъя аяны хүрээнд Чингисийн билэг сургаалаас цээжлэх сэдэвт ажилд 1-5-р ангийн сурагчдын дунд “Чингис хааны билэг сургаал” -аас 6-8 мөрийг цээжилж ангиараа уншиж видео бичлэг хийн 1-3-р байр шалгаруулан өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаан урамшууллаа. Сургаалаар дамжуулж сурагчдыг хэл яриа, цээжлэн тогтоох чадварыг сайжруулах улмаар сургаалаас ухаарал авч хичээл, үйл ажилдаа мөрдөх, ёс уламжлалаас сурах дадуулах ач холбогдолтой юм. Их эзэн Чингис хааны мэндэлсний 861 жилийн ойг угтан Монгол бахархлын өдрөөр 9-р ангийн 45 сурагчид өөрсдийн угийн бичгийг хөтлөн судалж, үзэсгэлэн гаргасан бөгөөд 1-р байранд 96 ангийн сурагч Д. Буяннэмэх шалгарсан. Мөн энэ өдрөөр багш сурагчид бүгд үндэсний хувцсаараа гоёсон. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад цэрэг- эх оронч хүмүүжил олгох, эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил олгож, эх орноо Батлан хамгаалах Монгол цэргийн залгамж халааг бэлтгэх зорилгоор цэрэг-спортын “ДӨЛ-2023” цогцолбор тэмцээний Ерөө бүсийн болон аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд Т.Бямбаагийн нэрэмжит Ерөнхий боловсролын сургуулийн “ТЭМҮҮЛЭЛ”баг тус тус амжилттай оролцож “ТУСГАЙ БЭЛТГЭЛ”-ийн төрөлд шилдгээр шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулсан. Баг тамирчдын бэлтгэл хангах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сумын Засаг даргын нөөц хөрөнгө болон ЗДТГ азраас нийт 2,1 сая төгрөг зарцуулсан. <p>1-р цэцэрлэг:</p> <ul style="list-style-type: none"> “Монгол бахархал”-ын өдрийг “Дээлтэй Монгол”, “Монгол бахархал” хөгжүүлэх сургалтаар Монгол улсын түүх, соёл зан заншил, газар нутаг, үндэсний онцлогийн талаарх мэдээлэл гаргах арга хэмжээнүүдийн хүрээнд зохион байгууллаа. Бүлэг бүр хүүхдийн насны онцлогт тохируулан монгол үндэсний хувцас, тоглоом наадгай, үндэс угсаа, соёл ёс заншил, эх орон, эзэн Чингис хаан, бахархлын тухай ойлголтыг өгч, хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгууллаа. Үйл ажиллагаанд нийт 190 хүүхэд оролцсон. Монгол хэл бичгийн боловсролыг хүүхдүүдэд эзэмшүүлж хүн бүрийн эх хэлний боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд авианы зөв дуудлага төлөвшүүлэхэд чиглэсэн дасгал, даалгавар боловсруулан, хэлний 10 дасгалыг тогтмол хийж хэвшсэн. Авиа үсэг зөв дуудах, р, с, ш, т, д авиа орсон үг хэлэх, нэрлүүлэх гэх мэт. 	100%

		<ul style="list-style-type: none"> • Үндэсний өв соёлыг хөгжүүлэх, өвлүүлэх ажлын хүрээнд: Сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, монгол хүний хандлага, хүмүүжил, төлөвшилд нийцсэн түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны агуулгаар баяжуулсан сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд Зан заншлын өргөөний хэрэглэгдэхүүнийг баяжуулан хөлөгт ба оньсон тоглоом тус бүр 10 аар нэмэгдүүлсэн. Монгол ахуйг харуулсан малчны хотыг хийж 5 хошуу малын макет 20 ш хийсэн. • Хөлөгт тоглоом даамны дугуйлангаар 4 бүлгийн 4-5 насны ахлах бэлтгэл 140 хүүхэд, шатрын дугуйланд 10 хүүхэд хичээллэж байна. <p>Бугант ЕБС:</p> <ul style="list-style-type: none"> • Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан хими, физик, биологийн хичээлээр хийгдсэн хүүхдүүдийн бүтээлч үзүүлэн, туршилтын / super science/ уралдаанд 10-12-р ангийн 3 багийн нийт 13 сурагч амжилттай оролцсон. • Хан Хэнтий улсын тусгай хамгаалалттай газрын мэдээллийн төв, “stream” төслийн багийн хамт олонтой хамтран зохион байгуулсан “ Ойчидтой 1 өдөр” өдөрлөгт Эко клубийн 7-11-р ангийн 25 сурагч оролцож биологийн олон янз байдал, орон нутгийн онцлог, гал түймрийн дараах ойн сэргэлтийн талаарх сургалтын ойд зохион байгуулж сурагчдад танин мэдэхүйн болон эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. • Б.Мөнхцэцэг багштай 5б ангийн 22 сурагч иргэний ёс зүйн боловсрол хичээлийн хүрээнд эцэг эхийн дэмжлэгтэйгээр хөдөө айлд зочлон “ Мал тамгалах ёс” -ы талаар үзэж ахуй нөхцөлтэй танилцаж түүх соёлтой танилцлаа <p>2-р цэцэрлэг Хүүхдийг багаас нь үндэсний өв соёл , уламжлалаараа бахархаж , эх оронч хүмүүжилтэй болгох зорилгоор бүлэг бүр ёс заншлын буланг байгуулж , сургалтын хөтөлбөртөө эх орон , нутаг орны тухай агуулгыг оруулж хүүхдүүдэд зохих мэдлэгийг өгч ажилласан. Мөн хүүхдүүдийн дунд ардын дууны тэмцээн , үлгэр , түргэн хэллэгийн өдөрлөгүүдийг зохион байгуулсан ба эцэг эхчүүдийн дунд Монгол бахархлын өдрийг тохиолдуулан Дэвжээ тэмцээнийг зохион байгуулсан.</p>	
22	1.22 Сум, орон нутгийн хэмжээнд гэрээр хүмүүжиж буй бага насны хүүхэд багачуудыг “Хүүхэд харах үйлчилгээ”-нд хамруулж сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нөхцөл боломжийг бүрдүүлэн дэмжиж ажиллана	“Гэгээ” хүүхэд харах үйлчилгээний төвд 10 хүүхэд Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хүүхэд амрах, тоглох хэсэг хамтдаа, гар угаах бие засах өрөө тусдаа, гал тогооны өрөө үүдний өрөөний хамт байрладаг, байр дулаан, агааржуулалт цонхоор шийдэгдсэн орчинд 7 сарын хугацаанд хүмүүжсэн байна. Гэгээ төвийг хариуцсан ажилтан эрүүл мэндийн шалтгаантай тул түр зогссон байна.	30%
23	1.23 Боломжит төсөл, хөтөлбөрүүдийн дэмжлэгтэйгээр сумандаа тодорхой мэргэжлийн “Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв”-ийг шинээр байгуулж мэргэжилтэй залуу, боловсон хүчнийг орон нутагтаа бэлтгэнэ.	УБТЗамын дэргэдэх төмөр замын МСҮТөв болгох саналыг холбогдох байгууллагад хүргүүлсэн.	30%
24	1.24 Жилдээ орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж буй 10-аас дээш “ Оюутны сургалтын төлбөрт зохих дэмжлэгийг үзүүлж”, их дээд сургууль төгсөөд орон нутагтаа ажиллах гэрээг байгуулан хамтарч ажиллана.	“БТЕГ” ХХК-ний Баянгол сангийн хөрөнгө оруулалтаар Сумын Засаг даргын 2021 оны А/171 дугаарт захирамжаар баталсан “Суралцагчдад сургалтын төлбөрийн дэмжлэг олгох журам”-ын хүрээнд Ерөө сумын 23 оюутан хамрагдаж хүүхэд бүр 1,956,000 төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг авсан ба Тавин багаас 6, Буурагчин багаас 8, Бугант тосгоноос 9 оюутан хамрагдсан. /45,0 сая төг/ Дархан-Уул аймаг дахь уул уурхай эрчим хүчний политехникийн коллежид шууд суралцах эрхийн бичгийг тус сумын амьжиргааны түвшин доогуур 3 өрхийн 3 залуу, “Хандгайт уул” ХХК-ний санаачилгаар Техник технологийн коллежид 1 сурагчийг үнэ төлбөргүй сургахаар тус тус шийдвэрлэсэн. 2021-2022 онд 44 оюутны сургалтын төлбөрт 88.4 сая төрөг олгосон.	100%
25	1.25 Багш суралцагчийн хөгжлийг дэмжиж “Элсэлтийн Ерөнхий шалгалтад 800 оноо авсан	Ерөө ЕБС: ЭЭШ-д бэлтгэсэн шавь нар нь улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн Хэл уран зохиолын багш Ц.Цэцэгмаа,	100%

	сурагч, бэлтгэсэн багш”, улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн мэргэжлийн хичээлийн багшийг урамшуулж тэтгэлэг олгоно.	Биологийн багш П.Нямдорж, Нийгмийн ухааны багш Д.Мөнхжаргал, Англи хэлний багш Э.Уянга, Түүхийн багш Ш.Болортуяа нарт цалингийн 25%, аймгийн дунджаас дээгүүр үнэлэгдсэн Физикийн багш М.Алтанцэцэгт цалингийн 20% хүртэл хувиар шагнаж урамшууллаа. Бугант ЕБС: 2022-2023 оны хичээлийн жилийн Элсэлтийн ерөнхий шалгалтыг 26 сурагч 7 судлагдахуунаар нийт 84 шалгалтыг өгч 515.6 оноо авч Сэлэнгэ аймгийн хэмжээнд 9-р байранд жагссан амжилтыг үзүүллээ.Өмнөх оны элсэлтийн ерөнхий шалгалтын оноог 65 оноогоор нэмэгдүүлсэн амжилттай байлаа.7 судлагдахуун тус бүр өмнөх хичээлийн жилийн дундаж оноогоо ахиуллаа.ЭЕШ-д бэлтгэсэн шавь нь амжилттай оролцсон багш нарт ур чадварын нэмэгдэл олгон урамшуулан ажиллаж байна.	
26	1.26 Суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллагын ажилтан, албан хаагчдын хүүхдийн хараа хяналтыг сайжруулах зорилгоор хүүхэд хамгааллын жишиг бодлого болон холбогдох хууль тогтоомж , дүрэм журам, стандартыг хангасан “Өдөр өнжүүлэх төв”-ийг сургуулийг түшиглэн нээж, шаардлагатай хэрэглэгдэхүүнээр тохижуулна.	Монгол Улсын Ерөнхий сайдын 03 тоот тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургуулийн багш ажилтны хүүхдийн мэдлэг боловсрол, аюулгүй байдлыг хангах зорилгоор сургууль дээрээ байгууллагын эцэг эхийн зөвлөлийн саналыг үндэслэн “Өдрийн багш” өдөр өнжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж багш, ажилтны 18 хүүхдийг ахмад багшийн удирдлага дор хамруулан 2 дахь жилдээ ажиллаж байна. Энэхүү хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүд гэрийн даалгавраа хийх, нэмэлт давтлага хийх, чөлөөт цагаараа тоглоомоор тоглох зэрэг үйлчилгээнд хамрагдан хөгжиж байна.	50%
27	1.27 Сургуулийн суралцагчдад хөдөлмөрийн дадлага туршлага олгох байгалийн ухааны хичээлийн туршилт хийх зориулалтын 2га “туршлагын талбай, ногооны газартай болгоно”	Хавар биологийн хичээлээр хүүхдүүд мэргэжлийн багштайгаа хамтран ногооны үрсэлгээгээ хийж зуны амралтаар сургуулийн үйлчилгээний ажилтнууд шилжүүлэн суулгаж, ургуулах ажлыг хийж гүйцэтгэдэг. Шинэ сургуулийн барилга туршилтын талбайд баригдсанаас шалтгаалан сумын газрын албанд 1га газрын хүсэлт материалаа бүрдүүлж өгч газрын асуудлаа шийдүүлсэн ч техник хэрэгсэлгүй учраас хол газар ногоо тарих боломжгүй байна.	50%
28	1.28 Хичээлийн 1-р байрны барилгыг цаашид ашиглах зорилгоор дээврийг шинэчилж, шувуун оройтой болгон өөрчилж, урсгал засварыг хийж гүйцэтгэнэ.	Хичээлийн 1-р байрны дээвэр шинэчлэх ажлыг "Таванхан-Уул" ХХК 65.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн. /2022 онд/ Цэцэрлэгийн 2-р байрны дээврээс дусаал орж анги танхим , өрөө тасалгаа руу нэвчин орж үйл ажиллагаа явуулахад хүндрэл гарч, 2023 оны 05 дугаар сард дээврийн засварын ажлыг улсын комисс хүлээн авсан. Засварын төсөв сум орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 52.5 сая төгрөг.	100%
29	1.29 Оюуны спортыг хөгжүүлэх төв байгуулах.	Энэ хичээлийн жилд нийт 35 сонгон дугуйлан хичээллэж байгаагаас 2 багш нас насны ангилалд шатрын дугуйлан хичээллүүлж сургуулийн аварга шалгаруулах тэмцээнээ нас, насны ангиллаар зохион байгуулсан. Цаашид шатрын танхимтай болох зорилт тавин ажиллаж байна. Мөн нийтийн дунд зохион байгуулж буй спортын арга хэмжээнд 3 удаа шатрын тэмцээн зохион байгуулж 45 иргэн оролцсон байна. 1-р цэцэрлэгт 256 хүүхэд 6 төрлийн дугуйланд хичээллэж байна. үүнээс Хөлөгт тоглоом, даамны дугуйлангаар 4 бүлгийн 4-5 насны 140 хүүхэд, шатрын дугуйланд 10 хүүхэд хичээллэж байна.	70%
1.2 ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД			
1	2.1 Сумын эрүүл мэндийн төв нь 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн сайдын А/540 тоот тушаалаар “А” зэрэглэлд /хуучнаар сум дундын эмнэлэг/ шилжсэнтэй холбогдуулж тойргийн сумдын хүн амд “Үндсэн 4 төрлийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлнэ”.	Ерөө сумын эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/540 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар “А” зэрэглэлийн эрүүл мэндийн төв болсон. 2023 онд нийт 3494 үзлэг хийсэн. Үүний 23% урьдчилан сэргийлэх үзлэг, 63% амбулаторийн үзлэг эзэлж байна. Нийт дуудлага 2331 үүнээс ойрын дуудлага 2041, алсын 290 дуудлага, осол гэмтлийн 56 дуудлагад хүрч үйлчилсэн. Стационарт 244 өвчтөн эмчлэгдэж гарсан байна. ЭМТ-ийн дарга, их эмч Д.Золжаргал нь дотрын эмчийн /хоол боловсруулах эрхтэн судлал/ үзлэгийг шаардлагатай өвчтөн үйлчлүүлэгчид үзүүлэхээс гадна ЭХО оношилгоог иргэдэд долоо хоног бүрийн мягмар, пүрэв гарагуудад хийдэг. 2023 онд өөрийн орон нутгийн 314 хүнд эхо үзлэг, 112 хүнд дотрын эмчийн үзлэг,	100%

		<p>шаардлагатай хүндэвтэр, хүнд, маш хүнд өвчтөний асуудал шийдвэрлэхэд хамтран оролцож мэргэжил аргагүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.</p> <p>Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 01/56 дугаар албан бичиг болон бусад холбогдох хууль тогтоомж, шийдвэрүүдийн дагуу алслагдсан хүн ам, малчин өрх, отор нүүдлээр яваа иргэдэд “Халуун сэтгэл-23” нүүдлийн эрүүл мэндийн үзлэгийн багт ажиллаж Хушаат, Түшиг, Зүүнбүрэн, Хүдэр, Баянгол сумдад дотрын эмчийн үзлэг болон эхо оношилгоо хийж ажиллалаа.</p> <p>2024 онд эмэгтэйчүүдийн эмчээр Б.Содцэцэг эмчийг сургахаар захиалга өгсөн.</p>	
2	2.2 Эрүүл мэндийн салбарын “хүний нөөцийн ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулж”, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэн иргэдэд хүрч үйлчлэх боломжийг хангана.	<p>Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр болон сургалтын хөтөлбөрийн дагуу эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүд мэдлэг мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, чадавхыг нь сайжруулах чиглэлээр дотоодын 22 төрлийн сургалт, Сэлэнгэ аймгийн ЭМГазраас зохион байгуулсан урт болон богино хугацааны, цахим 13 төрлийн сургалтад давхардсан тоогоор 168 албан хаагч хамрагдсан.</p> <ul style="list-style-type: none"> • Ажилчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор 2100000 төгрөгөөр СНЭ-тэй гэрээ хийсний үндсэн дээр урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулсан. • Ажилчдад 2 удаа 235000 төгрөгийн дархлаа дэмжих витаминжуулалт хийсэн. • Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх зааврын дагуу эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд нягтлан, нярав тогооч нар хамрагдсан . • Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу үндсэн цалингийн 6 сартай тэнцэх тэтгэмжид ТҮЭМ ангилалд хамаарагдах ажилтнууд хамрагддаг. 2023 онд эмийн санч Сүхцэцэг уг тэтгэмж, урамшуулалд хамрагдаж байгаа. • Эмнэлгийн мэргэжилтэн , ажилчдын ажлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг үндэслэн санаачилгатай, сайн ажилласан ажилчдад улирлын үр дүнгийн урамшууллыг 60 хүртэлх хувиар олгож байна. • ЭМБ-ийн гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотойгоор 11 сард ажилчдын үндсэн цалинг 20-25 хувиар нэмэгдүүлэн олгосон. • Нийт эмч ажилчдад Эрүүл мэндийн тухай хуулийн 79-р зүйлд заасан 5 жил тутамд 1 хоногийн нэмэгдэл амралтыг ээлжийн амралтын хоног дээр нь нэмж олгон мөрдөн ажиллаж байна. • Эмчлэх, сувилах эрх, мэргэжлийн үйл ажиллагааны лицензийн хугацаа цаг хугацаандаа сунгагддаг. 2023 онд 1 их эмчийн эмчлэх лиценз сунгагдсан. • Ажилчдын ажлын байрны таатай нөхцөл, үйлчлүүлэгчдийн эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэх ээлтэй орчныг бүрдүүлсэн. • ЭМТ-ийн нийт ажилчдад байгууллагын зардлаар 1825000 төгрөгийн өртөг бүхий ажлын байрны хувцасаар хангасан. <p>Бага эмч Ж.Мөнхдавааг Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу сарын үндсэн цалинг олгож дархлаажуулалтын сувилагчаар 3 сарын сургалтад хамруулж байна.</p> <p>Ажиллах орчин нөхцөлийг хангах үүднээс БТЕГ-ХХК-ийн санхүүжилтээр Ерөө, Бугантад 2 орон сууцыг худалдан авч шинээр ажилд орсон эмч, сувилагч нарыг амьдруулж байна. 2023 онд ажилчдыг 2 төрлийн ажлын хувцсаар хангахад 4764000 зарцуулсан байна.</p>	100%
3	2.3 “Эрүүл хүүхэд Ерөөгийн ирээдүй” урианы дор хүүхэд багачуудыг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, эрүүл өсөж бойжих нөхцөлийг бүрдүүлнэ.	<p>Ерөө ЕБС-ын эмчтэй хамтран 1-12 ангийн сурагчдын дунд эрт илрүүлгийн урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж 766 хүүхэд буюу 89,7 хувийг хамруулсан. Уг үзлэгээр бүх сурагчдад амны хөндийн үзлэгийг давхар хийсэн бөгөөд өвчлөлөөр нь авч үзвэл: Шүд хорхойтох өвчин /Кариес/ 378 буюу 49,3%, Архаг тонзиллит 3,3 хувийг тус тус эзэлж байна. Амны хөндийн эрүүл мэндийн талаар, тэр дундаа шүдээ угаах үйлдлийг хэвшил болгох зорилгоор ЕБС 3а ангийн 25 сурагчдыг шүдний нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж, “Амны хөндийн эрүүл мэнд”, “Шүдээ хэрхэн зөв угаах вэ” дадлага сургалтыг зохион байгууллаа.</p> <p>Шүдний их эмч Н.Энэрэл ЕБС-ын 5-8 ангийн сурагчдад амны хөндийн эрүүл мэнд, шүд хорхойтох өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар 12 сарын дундуур сургалт хийхээр төлөвлөж байгаа. Эрүүл</p>	90%

		<p>мэндийн төвийн шүдний кабинетаар /шүдний нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт/ давтан үзлэгтэй нийлээд давхардсан тоогоор нийт 90 хүн үйлчлүүлснээс 28 буюу 31 хувийг хүүхдүүд эзэлж байна. Цаашид ЭМТ нь байнгын шүдний эмчтэй болох зорилт тавин ажиллаж байна.</p> <p>Эрүүл мэндийн яам, Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, НҮБ-ийн Хүүхдийн сан хамтран хэрэгжүүлж буй "А бүлгийн стрептококийн шалтгаант хоолой залгиурын үрэвсэлт өвчин, хэрэхийн шалтгаант зүрхний олдмол гажгаас урьдчилан сэргийлэх нь" төслийн хүрээнд сургуулийн насны хүүхдүүдийн дунд спрептококийн халдварыг эрт илрүүлэх үзлэг оношилгоог 2 өдрийн турш амжилттай зохион байгуулж, Т.Бямбаагийн нэрэмжит ЕБС-ийн 1-5 ангийн 421, хавьтал 29, нийт 450 хүүхдийг 100 хувь хамрууллаа Спрептококийн халдварт өвчнөөр эерэг гарсан хүүхдүүдийг хяналтад авч 2-р шатны эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авч ажиллана.</p> <p>Томуу, ТТӨ, улаанбурхан, улаанууд өвчин нь амьсгалын замаар дамжин халдварладаг, бага насны хүүхэд зонхилон өвдөх эрсдэлтэй, халдварлалт, хүндрэл, эндэгдэл өндөртэй өвчин. Улаанбурхан улаанууд өвчнөөс сэргийлэх УЛААНБУРХАН, УЛААНУУД өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалт 2023 оны 05 сарын 29-ны өдрөөс эхлэн 6 сарын 10-ны өдрийн хооронд улс орон даяар эхэлсэн бөгөөд 10 сартайгаас 8 настай 420 хүүхдийг дархлаажуулалтад хамруулсан. Улаан бурхан,улаанууд өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 2 удаа хийж 38 хүн хамрагдсан.</p> <p>ЭМСайдын 2023 оны10 сарын А/ 358, Сэлэнгэ аймгийн ЭМГазрын даргын А/60 тоот тушаалаар Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2023 оны 10 сарын 10-наас 20 ны хооронд “Томуугаас сэргийлье” урианы дор зохион байгууллаа.</p> <p>Улирлын томуугүйн эсрэг вакцинаар жирэмсэн эмэгтэйчүүд, эрсдэлт бүлгийн хүн ам, эрүүл мэндийн байгууллагын ажилтан, эцэг эх асран хамгаалагчийн зөвшөөрлөөр 2-5 насны хүүхдэд нийт 269 хүн буюу 92,8 хувийг хамруулсан.</p> <p>Бугант ЕБС болон 2 дугаар цэцэрлэгийн сурагчдыг сургууль цэцэрлэгийн эмч нартай хамтран жилд 2 удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулдаг. Энэ онд ЕБС-н 6-18 насны 550 хүүхдээс урьдчилан сэргийлэх үзлэгт 442 хүүхэд хамрагдсан . Үүнээс ЧХХ-124, Зүрх судасны эмгэгтэй 2, Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 2, Ходоодны эмгэгтэй 1, Карисстай 236 хүүхдэд эмчилгээ зөвлөгөө өгсөн. 2-р Цэцэрлэгт 2-5 насны 220 хүүхэд хүмүүжиж байгаагаас 186 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийснээс ЧХХ 28, ДЧӨ 18, Карисстай 19, Ханиад шуухинаа 7, Рахит өвчнөөр 2 хүүхэд өвчилж эмчилгээ зөвлөгөө өгсөн. 2023 оны 5 болон 10 сард 6-59 сартай 524 хүүхдэд А аминдэм уулгасан. Сургууль цэцэрлэгийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 80% хийж гүйцэтгэсэн. 0-17 насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгт нийт 1203 хүүхэд хамрагдахаас 651 хүүхэд хамрагдсан хамрагдалтын хувь 54.7% байна.</p>																															
4	2.4 Ерөө, Бугант тосгоны Эрүүл мэндийн төвүүдийн “Барилгын өргөтгөлийн ажил”-ыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.	Ерөө ЭМТөвийн барилгын өргөтгөл 2024 онд баригдахаар улсын төсөвт 849,5 сая төгрөг батлагдсан байна. /нийт өртөг 1699,0 сая төгрөг/	70%																														
5	2.5 Иргэн бүрийг жилд 1 удаа урьдчилан сэргийлэх, “Эрт илрүүлэх” нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоонд иргэдийг 100 % хамруулна.	<p>ЭМС-ын тушаалын дагуу иргэдийг эрт ирүүлэг үзлэгт хамруулж байна. /59,1%/</p> <table border="1" data-bbox="801 1286 2024 1490"> <thead> <tr> <th rowspan="2">Эрт илрүүлэг</th> <th colspan="2">Нийт хамрагдвал зохих тоо</th> <th colspan="2">Хамрагдсан тоо</th> <th colspan="2">хамралтын хувь</th> <th rowspan="2">Дундаж</th> </tr> <tr> <th>Ерөө</th> <th>Бугант</th> <th>Ерөө</th> <th>Бугант</th> <th>Ерөө</th> <th>Бугант</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэг</td> <td>2571</td> <td>1486</td> <td>1287</td> <td>1437</td> <td>50.1</td> <td>96.7</td> <td>73.4</td> </tr> <tr> <td>Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэг</td> <td>1592</td> <td>1486</td> <td>1211</td> <td>1437</td> <td>76.1</td> <td>96.7</td> <td>86.4</td> </tr> </tbody> </table>	Эрт илрүүлэг	Нийт хамрагдвал зохих тоо		Хамрагдсан тоо		хамралтын хувь		Дундаж	Ерөө	Бугант	Ерөө	Бугант	Ерөө	Бугант	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэг	2571	1486	1287	1437	50.1	96.7	73.4	Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэг	1592	1486	1211	1437	76.1	96.7	86.4	70%
Эрт илрүүлэг	Нийт хамрагдвал зохих тоо			Хамрагдсан тоо		хамралтын хувь		Дундаж																									
	Ерөө	Бугант	Ерөө	Бугант	Ерөө	Бугант																											
Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэг	2571	1486	1287	1437	50.1	96.7	73.4																										
Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэг	1592	1486	1211	1437	76.1	96.7	86.4																										

		<table border="1"> <tr> <td>Элэгний эрт илрүүлэг</td> <td>2571</td> <td>1486</td> <td>994</td> <td>363</td> <td>38.7</td> <td>24.4</td> <td>31.5</td> </tr> <tr> <td>Умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг</td> <td>180</td> <td>216</td> <td>46</td> <td>95</td> <td>25.6</td> <td>44.0</td> <td>34.8</td> </tr> <tr> <td>Хүүхдийн эрт илрүүлэг үзлэг</td> <td>1322</td> <td>1203</td> <td>1124</td> <td>651</td> <td>85.0</td> <td>54.1</td> <td>69.6</td> </tr> <tr> <td>ДҮН</td> <td>8236</td> <td>5877</td> <td>4662</td> <td>3983</td> <td>56.6</td> <td>67.8</td> <td>59.1</td> </tr> </table> <p>Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан Халуун сэтгэл 2023 аяны хүрээнд алслагдсан айл өрхөд нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, 2 төрлийн оношилгоо (зүрхний цахилгаан бичлэг, эхо)-д 258 иргэн хамруулж, 230 гаруй өвчлөл илэрснээс шинээр оношлогдсон 10 байна.</p> <p>Эрүүл мэндийн даатгалаар хийгддэг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц үзлэгт /СНЭ- Дэмжих төв/ 64 иргэн хамрагдсан байна. Илрүүлэг үзлэгүүдээр өөрчлөлттэй гарсан иргэдийг эмчлэх асуудлыг шийдвэрлэхэд анхаарал хандуулан ажиллаж байна.</p>	Элэгний эрт илрүүлэг	2571	1486	994	363	38.7	24.4	31.5	Умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг	180	216	46	95	25.6	44.0	34.8	Хүүхдийн эрт илрүүлэг үзлэг	1322	1203	1124	651	85.0	54.1	69.6	ДҮН	8236	5877	4662	3983	56.6	67.8	59.1	
Элэгний эрт илрүүлэг	2571	1486	994	363	38.7	24.4	31.5																												
Умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг	180	216	46	95	25.6	44.0	34.8																												
Хүүхдийн эрт илрүүлэг үзлэг	1322	1203	1124	651	85.0	54.1	69.6																												
ДҮН	8236	5877	4662	3983	56.6	67.8	59.1																												
6	2.6 “Амны хөндийн эрүүл мэнд хөтөлбөр”- ийн хүрээнд “Шүдний эмчтэй болох” асуудлыг холбогдох шатанд уламжлан шийдвэрлүүлнэ.	<p>Ерөнхий боловсролын сургуулийн эмчтэй хамтран 1-12 ангийн сурагчдын дунд эрт илрүүлгийн урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж 766 хүүхэд буюу 89,7 хувийг хамруулсан. Уг үзлэгээр бүх сурагчдад амны хөндийн үзлэгийг давхар хийсэн бөгөөд өвчлөлөөр нь авч үзвэл: Шүд хорхойтох өвчин /Кариес/ 378 буюу 49,3%, Архаг тонзилит 3,3 хувийг тус тус эзэлж байна.</p> <p>Амны хөндийн эрүүл мэндийн талаар, тэр дундаа шүдээ угаах үйлдлийг хэвшил болгох зорилгоор ЕБС 3а ангийн 25 сурагчдыг шүдний нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж, “Амны хөндийн эрүүл мэнд”, “Шүдээ хэрхэн зөв угаах вэ” дадлага сургалтыг зохион байгууллаа.</p> <p>Эрүүл мэндийн төвийн шүдний кабинетаар /шүдний нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт/ давтан үзлэгтэй нийлээд давхардсан тоогоор нийт 90 хүн үйлчлүүлснээс 28 буюу 31 хувийг хүүхдүүд эзэлж байна. Цаашид эрүүл мэндийн төв нь байнгын шүдний эмчтэй болох зорилт тавин ажиллаж байна.</p>	70%																																
7	2.7 Эрүүл мэндийн төвүүдийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж /УВЧ аппарат, мэс заслын багаж хэрэгсэл, эхо аппарат, унтуулахын аппарат, биохимийн анализатор, зулайн аппарат, нярайн шарлагын аппарат/, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	<p>Ерөө ЭМТөв Амбулаторийн өрөөний орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор үйлчлүүлэгчдийн эмчилгээний дуслын хөлтэй 3 угсраа сандал 1 ширхэг 650000 төгрөгөөр, эмчилгээнд орж буй үйлчлүүлэгчдэд хэрэглэх цэвэршүүлсэн усны аппарат 250,000 төгрөгөөр авч үйлчилгээндээ хэрэглэж байна. Бугант ЭМТөвд ЭМЯамнаас спирометр 2ш, хурууны пульсоксиметр 16 ширхгийг хандиваар өгсөн.</p> <p>Эрүүл мэндийн төвүүд сувилахын тусламж үйлчилгээнд шаардлагатай хэрэгслүүд болон УВЧ, Нярайн шарлалтын фото аппарат, Биллиметр, Таблет Хэвлийн эхо, Зүрхний цахилгаан бичлэг, Биохимийн хагас автомат анализатор, Гемталогийн хагас автомат анализатор, Мэс заслын багаж хэрэгсэл, Ургийн доплер, Мониторинг зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжөөр 95% хангагдсан.</p>	90%																																
8	2.8 Хөдөөгийн өрх, малчдад жилд 2-оос доошгүй удаа эрүүл мэндийн үйлчилгээг хүргэж ажиллана	<p>Алслагдсан багийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг явуулын амбулаториор хүргэх “Халуун сэтгэл-23” үзлэгийн баг Ерөө суманд ажиллаж, нийт 1140 орчим иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүргэж үйлчилсэн. Тус үзлэгийн баг алслагдсан хэсэгт хүрч ажиллахдаа нийт 450 гаруй км зам туулж 3 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, 2 төрлийн оношилгоо (зүрхний цахилгаан бичлэг, эхо)-д 258 иргэн хамруулж, 230 гаруй өвчлөл илэрснээс 10 нь шинээр оношлогдсон байна.</p> <p>Багийн бага эмч Г.Эрдэнэтуяа Энхтал, Нарийн хөндий, Хандгайт, Улаанбулаг, Шаазгайтын 56 малчин өрхийн 162 хүнд, бага эмч Ж.Мөнхдаваа, сувилагч Батцэцэг нар Цагаан тохой, Баянгол, Ходоодын хэсгийн малчдаар УГУ вакцинажуулалт болон урьдчилан сэргийлэх үзлэг хийж эрүүл мэндийн үйлчилгээ, мэдээллийг хүргэж ажилласан.</p>	70%																																
9	2.9 Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх иргэд рүү чиглэсэн эрүүл мэндийн сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлж, “Халдварт болон халдварт бус өвчлөлийг	<ul style="list-style-type: none"> • Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлын хүрээнд: Хүн амыг улирлын чанартай томуу, томуу төст өвчин бусад хүн байгалийн үзэгдлээс шалтгаалах халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 6 удаагийн сургалт, 10 төрлийн ажил арга хэмжээг, 3 удаагийн үзлэг оношилгоог зохион байгуулж нийтдээ давхардсан тоогоор 2500 гаруй иргэнийг хамруулсан. Улирлын 	100%																																

	бууруулна”	<p>чанартай томуу томуу төст амьсгалын замын өвчлөл хүндрэлээс урьдчилан сэргийлэх халдварт өвчин ихсэх улирлыг угтуулан иргэдийн дунд сургалт сурталчилгааг гарын авлага, брошур хийж цахим хуудсанд зөвлөгөө мэдээлэл байршуулах, халдварын эсрэг дэглэм зэрэг арга хэрэгслийн талаар иргэдэд тогтмол сурталчилдаг.</p> <ul style="list-style-type: none"> • Эрүүл идэвхтэй амьдрал арга хэмжээний хүрээнд: Иргэд, албан хаагчдын эрүүл мэнд, хөдөлгөөнийг дэмжин эрүүл сайхан агаарт эрчимтэй хөдөлгөөн хийх нөхцөлийг бүрдүүлэх, эвсэг хамт олонч зан төлөвшүүлэх, нийгэм соёлын оролцоог идэвхжүүлэх зорилгоор 4 арга хэмжээ, 2 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 1350 иргэнийг хамруулсан. • Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээний хүрээнд: Иргэдэд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс сэргийлэх зорилгоор “Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэхэд иргэдийн оролцоо”, “НҮЭМ”, “Гэр бүл төлөвлөлт”, “Гэр бүлийн хүчирхийлэл” сэдвүүдээр сургалтуудыг зохион байгуулж нийт 53 иргэн хамрагдсан. • Харшлаас сэргийлэх арга хэмжээний хүрээнд: Ургамлын болон тоосны харшил элбэг тохиолддог сарууд буюу 4-9 сард иргэд, албан хаагчдад танхимаар болон цахимаар “Ерөө сумын эрүүл мэндийн төв сургалт сурталчилгаа” хаягаар зөвлөмж мэдээлэл хүргэн ажиллаж байна. • Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хүрээнд : Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/577 тоот /2022-2025 /Элэг бүтэн Монгол арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд үзлэг шинжилгээг стандартын дагуу чанартай, аюулгүй, жигд хүртээмжтэй нэмэлт төлбөргүй үйлчилгээ үзүүлж ажилласан бөгөөд элэгний хавдар илрүүлэх үзлэгт 1231 хүнийг хамруулсан. Элэгний В,С вирустэй нийт 81 үйлчлүүлэгчээс В вирустэй -46, С вирустэй 31, ВС хавсарсан вирустэй -4 байна. 2023 онд В вирус -6, С вирус -6 ВС хавсарсан вирустэй -3 нийт 15 иргэн вирус илэрсэн бөгөөд нийт хяналтаас хасагдсан -9, одоо 87 хүн хяналтад байна. Элэгний хяналтын үйлчлүүлэгчдийн 98 хувь нь вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдсан. Элэгний хорт хавдрын хяналтад 7, элэгний хатууралтай 4 хүн эмчилгээ үйлчилгээ авч байна. • Хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдэд 2023 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн ээлжийн сувилагч нар орой 22:00 цагт зонхилон тохиолдох өвчлөлийг бууруулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 35 хүнд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт явуулж, өглөө 08:00 цагт дасгал хөдөлгөөн хийлгэж хэвшсэн. Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн байдалд эмчлэгч эмч нар судалгаа хийн цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцдэг. /Бугант ЭМТ/ 																							
10	2.10 Товлолт вакцинжуулалтыг хугацаанд нь гүйцэтгэж, “Эх нялхсын эндэгдэлгүй ажиллана”.	<p>2023 онд Ерөөгийн ЭМТөвүүдэд 8 эх төрж 9 нярайг эндэгдэлгүй авсан. Тэдгээрийг төрсний дараах 24 цагийн товлолын дархлаажуулалтад 100% хамруулсан. Энэ онд нийт 106 эх төрж 107 нярайг товлолын дархлаажуулалт цаг тухай үед нь хамруулсан. Заавал хийх болон нэмэлт дархлаажуулалтад хамрагдалтын хувь 94 хувь байна.</p> <table border="1" data-bbox="801 1265 2040 1481"> <thead> <tr> <th rowspan="2"></th> <th colspan="2">Ерөөд төрсөн</th> <th rowspan="2">24 цагийн вакцинжуулалт</th> <th colspan="2">Бусад орон нутагт төрсөн</th> <th rowspan="2">товлолт вакцинжуулалт</th> <th rowspan="2">нялхсын эндэгдэл</th> <th rowspan="2">Тайлбар</th> </tr> <tr> <th>эх</th> <th>хүүхэд</th> <th>эх</th> <th>хүүхэд</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Ерөө</td> <td>2</td> <td>2</td> <td>100%</td> <td>62</td> <td>62</td> <td>98% /1 хүүхэд дутуу төрсөн, вакцин хийх хугацаа болоогүй/</td> <td>2</td> <td>1 нярай - 1 сартай, гадны шалтгаант осол гэмтэл, 1 нярай - 9 сартай, төрөлхийн ховдол</td> </tr> </tbody> </table>		Ерөөд төрсөн		24 цагийн вакцинжуулалт	Бусад орон нутагт төрсөн		товлолт вакцинжуулалт	нялхсын эндэгдэл	Тайлбар	эх	хүүхэд	эх	хүүхэд	Ерөө	2	2	100%	62	62	98% /1 хүүхэд дутуу төрсөн, вакцин хийх хугацаа болоогүй/	2	1 нярай - 1 сартай, гадны шалтгаант осол гэмтэл, 1 нярай - 9 сартай, төрөлхийн ховдол	100%
	Ерөөд төрсөн			24 цагийн вакцинжуулалт	Бусад орон нутагт төрсөн		товлолт вакцинжуулалт	нялхсын эндэгдэл				Тайлбар													
	эх	хүүхэд	эх		хүүхэд																				
Ерөө	2	2	100%	62	62	98% /1 хүүхэд дутуу төрсөн, вакцин хийх хугацаа болоогүй/	2	1 нярай - 1 сартай, гадны шалтгаант осол гэмтэл, 1 нярай - 9 сартай, төрөлхийн ховдол																	

								хоорондын гажиг
Бугант	6	7	100%	44	45	100%	0	-
	8	9		106	107	99%	2	

Вакцины нэр	Хамрагдвал зохих		Хамрагдсан тоо		Хувь		
	Ерөө	Бугант	Ерөө	Бугант	Ерөө	Бугант	
Заавал хийх дархлаажуулалт							
БЦЖ	1	8	1	8	100	100	100
ВВГ	57	8	57	8	100	100	100
Х/саа	207	132	219	127	100	94.4	97
тавт	207	1.26	219	119	105.8	94.4	100
ПЭВ	204	122	199	113	97.5	94.4	96
саа тариагаар	65	41	58	34	89.2	92.6	91
ВАГ	112	38	100	29	89.3	76.3	83
УГУ	120	52	113	44	94.2	84.6	89
сахуу, татран	152	85	153	87	100.7	102.3	101
Нэмэлт дархлаажуулалт							
уу	600	640	610	640	101.7	100	101
ковид		0					
томуу	300	250	300	250	100.0	100	100
Сайн дураар хийлгэх дархлаажуулалт							
ВВГ		45	57	45		100	50
хачигт энцефалит		500	31	483		96.6	48.3
Тархвар судлалын заалтаар							
Галзуу	23	12	23	12	100%	100	50.5

11	2.11 “Ахмадын сувилал”-ын үйл ажиллагааг сэргээн тогтмолжуулж бие эрүүл, сэтгэл амар, ая тухтай орчныг бүрдүүлнэ.	Орон нутгийн төсвийн 800,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Ахмадын сувилал”-ын барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулахаар төлөвлөн төсөв санхүүгийн төлөвлөгөөндөө тусган ажилласан боловч мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн зураг, төсөв тооцоолсон хэмжээнээс 1 дахин нэмэгдсэн өртөгтэй гарсан. Гэсэн хэдий ч орон нутгийн зүгээс холбогдох дээд шатны төсөвт тусгуулахаар төлөвлөн ажиллаж эхний элжинд газрын асуудлыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөндөө тусгаад байна. Зураг, төсвийн ажил бэлэн болсон..	30%
12	2.12 Сумын иргэдэд эрүүл зөв хооллолт, стрессээ удирдах, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх дасгал хөдөлгөөн, иог, бүжиг хийх	ЭМТ нь 2023 оны 4 сараас 1 сарын хугацаатай Бугант тосгоны эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран “Энэ жилдээ эрүүл жиндээ” аяны хүрээнд өглөө болгон алхалт дасгал хөдөлгөөн хийсэн. Давхардсан тоогоор 186 эмэгтэй иргэн хамрагдсан байна.	50%

	зэрэг үйлчилгээг авах бололцоо бүхий “Эрүүл зөв амьдрал” төвийг ажиллуулах бололцоог улсын төсөв, хувийн хэвшлийн оролцоотойгоор дэмжин хөгжүүлнэ	Монголын үг урлаачдын нийгэмлэгийн хүмүүнлэгийн лектор Чила иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө лекц хийхэд дэмжлэг үзүүлсэн. Хэвтэн эмчлүүлэгч нарт “Зөв зохистой хооллолт, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх нь” сургалт сурталчилгааг хийж байна.	
13	2.13 Эрүүл мэндийн төвийн эмч ажилчдыг урамшуулан дэмжиж ажиллах.	<p>Ерөө ЭМТөв:</p> <ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу үндсэн цалингийн 6 сартай тэнцэх тэтгэмжид хуулийн дагуу 2023 онд эмийн санч Сүхцэцэг хамрагдаж байна. • Эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын ажлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг үндэслэн санаачилгатай, сайн ажилласан ажилчдад улирлын үр дүнгийн урамшууллыг 60 хүртэлх хувиар олгож байна. • ЭМБ-ийн гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотойгоор 11 сард ажилчдын үндсэн цалинг 20-25 хувиар нэмэгдүүлэн олгосон. • Нийт эмч ажилчдад Эрүүл мэндийн тухай хуулийн 79-р зүйлд заасан 5 жил тутамд 1 хоногийн нэмэгдэл амралтыг ээлжийн амралтын хоног дээр нь нэмж олгон мөрдөн ажиллаж байна. • ЭМТ-ийн нийт ажилчдад байгууллагын зардлаар 1825000 төгрөгийн өртөг бүхий ажлын байрны хувцсаар хангасан. <p>Бугант ЭМТөв:</p> <ul style="list-style-type: none"> • 2022 онд эмнэлгийн ажилчдын байртай болсон ба шинээр ирсэн сувилагч амьдарч байна. • 2023 оны эхний 3 улирлын байдлаар 27,000,000 төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна. 	100%
1.3 СОЁЛ УРЛАГ, СПОРТЫН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД			
1	3.1 Сумандаа 500 хүний суудалтай “Шинэ Соёлын төв”-тэй болох асуудлыг холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлнэ.	400 хүний суудалтай 3,8 тэрбум төгрөгийн өртөг бүхий Соёлын төвийн барилгын ажил 2024 онд улсын төсвийн 1,9 тэрбум төгрөгөөр санхүүжигдэхээр батлагдсан байна	70%
2	3.2 “Бид Сэлэнгийн үр сад”, “Эв модны наадам”, “Алтаргана” зэрэг томоохон урлаг, соёлын арга хэмжээнүүдэд оролцож, хүүхэд залуучууд, уран бүтээлчдийг дэмжиж ажиллана	2023 онд аймаг, бүсийн чанартай 6 удаагийн уралдаан наадмуудад Ерөө сумаас давхардсан тоогоор нийт 403 хүүхэд, том хүн оролцож 7 цом, 117 алт, 112 мөнгө, 167 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлээд байна.	100%
3	3.3 Сум, тосгоны соёлын төвүүдийг шаардлагатай техник тоног төхөөрөмж /лед дэлгэц/, хэрэглэгдэхүүнээр хангаж, тохижуулна.	<p>Ерөө сумын Соёлын төвүүд 2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 6х4м, 5х3м харьцаатай ЛЕД дэлгэцүүдтэй болсон. /130,0 сая төгрөг/</p> <p>2023 онд аймаг, улс, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 46,977,400 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Аймгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 15 сая төгрөгийн 22 ширхэг үндэсний хөгжмийн зэмсэг /Морин хуур, ятга, лимбэ, товшуур хөгжмүүд/ 2.Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 13,9 сая төгрөгөөр тайзны өмсгөлөө иж бүрэн шинэчилсэн. 3.Соёлын яамны хөрөнгө оруулалтаар 18,077,400 төгрөгийн үнэтэй 198 хүний суудалтай сандал 	100%
4	3.4 Сумын номын сангийн уншлагын танхимыг интернэтэд холбож компьютер, тоног төхөөрөмжөөр ханган номын фондыг нэмэгдүүлэн “Цахим номын сан”-гийн үйлчилгээг нэвтрүүлнэ.	Соёлын яамны хөрөнгө оруулалтаар 2,0 сая төгрөгийн шилэн кабелийг Монголын цахилгааны холбооны Сэлэнгэ аймгийн холбооны салбартай гэрээ байгуулан 2023 оны 04 дүгээр сард тавьж суурилуулсан.	50%
5	3.5 Соёлын төвийн “Үндэсний хөгжим”-ийг шинэчилнэ. /Ёочин, шанз, ятга, морин хуур, хуучир, лимбэ гэх мэт.	Аймгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 15 сая төгрөгийн 22 ширхэг үндэсний хөгжмийн зэмсэгтэй болсноор ардын урлагийг түгээн дэлгэрүүлж, орон нутгийн соёлын байгууллагын үйл ажиллагаа явуулах нөхцөл боломж бүрдсэн.	100%

6	3.6 Өсвөр үе, залуучууд, иргэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдраа хөгжүүлэх, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шинээр “Фитнес төв”-ийг байгуулна.	Бугант тосгоны Хүүхэд хөгжлийн төвийн их засварын ажилд аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 320,0 сая төгрөгийн ажлын “Сэлэнгэ Ундрэм”ХХК 100% гүйцэтгэсэн. ИТХ- 2022 оны 12 дугаар сарын 28 өдрийн тогтоолоор Хөгжлийн сангийн хандивын хөрөнгө оруулалтаар фитнес төвийн тоног төхөөрөмжийн 30 сая төгрөг баталсан боловч хэрэгжүүлэх боломж бүрдээгүй.	50%
7	3.7 “Ахмадын өргөө”-ний халаалтын асуудлыг шийдвэрлэж үйл ажиллагааг тогтмолжуулна.	Бугант тосгоны ахмадын өргөөний урсгал засварын ажлыг аймгийн ОНХС-ын 100 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Сэлэнгэ Ундрэм” ХХК 100% гүйцэтгэсэн.	100%
8	3.8 Сумын орон нутаг судлах “Музейн үзмэр”-ийг баяжуулж нутаг орныхоо онцлог, түүх соёлын онцлогийг сурталчилна.	2023 оны жилийн эцсийн байдлаар ЕБСургууль, Цэцэрлэгийн нийт 338 хүүхэд, 56 том хүнд сумынхаа Орон нутаг сурталчлах танхимаа сурталчилж, сум орон нутгийнхаа түүхийн талаар мэдээлэл өглөө. Мөн хүүхэд бүрийг сум орон нутгийнхаа түүхийн талаар мэдлэг мэдээлэлтэй болгох зорилгоор Ерөө сум байгуулагдсаны 100 жилийн ойг угтаж ЕБС-ийн сурагчдын дунд “Миний сум-миний бахархал” гар зургийн уралдаан, Олон Улсын Музейн өдрийг тохиолдуулан сурагчдын дунд “Музей миний нүдээр” гар зургийн уралдаан, Ахмадуудын дунд шагайн наадгайг хөгжүүлэх зорилгоор “Өв соёлоо дээдэлье” тэмцээн, Улаанбаатар хот байгуулагдсаны 384 жилийн ойг угтан ЕБС-ийн сурагчдын дунд Ерөө сумын түүхийн талаар “АХА” тэмцээнийг тус тус зохион байгуулж давхардсан тоогоор 115 хүүхдийг хамрууллаа.	100%
9	3.9 Бугант тосгонд иргэд, хүүхэд залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, хөгжих орчныг бүрдүүлэх зорилгоор шинэ “Спорт цогцолбор/-ыг байгуулна.	БТЕГ ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд хийхээр ИТХ-ын зөвлөл БТЕГ удирдлагуудтай уулзаж зураг төсөв хийгдсэн. 2024 онд Баянгол сангийн хөрөнгө оруулалтаар барьж эхлэхээр төлөвлөсөн.	30%
10	3.10 Сумандаа “Өвлийн спорт”-ыг бодлогоор дэмжихийн зэрэгцээ үндэсний уламжлалт спортыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.	Оросын холбооны Буриад улсын Закаменск-д зохион байгуулагдсан Бөмбөгтэй хоккейн олон улсын тэмцээнд Сэлэнгэ аймгаа төлөөлж Бугант тосгоны сурагчид оролцон Тэргүүн байр эзэллээ. /1,0 сая төгрөг/ Сурын довын цэц мэргэн холбооны нээлтэд зориулсан харваа тэмцээн 2023.02.25,26-нд амжилттай болж өндөрлөлөө. Тэмцээнд Дархан Уул аймаг, Сэлэнгэ аймаг, Ерөө сум, Хүдэр сум, Бугант тосгоны нийт 50 гаруй харваач цэц мэргэнээ сорин өрсөлдлөө. Ерөө сумын сурын холбооноос санаачлан зохион байгуулсан Хойд бүсийн мөсөн сурын аварга шалгаруулах тэмцээнийг дэмжиж 10,0 сая төгрөг зарцууллаа. Тус тэмцээнд 18 багийн 200 гаруй тамирчид оролцож, мөсөн сурын спортын мастерын болзлыг 18, дэд мастерын болзлыг 5 тамирчин тус тус хангасан байна. Мөн Хоккейн спортыг дэмжиж хувцас хэрэглэл, тэмцээний зардалд 8,0 сая төгрөг зарцуулсан.	100%
11	3.11 Угийн бичиг хөтлөх болон соёл урлагийн салбарын үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг ханган иргэд, олон нийтэд сурталчилж ажиллана.	Суманд зохион байгуулагдсан “ХАРИУЦЛАГАТАЙ МАЛЧИН-ХӨДӨӨ АЖ АХУЙН СЭРГЭЛТ” сургалтад оролцсон малчдад “УГИЙН БИЧИГ ХӨТЛӨХ НЬ” сэдэвт сургалт хийн дараа нь Угийн бичигтэй холбоотой асуулт хариулт явуулж 2 малчин иргэнийг ДДШТВ-ийн ФАНАТ- 3 сарын эрхийн бичгээр шагнаж урамшууллаа. Номын сангаас “Угийн бичгээ хөтөлцгөө” гарын авлага хийн иргэдэд тараалаа. Хамрагдсан хүний тоо: 30 2.2023.05.24-ны өдөр 2-р багийн Тасгийн малчдад “Угийн бичгээ хөтөлцгөө” гарын авлагыг 11 иргэнд тараалаа. 3. Цахимаар: • Угийн бичиг гэж юу вэ?, • Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар • Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол • Угийн бичгийн схем зураглал • Угийн бичиг хөтлөх арга зүй • 3 үеийн угийн бичиг хөтлөх загвар • Угийн бичиг хөтлөх журам, тэмдэглэгээ зэрэг 7 мэдээллийг хүргэсэн./ 60 лайк, 49 сэтгэгдэл/ Мөн соёлын төвөөс хандгайтын малчдад соёлын үйлчилгээгээ хүргэлээ. Энэ үеэр малчин өрхүүдэд “Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол” -ын талаар гарын авлага тараан сургалт явууллаа. Оролцсон хүний тоо 40.	50%

12	3.12 Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор соён гэгээрүүлэх ажлыг тогтмолжуулж, “Цахим соёл”-ыг түгээн дэлгэрүүлнэ.	Бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор соён гэгээрүүлэх ажлыг тогтмолжуулж, “Цахим соёл”-ыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд Соёлын төвд үндэсний наадгай болох “ Шагайн харваа”-г хөгжүүлэх өвлүүлэх зорилгоор 30 гаран залуус нэгдэн өдөр бүр тогтмол хичээллүүлж байна. “Zumbo” бүжгийн сургалт хичээллэж 20 хүн хамрагдсан байна. Цахим соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд “ Сэтгэлийн үг ” хайрын захидлын уралдаан, “ Ээждээ захидал бичээрэй ”, “ Эхийн тухай дууг хэн сайн дуулах вэ”, зэрэг цахим уралдаанууд зохион байгуулж , СББӨ-ийг өвлөн уламжлагчдын мэдээлэл, Соёлын төвийн ажил үйлчилгээ арга хэмжээнүүдийг Соёлын төвийн цахим хаягт тогтмол байршуулан иргэдэд хүргэн ажиллаж байна	50%
13	3.13 Спорт, урлагаар аймаг, улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлж, удаа дараа амжилт гаргасан иргэд, хүүхэд багачуудыг “Урамшуулах бодлого”-ыг хэрэгжүүлнэ.	Бид Сэлэнгийн үр сад хүүхдийн наадамд амжилттай оролцсон хүүхэд багачуудыг Ерөө суманд үйл ажиллагаа явуулдаг 1 ААНэгжээс 0,5 сая төгрөг, Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж буй Үндэсний уран хатгамалчдын 4-р уралдаанд сумаа төлөөлөн оролцсон Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, ахмад багш П.Гантуяад ЗДТГ, Соёлын төвөөс 1,0 сая төгрөг, Жавхлант суманд болсон "МОНГОЛ ХҮҮХЭД-МОНГОЛ БАХАРХАЛ" Ерөө бүсийн хүүхдийн язгуур урлагийн наадамд оролцсон хүүхдүүдийн замын зардалд Соёлын төвөөс 0,250 сая төгрөг, Соёл Урлагийн их сургуулийн Бүжгийн Урлагийн сургуулиас зохион байгуулсан МУАЖ Дунжаагийн Нанжидын нэрэмжит Биелгээ, ардын бүжгийн олон улсын уралдаанд Бугант тосгоноос оролцогч СББӨ-ийг өвлөн уламжлагч Төмөрбаатарын Цэцэгээ 0,5 сая төгрөг, ХБИргэдийн аймгийн аварга шалгаруулах спорт, урлагийн наадамд Ерөө сум, орон нутгаа төлөөлөн оролцох тамирчдад 1,8 сая төгрөгийн дэмжлэгийг тус үзүүлж хамтарч ажилласан.	100%
14	3.14 Суманд Соёл урлагийн байгууллага үүсэж хөгжсөний “Түүхт 60 жилийн ой”-г сумандаа тэмдэглэн өнгөрүүлэхэд дэмжлэг тусалцааг үзүүлж, хамтарч ажиллана.	2021 онд Ерөө суманд Соёлын төв байгуулагдсаны 60 жилийн ойн ажлын хүрээнд байгууллагын гадна талыг сэргээн засварлаж, өнгө үзэмжийг сайжруулахаар Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 30,0 сая төгрөгийн их засварын ажил хийгдсэн. Соёл урлагийн салбарт амжилттай ажилласан албан хаагч, иргэдийг төрийн дээд шагнал болон салбарын шагналд уламжилсан.	30%
15	3.15 “Шинэ давлагаа Ерөөгийн хөгжилд” спортын наадмыг жил бүр уламжлал зохион байгуулна.		0%
16	3.16 Спортын төрлөөр үйл ажиллагаа явуулж буй салбар зөвлөл, клуб, төрийн бус байгууллагын ажиллагааг дэмжин хамтран ажиллах.	Ерөө сумын сурын холбооноос санаачлан зохион байгуулсан Хойд бүсийн мөсөн сурын улсын аварга шалгаруулах тэмцээнийг дэмжиж 10,0 сая төгрөг, Чөлөөт бөхийн өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах болон хүүхдийн сумо бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг сумандаа зохион байгуулахад 10,0 сая төгрөг, Үндэсний бөхийн цуврал барилдаан зохион байгуулахад 4,0 сая төгрөг, Хоккейн спортыг дэмжиж 8,0 сая төгрөг, ХБИргэдийн холбоо Аймгийн аварга шалгаруулах спорт, урлагийн наадамд оролцоход 1,8 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн. Үндэсний наадгай болох “ Шагайн харваа”-г хөгжүүлэх өвлүүлэх зорилгоор өдөр бүр тогтмол хичээллүүлж байна.	100%
17	3.17 Малчин өрхүүдэд соёл урлаг, спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулна.	2023 онд малчдад соёлын явуулын үйлчилгээг 3 удаа хүргэж 691 иргэнийг хамрууллаа.	100%
18	3.18 Сумандаа бус, аймаг, улсын чанартай тэмцээнд уралдаан зохион байгуулах.	УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР: 2023 онд бүсийн чанартай 2, сумын хэмжээнд 3 нийт 5 удаагийн уралдаан наадмууд зохион байгуулан явагдлаа. Үүнд: 1. 2023 оны 01 дүгээр сарын 11 нд Ерөө бүсийн сумд болох Ерөө, Бугант, Хүдэр, Дулаанхаан, Жавхлант зэрэг сумдын дунд бүсийн “Багш нарын урлагийн наадам”-ын 1-р шатны шалгаруулалт зохион явагдлаа. Уг наадамд 70 гаруй хүн оролцлоо. Үзэгч 118. 2. 2024 онд тохиох Ерөө сумын 100 жилийн ойг угтсан ажлын хүрээнд сумын ЗДТГ, Соёлын төвөөс хамтран 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Засаг даргын нэрэмжит “БИД ЕРӨӨ НУТГИЙНХАН” урлагийн наадам зохион явууллаа. Уг наадамд ЗДТГ, ЕБСургууль, 1 дүгээр Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Шеф хамт олон /Соёлын төв, ХААН банк, Төрийн банк, ДСЦШСүлжээ ХХК, ЦДҮСүлжээ ТӨК, Гялс төгрөг ХЗХ/ , Ахмадууд, 1,2 дугаар баг зэрэг 8 байгууллага, ААН, багийн иргэд 7 төрлөөр авъяас чадвараа сорин	100%

		<p>өрсөлдлөө./205 гаруй хүн/. Үзэгчид 156 Шагналын зардалд нийт 1,536,200 төгрөг зарцуулсан. 3. 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Сэлэнгэ аймгийн Жавхлант суманд аймаг, суманд "МОНГОЛ ХҮҮХЭД-МОНГОЛ БАХАРХАЛ" Ерөө бүсийн хүүхдийн язгуур урлагийн наадам амжилттай зохион байгуулагдлаа. Уг наадамд Ерөө сумаас 3 хамтлагийн 49 хүүхэд 3 насны ангилалаар 19 төрөлд оролцсоноос: нийт 46 алт, 29 мөнгө, 21 хүрэл, хамтлагаараа 4 цом, Шилдэг сумаар Ерөө сум шалгаран "ШИЛЖИН ЯВАХ ЦОМ"-ЫН ЭЗЭН БОЛЛОО. 4. 2023.11.29, 2023.12.01-ны өдрүүдэд Т.Бямбаагийн нэрэмжит Ерөө ЕБС-ийн сурагчдын "ХҮҮХДИЙН УРЛАГИЙН НААДАМ" зохион байгуулагдлаа. Уг наадамд 1-12 дугаар ангийн 880 хүүхэд оролцлоо. Үзэгч 329. 5. 2023.11.29, 12 сарын 01- ны өдрүүдэд Т.Бямбаагийн нэрэмжит ЕБС-ийн Хүүхдийн урлагийн наадам амжилттай болж өнгөрлөө. Нийт 880 хүүхэд оролцож, үзэгчид 329 хүн СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР: Аймгийн аварга шалгаруулах Сумо бөхийн тэмцээн Ерөө суманд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд 16 сум, 2 тосгоны 300 гаруй тамирчид хүч чадлаа үзэн өрсөлдөж аваргуудаа тодрууллаа. Ерөө бүсийн идэрчүүдийн аварга шалгаруулах волейболын тэмцээн 2023 оны 02-р сарын 26-ны өдрүүдэд Ерөө Спорт Цогцолбор, ЕБС-н зааланд зохион байгуулагдаж эрэгтэй 6 баг эмэгтэй 6 багийн 100 гаруй тамирчид ур чадвар авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Ерөө бүсийн Идэрчүүдийн аварга шалгаруулах 5х5, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн 2023 оны 03 сарын 27 ны өдөр амжилттай болж өнгөрлөө Т.Бямбаагийн нэрэмжит Ерөө ЕБС, Ерөө Сумын Спорт Цогцолбороос Идэрчүүдийн Дэлхийн аваргын хүрэл медальт Азийн аваргын мөнгөн медальт Дэлхийн залуучуудын аваргын шагналт тавдугаар байрт Монгол улсын хошой аварга ОУХМ Ганболдын Мөнхцэцэгийн нэрэмжит тэмцээн нийт 13 жингийн 74 сурагч оролцож амжилттай болж өндөрлөлөө.</p>	
1.4 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН БОДЛОГО. Нэг өрх – Нэг ажлын байр			
1	4.1 Жил бүр ажилгүй иргэдийн судалгааг үндэслэн орон нутгийн бүтээн байгуулалтын ажлын эрэлт хэрэгцээнд тулгуурлан мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлнэ	<p>Суманд үйл ажиллагаа эрхэлдэг уул уурхайн БТЕГ ХХК, Инфинити спейс ХХК, Хандгайт гол ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдэд шаардлагатай ажлын байранд нийцүүлэн холбогдох мэргэжлийн сургалтын байгууллагуудад иргэдийг сургахаар холбон зуучилж ажилласан. Үүний үр дүнд өөрийн зардлаар 8 иргэн Дархан-Уул аймгийн сургалтын төвүүдэд уул, уурхайн мэргэжлээр суралцаж мэргэжилтэй боловсон хүчнээр бэлтгэгдэн ажлын байраар хангагдсан. Хандгайт гол ХХКомпанийн дэмжлэгтэйгээр хүнсний технологич мэргэжлээр Техник, технологийн дээд сургуульд 1 иргэний төлбөрийг 100% даан сургаж байна. Мөн ЕБСургуулиа төгссөн 3 суралцагчийг Дархан-Уул аймгийн Политехникийн коллежтой хамтын ажиллагааны хүрээнд автын засварчин, гагнуурчин мэргэжлээр тус тус суралцуулж байна. Тайлант хугацаанд уул уурхайн өргөн мэргэжил эзэмшүүлэх богино хугацааны сургалтыг орон нутагтаа 2 удаа зохион байгуулахаар сургалтын төвүүдтэй хамтран ажиллахаар нийтэд зар түгээж ажилласан боловч анги бүрдээгүй шалтгаанаар тус сургалтууд цуцлагдсан. /анги дүүргэлт 15, төлбөр 400,0₮/</p>	70%
2	4.2 Сумын хэмжээнд байгаа мэргэжилтэй боловсон хүчнийг ажлын байранд зуучилж, ажилтай, орлоготой болгох зорилгоор "Нэг өрх–Нэг ажлын байр" хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилгүйдлийг багасгаж, өрхийн үйлдвэрлэгчдийг дэмжиж ажиллана.	<p>Уул уурхайн салбар болон газар тариалангийн салбарт сумын иргэдээс давхардсан тоогоор 105 иргэн ажил горилочгийн анкет бөглөж 84 иргэн байнгын ажлын байранд, нийтийг хамарсан болон мод тарих ажилд 15 иргэн зуучлуулан ажилласан байна. Мөн уул уурхай, газар тариалангийн 6 аж ахуй нэгж, төр төсвийн 7 байгууллагат 89 иргэн шинэ ажлын байртай болсон байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон Хоршоо хөгжүүлэх сангаас 9 иргэнд 85.0 сая төгрөгийн санхүүжилт олгож 17 байнгын ажлын байр бий болсон.</p>	100%
3	4.3 Бүтээн байгуулалтын ажил, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн хөдөлмөр эрхлэлтийг	<p>2023-2024 онд хэрэгжих төсөл хөтөлбөрүүдээс суманд ирсэн квотын дагуу иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 2, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих хөтөлбөрт 2, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих</p>	100%

	бодлогоор дэмжиж, шинэ ажлын байрыг бий болгохын зэрэгцээ ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, малчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлж ажиллана.	хөтөлбөрт 2, Малжуулах хөтөлбөрт 1 иргэний төслийг тус тус хүлээн авч хүлээн авсан бөгөөд үүнээс малжуулах хөтөлбөрт 1-р багийн иргэн Ц.Хишигтогтох 5 сая, Иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 2-р иргэн М.Отгонжаргалын “Тансаг амт” төсөл шалгарч хүүгүй, барьцаагүй, 3 жилийн хугацаатай 10 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг тус тус авч үйл ажиллагаагаа өргөтгөн тоног төхөөрөмжөө сайжрууллаа.	
4	4.4 Амьжиргааны баталгаажих түшингээс доогуур орлоготой зорилтот бүлгийн өрхүүдийг “Малжуулах, туслах аж ахуй эрхлэх” нөхцөл боломжоор хангаж амьжиргааны эх үүсвэртэй болгоно.	2023 онд малжуулахын санхүүгийн дэмжлэгт 1-р багийн иргэн Ц. Хишигтогтохын өрх 5.000.0 төгрөгийн хүүгүй, 3 жилийн хугацаатай эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдаж 2 үнээ, 2 тугал, 3 бяруу худалдан авлаа. Мөн тухайн өрхийн 2 гишүүнийг “Зүүнхараа политехник коллеж”-д болсон мал маллах болон малын ашиг шимийг хэрхэн үр дүнтэй ашигтай боловсруулах сургалтад хамруулсан.	100%
5	4.5 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, оролцоог хангаж “Нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаанд хамруулж”, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ	83 ахмад настан ахмадын зориулалттай амралт, сувилал болон рашаан сувилалд хэвтэн эмчлүүлж нийгмийн халамжийн сангаас нийт 12.683.0 мян төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн байна.	100%
6	4.6 Сумын хэмжээний төр, төсвийн байгууллагууд, үйлчилгээний газруудад ахмад настан, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дараалал харгалзахгүйгээр үйлчлэх “Үйлчилгээний соёл”-ыг хэвшүүлнэ.	Ерөө суманд үйл ажиллагаа явуулдаг төр төсвийн 5, нийтийн зориулалттай үйлчилгээний 6 байгууллагуудын дарга эрхлэгч нарт сумын Засаг даргын албан бичгээр ахмад настан, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дараалал харгалзахгүйгээр үйлчлэх, үйлчилгээний соёлыг хэвшүүлэн ажиллахыг чиглэл болгон ажилласан.	100%
7	4.7 Шинэ залуу гэр бүл болон сумын хэмжээнд байгаа зорилтот бүлгийн иргэд, төр төсвийн байгууллагын ажилтнуудыг орон сууцжуулах зорилгоор 20-оос доошгүй өрхийг зохих журмын дагуу “Орон сууцжуулах бодлогыг хэрэгжүүлэн ажиллана.	2023 оны Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар “Ерөө цагдаагийн албан хаагчийн байр” төсөл арга хэмжээний ажилд 39,5 сая төгрөгөөр “Халиун уул” ХХК шалгарч 5 давхар орон сууцны 5 давхарт 45 м2 талбай бүхий 2 өрөө орон сууцыг хүлээлгэн өгсөн. Ойн сан гэрээгээр эзэмшигч Мандал Оргил ХХК, Бугант номин ХХК-аас өндөр настан Я.Марусяд 100 ширхэг палк, 3 төрийн албан хаагчийн орон сууцны барилгын ажилд зориулж 80 ширхэг палкийг үнэ төлбөргүй олгосон. Мөн ахуйн түймэрт байшин нь шатсан 8 өрхөд сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс тус бүрт 1000.0 сая төгрөг олгосон.	100%
8	4.8 “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагаанд дэмжлэг тусалцааг үзүүлж, сум, тосгонд “Түр хамгаалах байр”-ыг байгуулна.	ИТХурлын 2023 оны 115 дугаартай тогтоолоор Түр хамгаалах байр барихад 100,000,000 төгрөг зарцуулахаар баталсан. Түр хамгаалах байрны шаардлагад цагдаагийн хамгаалалтад байна гэсний дагуу Ерөөгийн цагдаагийн кабоны хашаанд барихаар зураг төсөв хийлгэсэн боловч Архитектур төлөвлөлтийн А даалгавар гараагүй. /газрын захирамжтай холбоотой/ Иймд 2024 онд цагдаагийн кабоны 2 өрөөг түр хамгаалах өрөөгөөр засварлан тохижуулахаар төлөвлөсөн.	50%
9	4.9 Хүүхэд, гэр бүлд чиглэсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулж, эцэг эхийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд зохион байгуулна.	ИТХ-аар 2023 онд Хүүхдэд чиглэсэн 7 төрлийн ажил, арга хэмжээнд 1,390,601,000 төгрөг зарцуулахаар баталсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 33 ажил, арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор 4572 хүүхэд хамруулж 1,364,269,000 төгрөгийг зарцуулсан байна. Хүүхдийн хүмүүжил төлөвшилд анхаарах асуудлын хүрээнд: <ul style="list-style-type: none"> • “Дэлхийн зөн” ОУБ-аас 25 сурагчид “Өсвөр нас” • ГБХЗХГазраас 125 сурагчид “Хүүхдэд амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх модуль сургалт”, • ЗДТГазраас зохион байгуулсан “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга”, “Хүүхэд хамгаалал” сэдэвт сургалтад 264 эцэг, эх • Дэлхийн зөн ОУБ-аас зохион байгуулсан “Би бол цор ганц харин харагдах байдал минь ондоо” эцэг эх асран хамгаалагчдын 2 дахь удаагийн сургалтад 2 эцэг эх 2 хүүхэд, • “Дэлхий Зөн” ОУБ-аас “ААВ” сургалтад 30 аав • Нийтийн далд ухамсрыг сэргээх “Баярлалаа” төвөөс “Хүний хөгжил ба аз жаргал” сургалтад 113 эцэг эх • Сэлэнгэ аймгийн ГБХЗХГазраас “Гэр бүлийн харилцаа хандлага” сэдэвт сургалтад 69 эцэг эх 	100%

		нийт 8 сургалтад 630 эцэг эх, хүүхдүүдийг хамруулсан. Нөлөөллийн 48 арга хэмжээ зохион байгуулж 7473 иргэнийг хамруулсан.	
10	4.10 “Тэргүүний өрхийн аж ахуй”, “Бүтээлч айл өрх”, “Соёлч өрх”-ийг жил бүр шалгаруулан туршлагыг түгээн дэлгэрүүлж, бусад аймаг, сум, нийслэл, дүүргийн туршлага судлуулах ажлыг зохион байгуулна.	Ерөө сум үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойн баярыг угтан сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/112 тоот захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дунд тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх болзолт уралдааныг зарлаж Шилдэг өрхөөр Ц.Төмөрбаатар, Шилдэг аж ахуйн нэгжээр “Одногийн гуанз” шалгарлаа.	100%
11	4.11 Өрхийн амьжиргааны түвшнийг тогтоох судалгаанд үндэслэн нийгмийн “Халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн өрхийн амьжиргааг дэмжиж” ажиллана.	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/36 дугаартай тушаал “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал” судалгааг зохион байгуулж сумын 1, 2-р багийн 57, 3-р багийн 31 өрхөөр 5 сарын 30-аас 6 сарын 2-ны хооронд гэрээр айлчлан судалгааг авч РМТ2023 программд илгээсэн. Энэ онд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 4 өрхийн 7 том хүн, 16 хүүхэд хамрагдаж 2.880.000 төгрөгийн хүнс тэжээлийн дэмжлэг авсан байна.	100%
12	4.12 Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, сайн дурын даатгалд хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, малчдыг 60% хамруулна.	Жилийн эцсийн байдлаар сайн дурын даатгалд нийт 162 даатгуулагч хамрагдсанаас малчин 75, ХХЭ болон ажил хөдөлмөр эрхлээгүй 86, оюутан 1 даатгуулагч хамрагдсан байна. Шинээр 62 даатгуулагч хамрагдсанаас малчин 28, хувиараа хөдөлмөр эрхлэгч буюу ажил хөдөлмөр эрхлээгүй 34 даатгуулагч хамрагдсан байна.	70%
13	4.13 Эрүүл мэндийн даатгалд хамрагдагсдын хувийг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхэлдэггүй иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчдыг хамруулна.	2023 онд ЭМ-ийн даатгалд нийт 182 даатгуулагч шимтгэл төлж хамрагдсанаас малчин 61, ажил хөдөлмөр эрхлээгүй 95, оюутан 26 даатгуулагч хамрагдсан. -Малчин 61/ 33,5% - Тодорхой ажил эрхлээгүй иргэд 95/ 52,4% - Оюутан 26/ 14,1%	70%
14	4.14 Гадаад харилцааг хөгжүүлэх.	<ul style="list-style-type: none"> Сургуулийн захирал нар Япон улсын Нагоя хотын их сургуулийн дэргэдэх ахлах сургуулийн байгалийн шинжлэх ухааны тусгай хөтөлбөрт оролцон туршлага судалсан байна. 2023 оны 02 дугаар сарын 28-наас 03 дугаар сарын 04-ны өдрүүдэд ОХУ-ын Буриядын Зэдийн районы Соёл урлагийн газрын даргатай байгуулсан гэрээний дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө, Жавхлант, Алтанбулаг, Зүүнбүрэн, Баруунбүрэн сумдын Соёлын төв, Хөтөл Соёлын ордны уран бүтээлчидтэй хамтарсан 65 хүний бүрэлдэхүүнтэй “МОНГОЛ ТҮМНИЙ ДУУЛАЛ” тоглолтоо Зэдийн район, Дэтөр, Дээд Учотээ, Алцаг зэрэг тосгонуудад тоглоод ирлээ. Ерөө сумаас 8 хүүхэд, 4 том хүн оролцлоо. 2023 оны 10 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд Ерөө бүсийн Соёлын ажилтнууд хөрш зэргэлдээ орны аялал жуулчлал, музейн дэглэлт, үзвэр үйлчилгээ- шоу менежмент, үйлдвэржилтийн түүхэн технологийн соёлтой танилцах ажил хийгдсэн. БНСУЛсын Инчэон хотод зохион байгуулагдсан “Гастроэнтерологийн 7 хоног” олон улсын эмч нар хуралд Ерөө сумын ЭМТ-ийн дарга Д.Золжаргал оролцсон. 	100%
15	4.15 Иргэдийн оролцоо Ерөөгийн хөгжилд иргэдээ соён гэгээрүүлэх хөтөлбөр гаргах. Жилдээ нэг удаа зохион байгуулж хэрэгжүүлнэ.	<ul style="list-style-type: none"> Сумын Засаг даргын А/276 “Өвөл цагийн соёл хүмүүжлийн ажил зохион байгуулах тухай” захирамжаар сумын төр, төсвийн байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн дунд спортын 5 төрөлт тэмцээнийг зохион байгуулан 130 гаруй иргэнийг хамруулж 3000000 (гурван сая) төгрөгийг зарцуулсан. Сумын Засаг даргын А/290, 291 “Малчдын туршлага судлах, уулзалт арга хэмжээг зохион байгуулах тухай” захирамжуудаар Мал эмнэлэг, үржлийн албаны 100 жилийн ой, Ерөө сум үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойг угтан малчдын дунд 3 төрөлт спортын арга хэмжээг амжилттай зохион байгуулан 1500000 (нэг сая таван зуун мянган) төгрөгийн зарцууллаа. Уг арга хэмжээнд 8 хэсгийн 100 гаруй малчид хамрагдсан бөгөөд малчдын өрхийн үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Сургагч багш Я.Ариунтөгс “Ажлын байрны харилцаа” сэдвээр 2023 оны 03 дугаар сарын 13-14-ний өдөр Засаг даргын Тамгын газрын 22 албан хаагч, Ерөнхий боловсролын сургуулийн 25 багш, ажилчдад сургалт зохион байгууллаа. Сургалтын төлбөрт Засаг даргын нөөц хөрөнгөөс 571,200 төгрөгийг 	100%

		<p>зарцуулсан.</p> <ul style="list-style-type: none"> • Ерөө сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, “Тунараа хүний хөгжил төв”-ийн захирал, Энерги ухамсар судлалын доктор П.Тунараатай хамтран 2023 оны 03 дугаар сарын 14-15-ны өдөр "Стресс менежмент, өөртөө итгэх итгэл", “Хүний хөгжил ба аз жаргал” сэдвээр сургалт зохион байгууллаа. Тус сургалтад Засаг даргын Тамгын газрын 14 албан хаагч, 185 иргэн хамрагдаж, Засаг даргын нөөц хөрөнгөөс 540000 төгрөгийг зарцууллаа. • Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар, “Иргэдийн шударга шүүх” ТББ, Ерөө сумын Засаг даргын Тамгын газар хамтран Анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ойг угтан “Бүх нийтийн үндсэн хуулийн мэдлэгийг дээшлүүлэх” сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр зохион байгууллаа. Тус сургалтад төр, төсвийн 4 албан хаагч, 80 иргэн оролцсон байна. • Монголын үг урлаачдын нэгдсэн нийгэмлэгийн туузын дарга лектор Г.Бандицэрэн /Chila lector/ 2023.09.15-ний өдөр Бугант тосгоны Захирагчийн Алба , Хамтарсан багийн хүсэлтийг хүлээн авч Бугант тосгонд 3 удаагийн лекцийн үйл ажиллагааг зохион байгуулж нийт 450 гаруй иргэд ,хүүхэд залуучуудыг хамруулсан өргөн үйл ажиллагаа боллоо. 6 ААНэгж байгууллагын дэмжлэгтэйгээр 2.0 сая төгрөг 	
16	4.16 Эмэгтэйчүүдийн холбооны байртай болох		0%

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО. ХӨГЖИЛД ТЭМҮҮЛСЭН ЕРӨӨЧҮҮД

1	2.1 Бугант тосгоныг сумын төвтэй “Хатуу хучилттай замаар холбох” ажлыг холбогдох шатанд уламжилж шийдвэрлүүлнэ.	Ерөө сумын төвөөс Бугант чиглэлийн хатуу хучилттай 27,8 км авто замын зураг төсвийн ажлыг “Эс Ар Пи инженер консалтинг Монголиа” ХХК гүйцэтгэж, зураг төсвийн ажлын санхүүжилтэд 50,0 сая төгрөгийг Баянгол сангаас олгосон. Тус ажлын эхний үе шатыг гүйцэтгэх 5945,4 сая төгрөгийн төсөв 2024 оны улсын төсөвт батлагдсан.	70%
2	2.2 Сумын төвийг “4 зам-Хүдэр” чиглэлийн хатуу хучилттай замтай холбох ажлыг гүйцэтгүүлнэ.	A0401 дугаар замаас Хүдэр сум хүртэлх 98 км замын 45 дахь км-ээс Ерөө сум хүртэлх 3,7 км хатуу хучилттай авто замын ажлыг Улсын төсвийн 2375.0 сая төгрөгийн хөрөнгөөр “Эсперс зам” ХХК шалгарч, ажлыг 100 хувь хийж гүйцэтгэн хүлээлгэж өгсөн. /2021 онд/	100%
3	2.3 Ерөө сумын 1-р багийн Энхталын зарим малчин өрх, 2-р багийн Хужрын хаяа хэсгийн айл өрхүүдийг “Цахилгаан, эрчим хүчээр хангах” ажлыг гүйцэтгэнэ.	<ul style="list-style-type: none"> • Ерөө сумын 2-р багийн Хужирын хаяаны малчин, мал бүхий айл өрхийг “Цахилгаан эрчим хүчээр хангах” ажлыг Жи Ар Капитал Ложистик ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд (40,0 сая төгрөг) гүйцэтгэснээр 8 өрх цахилгаанаар бүрэн хангагдсан. • Тавин багийн “Шаазгайт” хэсгийн 7-8 малчин өрхүүдийг төвлөрсөн цахилгаан шугамд холбох ажлын хүрээнд малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр трансформатор худалдан авсан. “ДСЦТС” ХК-аас техникийн нөхцөл авахаар холбогдох материалыг бүрдүүлэн хүргүүлсэн. • Ерөө сумын 1-р багийн хөдөөгийн Энхтал хэсэгт баригдсан “Мал үржлийн төв”-ийг цахилгааны төвлөрсөн шугамд холбох Трансформатор суурилуулах 19,6 сая төгрөгийн өртөг бүхий ажлын гэрээг “Дархан хэрлэн” ХХК-тай байгуулсан. “ДСЦТС” ХК-аас техникийн нөхцөлийн авсан. Ажил эхлүүлэх зөвшөөрөл хүлээгдэж байна. 	70%
4	2.4 Ойн мэргэжлийн байгууллагуудыг түшиглэн “Мод боловсруулах эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр” -ийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор төсөл хөтөлбөрт хамруулна.	<p>Ерөө сумын ойн мэргэжлийн байгууллагуудын нэг Бугант нандин ХХК өөрийн хөрөнгө оруулалтаар Мод боловсруулах эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг 2022 онд ашиглалтад оруулан иж бүрэн тавилгатай Монгол гэрээс, сандал ширээ, буйдан , гэр ахуйн болон оффис тавилга зэрэг 30-50 нэр төрлийн эцсийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн хүссэн хэмжээ загварт нийцүүлэн гаргаж олны талархлыг хүлээсээр байна. Үйлдвэрлэлийн баазаа чанарын шаардлага хангасан техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, 50-80 хүнийг байнгын ажлын байраар ханган ажиллаж байна.</p> <p>Мөн гэрийн мод үйлдвэрлэлийг /унь, шал, тооно/ ойн мэргэжлийн 2 ААНэгж, 4 иргэн эрхэлж, жилдээ 1000 гэрийн унь, 50 гэрийн тооно болон шалыг зах зээлд нийлүүлж байна.</p>	90%

5	2.5 Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэн “Шинэ суурьшлын бүсэд буусан айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр хангах” ажлыг холбогдох шатанд уламжилж хэрэгжүүлнэ.	Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Шинээр гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон газрын цахилгааны зураг төсөв хийлгэх” 20000,0 мянган төгрөгийн өртөгтэй ажлын дэвсгэр зургийг “Дархан билгүүн баялаг” ХХК хийж, техникийн нөхцөлийг бэлэн болсон байна.	50%
6	2.6 Сум, тосгоны төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбай дахь замуудыг үе шаттайгаар “Хатуу хучилттай зам” болгоно.	Бугант тосгонд 235 сая төгрөгийн өртөгтэй 1,2км хайрган хучилттай автозам, 500 сая төгрөгийн өртөгтэй 1,2км замыг асфальтаар хучиж, 195,1 сая төгрөгийн өртөгтэй 96 ширхэг гэрэлтүүлэг хийгдсэн. Ерөө суманд 1.040.3 сая төгрөгийн өртгөөр 1.9 км замыг асфальтаар хучиж, 2.9 км дугуйн замыг шинээр барьж, 140.0 сая төгрөгийн өртгөөр Сургуулийн авто зогсоол, ЭМТ-өөс гангын зам хүртэлх 430м хайрган хучилттай авто замыг шинээр барьж, цэцэрлэгийн хуучин авто зогсоолыг засварласан.	100%
7	2.7 Шинэ суурьшлын бүсэд “Хаус” хороолол барьж байгуулах ажлыг аж ахуйн нэгж, иргэдийн оролцоотойгоор эхлүүлнэ.		0%
8	2.8 Сум, тосгоны гудамж талбайн гэрэлтүүлгийг засварлан, тодорхой хэсгүүдэд нэмж “Шинэ гэрэлтүүлэг” тавина.	2023 онд Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар “Бугант тосгонд гэрэлтүүлэг нэмэгдүүлэх” ажлын тендерт “Арвилах” ХХК шалгарч 195,1 сая төгрөгөөр Бугант тосгоны Чулуут, Өлөнтийн хэсэгт 96 ширхэг гэрэлтүүлгийг 100 хувь гүйцэтгэсэн. Сумын төв талбайн 20 ширхэг гэрлийг шинэчлэх ажлыг 6,0 сая төгрөгөөр Төгөлдөр Ерөө ХХК гүйцэтгэсэн.	100%
9	2.9 Ерөө суманд “Худалдааны төв” -ийг барьж ашиглалтад оруулан ажлын байрыг нэмэгдүүлнэ.	Ерөө сумын худалдааны гудамжны тохижилтын ажлыг аймгийн ОНХС-ын хөрөнгө оруулалтаар “Дэв солт ” ХХК 115,0 сая төгрөгөөр гэрээ байгуулан ажлаа эхлүүлсэн.	30%
10	2.10 Инженерийн байгууламж, шугам сүлжээг байгуулж аж ахуйн нэгж, байгууллагууд болон айл өрхүүдийг холбох ажлыг эхлүүлнэ	Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 06 дугаар сарын 01 өдрийн 161 дүгээр тогтоол “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээнд 19 аймгийн 59 сумын төвд Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлэн хэрэгжүүлнэ гэж заасан. Сэлэнгэ аймгаас Ерөө сум сонгогдож “Дөрвөн гүн” ХХК-иар сумын инженерийн дэд бүтцийн хангамжийн зураг төсвийг хийлгэж байна.	30%
11	2.11 Сумын төвийн урд жижиг гүүрнээс “Гэрэлтхайлааст /тасаг/ хүртэлх зам” -ыг сайжруулан засварлана.	2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын саналд эрэмбэлэгдэн “Ихэр мөнх”ХХК -иар төсвийг хийлгэж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулахаар бэлтгэсэн.	70%
12	2.12 Бугант тосгоны “5 давхар байр” -нуудын дээврийг шинэчлэх, засварлах, хуучин захирагчийн албаны байрны их засварын ажлыг тус тус шийдвэрлэн ажиллана.	2022 оны Орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Бугант тосгоны нийтийн орон сууцнуудын дээврийг засварлах” ажилд 132448.0 мянган төгрөгийн өртөгтэйгөөр “Уран төмөр хэлхээ” ХХК шалгарч, ажлыг 100 хувь гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.	100%
13	2.13 Сум, тосгоны хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нэгдсэн “Камержуулалт” -ын ажлыг үе шаттайгаар гүйцэтгэнэ	Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар Ерөө ЕБС-ийн дотор 64 камер суурилуулах ажилд 20.0 сая төгрөгөөр Магнай жонон ХХК 100% гүйцэтгэсэн. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс “Сумын төвийн камержуулалт”-ын урсгал засварын ажилд 2.0 сая төгрөг зарцуулж “Магнай жонон” ХХК ажлыг 100% гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Номин од ХХК Бугант тосгоны ЕБСургуулийн 3 камерийг шинэчилсэн / 0.3 сая₮/.	100%
14	2.14 Сум, тосгоны тоглоомын талбайг стандартын шаардлага хангасан хүүхдийн тоглоомоор баяжуулан, хуучин талбайнуудыг засаж шинэчлэн, шинээр байгуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.	Орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 59.9 сая төгрөгийн өртөгтэй “Бугант тосгоны ходоодын хэсэгт хүүхдийн тоглоомын талбай барих” ажилд “Ачлалт төмөр хэлхээ” ХХК шалгарч, ажлыг 100 хувь гүйцэтгэсэн. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд “Инфинити спэйс” ХХК Тавин Буурагчин багийн хүүхдийн тоглоомын талбайг 3,5 сая төгрөгөөр засаж өнгө будгийг сэргээсэн.	100%
15	2.15 Бугант тосгоны хуучин үерийн далангуудыг сэргээн засварлах, шинэчлэх сумын төвд Ерөө голын эрэг дагуух үерийн даланг байгуулах ажлуудыг шат дараатайгаар хийж гүйцэтгэнэ.	Аймгийн Замын сангийн хөрөнгө оруулалтаар Бугант тосгоны зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг хийх ажлын тендерт 235,000,000 төгрөгөөр “Сэлэнгэ есөн эрдэнэ” ХХК шалгарч үерийн ган хоолой 3 ширхгийг суурилуулж хүлээлгэн өгсөн.	100%

16	2.16 Сум , тосгоны иргэдийг стандартын шаардлага хангасан гүний усаар хангах зорилгоор шинээр жилдээ 1-2 “гүний худаг” гаргаж, ашиглалтад оруулна.	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 08-р сарын 16-ны өдрийн 102 тоот тогтоолоор төсвийн хөрөнгө оруулалтын 125,0 сая төгрөгийн өртгөөр хийгдэх “Ухаалаг худаг/ Усны төв/”-ийн тендерт “Баялаг говь”ХХК худалдан авах ажиллагааны онцгой журмаар шууд гэрээ байгуулах нөхцөлөөр гэрээ хийгдэн ажлыг гүйцэтгэж байна. Орон нутгийн хөгжлийн сангийн 20,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бодь хараа ХХК Ерөө сумын 1-р багийн нутаг Хандгайтад 120м гүнтэй хүний худаг гаргасан.	90%
17	2.17 Бугант тосгоны Төв уурын зуухыг шинэчлэх, дулааны шугам хоолойг засварлах, өргөтгөл хийх ажлыг хийж гүйцэтгэнэ	Бугант тосгоны Төв уурын зуухыг шинэчлэх, дулааны шугам хоолойг засварлах, өргөтгөл хийх ажлыг “Буга- Өндөр ХХК” өөрийн хөрөнгөөр (479.3 сая төгрөг) хийж гүйцэтгэсэн байна. /2022 онд/	100%
18	2.18 Бугант тосгоны орох, гарах хэсэгт байнгын постын байрыг шинээр барьж , явуулын пост, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	Сумын төв болон Бугант тосгонд ашиглагдах постын байрны зориулалттай 2 вагончик төсвийн 20,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар худалдан авч нийлүүлсэн. /2021 онд/ Бугант тосгоны цагдаагийн албан хаагчдад хяналтын постын зориулалтаар Засаг даргын нөөц хөрөнгөөс 3,5 сая төгрөгийн өртгөөр гэр авч ашиглаж байна.	100%
19	2.19 Сумын эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн ажлын зураг төсвийг гаргуулан , өргөтгөлийн барилгын ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.	Ерөө сумын Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн зураг төсвийг “Ноёдын Туурь” ХХК -иар 40.9 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн. Тус барилгын ажил 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлаар батлагдсан. /950,0 сая₮/ “Ерөө ЭМТ-ын цахилгааны монтажийг солих” ажилд 10.0 сая төгрөгийн өртөгтэйгөөр “Чухаг арвис ” ХХК шалгарч, 100% гүйцэтгэсэн.	100%
20	2.20 “Гудамж” төслийг хэрэгжүүлж, автозамын уулзваруудыг шинэчилж, сумын өнгө үзэмжийг сайжруулна.	Айл өрхийн хашааны өнгө үзэмжийг сайжруулах ажлын хүрээнд ойн мэргэжлийн 2 ААНэгжээс 1-р багийн 7 өрх, 2-р багийн 4 өрхөд 4м 400 ш, 2 м 3000 ш хашааны бэлдцийг зах зээлийн үнээс хямд үнээр нийлүүлсэн.	50%
21	2.21 “Дугуйн болон явган хүний замыг байгуулж” , автозамын зогсоолуудыг шинэчлэн сайжруулна.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 1900м замыг асфальтаар хучих, 2,9 км дугуйн замын тендерт 1.040.4 сая төгрөгөөр Сэлэнгэ АЗЗА компани шалгарч гүйцэтгэл 98 хувьтай байна. Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар Ерөө сургуульд авто зогсоол шинээр барих, цэцэрлэгийн авто зогсоолыг засварлах ажлын тендерт 140,0 сая төгрөгөөр “Сэлэнгэ Есөн эрдэнэ” компани шалгарч 100 хувь гүйцэтгэсэн.	100%
22	2.22 Сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, “Орчин үеийн шийдэл бүхий цэцэрлэгт хүрээлэнг” аж ахуйн нэгж , иргэдийн оролцоотойгоор шинэчилж байгуулна.	Мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаар ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлыг Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ 20,0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн. Мөн БТЕГол ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд Ерөө сум хүртэлх 3,7 км авто зам дагуу ногоон байгууламжийг хамгаалах хашаа барьж, мод тарьсан. /17,0 сая₮/ 2024 онд Аймгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар ногоон байгууламж нэмэгдүүлэх ажил хийхээр батлуулсан. /50,0 сая₮/	70%
23	2.23 “Наадмын талбайд засвар” оруулна.	Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар “Бугант тосгонд наадмын талбай шинээр барих ажлыг “Даян өгөөж” ХХК 276,9 сая төгрөгийн өртгөөр гүйцэтгэсэн.	90%
24	2.24 “Сэргээгдэх эрчим хүчний байгууламжийн шинээр байгуулах” үйл ажиллагааг дэмжиж , иргэн, аж ахуйн нэгжтэй хамтарч ажиллана.		0%
25	2.25 Бохир хуримтлуулах байгууламжийг шинээр барьж , “Бохирын машинтай болно”	Орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 57200,0 мянган төгрөгийн өртөгтэй “Бохирын машин” худалдан авах ажилд “УАЗ МЕГА” ХХК шалгарч, бохирын машиныг нийлүүлсэн. /2021 он/	100%
26	2.26 Хаягжуулалтын тухай хууль, Засгийн газрын 2019 оны гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмын дагуу Ерөө сумын	Монгол улсын Засгийн газрын 2019 оны “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах” 325-р журмын дагуу “Хаягийн мэдээллийн систем байгуулах төсөл, арга хэмжээг эрчимжүүлэх” ажлын хүрээнд сумын 2026 нэгж талбар, 1180 барилга, 239 гудамжны хаягжуулалтыг хийж гүйцэтгэн хаягийн нэгдсэн	100%

3039 нэгж талбарын “Шинэчилсэн хаягийг байршуулах” ажлыг зохион байгуулна.	мэдээллийн санд бүртгэлжүүлж, гудамж талбайд шинэчилсэн хаягийг суурилуулах ажлын бэлтгэлийг бүрэн хангасан.
---	--

ГУРАВ. ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСАГ ХӨГЖЛИЙН ТҮЛХҮҮР

1	3.1 Төрийн байгууллагын туслах аж ахуйн ажлын ачааллыг багасгах зорилгоор байгууллагуудын өмчид байгаа хөрөнгүүдийг “Төрийн өмчит орон нутгийн байгууллагуудад ашиглуулах” замаар хөрөнгийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлнэ.	Төрийн байгууллагын туслах аж ахуйн ачааллыг багасгах зорилгоор ЗДТГазарт бүртгэлтэй тусгай зориулалтын тээврийн хэрэгслүүд болон байгууламжийг Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ-т ашиглалтын гэрээгээр ашиглуулснаар эвдрэл гэмтлийг хариуцан, зориулалтын дагуу ашиглаж хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлж байна. Тус байгууллага багийн төвийн байранд үйл ажиллагаа эрхлэн, бохир соруулах, хог зөөвөрлөх, өргөгч, универсал трактор, гал командын машин зэрэг тусгай зориулалтын техник хэрэгслүүдийн бэлэн байдал, ашиглалтыг хариуцан, хог цэвэрлэх, тээвэрлэх, гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ, ногоон байгууламж услах болон бусад ажлуудыг хийн гүйцэтгэж байна.	100%
2	3.2 И-баримт, И-монголиа, QR коджуулалтын тусламжтайгаар татварт хамруулалт, татварын өрийн барагдуулалт, татварын үйлчилгээг цахимаар үзүүлэх, татварт хамрагдуулалтыг нэмэгдүүлэх, төлбөрийг цахимаар төлөх боломжуудын талаар “Иргэдэд мэдээ, мэдээллийг өгч” байнга хамтарч ажиллана	2023 онд Ерөө суманд худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 34 хуулийн этгээд, хувь хүний үйл ажиллагаанд хяналт тавьж, QR кодоор баримт олголт хангалтгүй байсан төлөгч нарт 1-3 удаагийн давтан шалгалт хийж, албан шаардлага хүргүүлж, уг зөрчлийн арилгасан. 2023.01.29-30-ны өдрүүдэд худалдаа үйлчилгээний газрын татварт хамрагдалт, баримт олголт ямар түвшинд байгааг илрүүлэх зорилгоор сумын Засаг даргын удирдамжаар ажлын хэсэг гарч чиглэл чиглэлээрээ хуулийн заавар зөвлөгөө өгч хамтран ажилласны дүнд 60 хувь хүнээс 16,130,099 төгрөгийн ХХОАТ-ын орлого төвлөрүүлж ажилласан. 2023 онд шинээр бүртгэвэл зохих ХХК-3, Нөхөрлөл-5, Төрийн сангийн нэгж-3, Холбоо /ТББ/-2 нийт 13 хуулийн этгээд, 15 хувь хүнийг бүгдийг нь татвар төлөгчөөр болон төрлийн бүртгэлд 100 хувь бүртгүүлж, татварын үйлчилгээг цахимаар авах бүрэн боломжтой болсон.Татварын үйлчилгээний цахимжуулалтын талаар сумын нийт татвар төлөгч нарт байнгын ажиллагаатай 5 цахим группээр болон биечлэн сургалт сурталчилгаа хийж, хуулийн зөвлөгөө, мэдээлэл тасралтгүй өгч ажилласан.	70%
3	3.3 Татвар төлөгчийн ирүүлсэн тайланг татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэлтэй тулган боловсруулалт хийж, зөрчилтэй тайланг засварлуулах, тайлангийн ирц хангуулан хөндлөнгийн мэдээллийн ашиглалтыг сайжруулах замаар “Татварын суурь” -ийг нэмэгдүүлнэ.	Татварын тайлангаа хугацаандаа ирүүлсэн байдал: <ul style="list-style-type: none"> • ААНОАТ 495 тайлангаас ирүүлсэн 493 85% • ХХОАТ 805 тайлангаас ирүүлсэн 720 89% • НӨАТ 29 тайлангаас ирүүлсэн 29 100% • ЦХ 465 тайлангаас ирүүлсэн 430 92% • Суутган 375 тайлангаас ирүүлсэн 316 84% • Ус бохирдуулсны төлбөр 13 тайлангаас 12 92% <p>Цахимаар хуваарилагдан ирсэн хүсэлтүүдийг шалгаж шийдвэрлэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Татварын тайлан хүлээж авах хүсэлт-415 • Засварласан тайланг хүлээн авах хүсэлт-25 • Тайлан залруулах хүсэлт-15 • Хоцорсон тайлан тушаах хүсэлт-42 • Санал гомдол-9 тус тус цахимаар ирснийг шалгуур хангасан тайлангуудыг шууд хүлээн авч, шалгуур хангаагүй зөрчилтэй тайланг засварлуулан хүлээн авч ажилласан. <p>8 татвар төлөгчтэй холбоотой хөндлөнгийн мэдээллийг холбогдох эх үүсвэрээс цуглуулан, Татварын удирдлагын нэгдсэн санд шивж мэдээллийг баяжуулж ажилласан.</p>	90%
4	3.4 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад тавих “Хяналтыг сайжруулж, иргэдэд ил тод нээлттэй болгоно” .	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 12 төсөл арга хэмжээнээс <ul style="list-style-type: none"> - 11 төрлийн ажил үйлчилгээг 1,284,2 сая төгрөгөөр 100% гүйцэтгэсэн. - 1 төрлийн ажил үйлчилгээг 184.5 сая төгрөгөөр 2 удаа зарласан боловч оролцогч байгүй, хэрэгжээгүй. Хяналтыг сайжруулж, иргэдэд ил тод нээлттэй болгох ажлын хүрээнд шилэн данс, tender.gov.mn 	90%

		сайт, ЗДТГазрын мэдээ болон бусад сайтаар хүргэж байна.	
5	3.5 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож иргэд, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.	<p>Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 08-р сарын 16-ны өдрийн 115 тоот тогтоолоор Төрийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 50 төрлийн ажил үйлчилгээг 6112.6 сая төгрөгийн өртөгтэйгээр хийгдэхээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган Монгол Улсын Сангийн яамаар батлуулан ажилласан.</p> <p>Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах ажлын хүрээнд худалдан авах төлөвлөгөөнд заасан бүх төсөл арга хэмжээг Tender.gov.mn цахим хуудсаар зарлан хэрэгжүүлж, Сэлэнгэ Барилга захиалагч ОНӨААТҮГазар ажил тус бүрд хяналт хийх ажлыг гүйцэтгэхийн зэрэгцээ сумын ИТХ-ын дэргэдэх хянан шалгах хорооноос 2023 оны Хөрөнгө оруулалтад 2 удаагийн хяналт шалгалт хийсэн.</p> <p>Мөн аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Барилгын байцаагч Гэрэлмаагаар ахлуулсан ажлын хэсэг, Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хэлтсийн Замын байцаагч Баярхүүгээр ахлуулсан ажлын хэсэг ирж шалгалт хийсэн.</p>	100%
6	3.6 Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	<p>Нийгмийн хариуцлагын хүрээнд 5 байгууллагаас 115.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ.</p> <ul style="list-style-type: none"> • БТЕГол ХХК сумын төв хүртэлх 3,7 км засмал зам дагуу ногоон байгууламжийг хамгаалах хашаа барьж мод тарих ажилд 17.0 сая төгрөг • Түм Их Эрхэд ХХК – Сумын төвд шинээр баригдаж буй хүлэмжийн паркийн 0,5 га газрыг хашаажуулах ажилд 8,0 сая төгрөг, Бугант тосгоны соёлын төвийн их танхимын шал будах ажилд 0,6 сая төгрөг • "Бугант Нандин" ХХК, "Ди Зэт Энд Ай" ХХК хамтран нийгмийн хариуцлагын хүрээнд Бугант тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын суралцах орчин нөхцөлийг сайжруулахад зориулан 80.0 сая төгрөгийн үнэ бүхий 6 ангийн иж бүрэн ширээ сандал, 9ш багшийн иж бүрэн ширээ, сандал. • "Инфинити Спэйс" ХХК-ны Хандгайт төмрийн хүдрийн уурхайн хүдэр баяжуулах үйлдвэрийн эцэг эхийн зөвлөлөөс Ерөө ЕБСургуульд 10м урттай, 2.5м өргөнтэй 5.9 сая төгрөгийн өртөгтэй дугуйн зогсоолыг хийж өгсөн. • "Инфинити спэйс" ХХК Тавин Буурагчин багийн хүүхдийн тоглоомын талбайг 3,5 сая төгрөгөөр засаж өнгө будгийг сэргээсэн. • Номин-Од ХХК-наас ЕБСургуулийн дотор байрлах 3 хяналтын камерыг шинэчлэх ажилд 0.3 сая ₮ зарцуулсан. <p>Төмс, хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хоршоодыг нэмэгдүүлэх зорилгоор:</p> <ul style="list-style-type: none"> • АДРА олон улсын байгууллагаас "Органик хөдөө аж ахуй" сургалтыг 2 удаа • Японы ядуурлыг бууруулах сан азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар нийт 927.1 сая төгрөгийн өтрөг бүхий техник, тоног төхөөрөмжийг "Ургац Ерөө" хоршоонд • НҮБ-н ХАА-н байгууллагаас малын үржлийн нэгж болон "Монгол женетикс сервис" ХХК-д 160,0 сая төгрөгийн өртөг бүхий мал үржлийн орчин үеийн дэвшилтэд багаж хэрэгсэл, шинээр байгуулагдаж буй үржлийн нэгжийн хашаажуулалтад 50.0 сая төгрөг, малчдын сургалт, сурталчилгаанд 15.0 сая төгрөг • НҮБ-ын богино хугацаат төслөөс малаас гарах нэмүү өртгийн сүлжээг дэмжихээр "Өгөөж Ерөө сүү" хоршоонд 140.0 сая төгрөгийн сүү цагаан идээ боловсруулах тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн. Нийт олон улсын байгууллагын 3 төсөл хөтөлбөрөөс 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. 	100%

ДӨРӨВ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГО

4.1 ХЕДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫГ ХҮРЭЭНД

1 4.1.1 Атрын 4-р аяны хүрээнд атар газрын тооллого явуулж, “Атаршсан тариалангийн талбайг” иргэдэд олгон гэрчилгээжүүлж, үр тариа, төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлнэ. Орон нутгийн үр үржүүлэх аж ахуйн нэгжийг түшиглэн **“Сайн чанарын үрээр орон нутгийн тариалангийн аж ахуйн нэгжийг хангах”** бодлогыг хэрэгжүүлнэ.

Монгол улсын Засгийн газрын 2020 оны “Газар тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих арга хэмжээний тухай” 138 дугаар тогтоол болон Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын 3.1-д заасан “Тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх, атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх, зорилгын хүрээнд сумын Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 373 тоот албан бичгээр тус сумын хэмжээнд тариалангийн ангилалд шилжүүлэх боломжтой 84 байршилд 1159 га газрын судалгааг гарган координатжуулан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

Тариалангийн тухай хуулийн 5.1 дэх заалтад Сум дүүргийн ИТХ-д атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх талаар Засаг даргын саналыг хэлэлцэж шийдвэр гаргана гэж заасны дагуу атар газарт шилжүүлэх боломжтой ашиглаж байгаа 597 га, атар газар нэмж хагалах боломжтой 562 га газрыг сумын ИТХ-д санал оруулан батлуулахаар хэлэлцэх шатандаа явж байна.

Монгол улсын Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Засгийн газрын 2003 оны 02-р сарын 07-ны өдрийн 28 тоот тогтоолын 5 дугаар хавсралт “Тариалангийн газрыг давуу эрхээр эзэмшүүлэх журам”-ын дагуу 7 иргэний өргөдлийг хэлэлцүүлж, давуу эрхийн тариаланч өрхөөр тодорхойлуулахаар сумын ИТХуралд саналыг хүргүүлсэн.

- 2023 онд ногоочдын үйл ажиллагааг эрчимжүүлэн дэмжих зорилгоор ХХААХҮЯамнаас 80 хувийн хөнгөлөлттэй үнээр ирсэн 397300 төгрөгний үнэ бүхий 300 кг сонгино, 200 кг саримс, 1 кг хүрэн манжин, 4 кг шар манжин, 4 кг лууван, 1 кг бууцай, 5 уут байцаа, 1 кг урт сонгино, 6 уут өргөст хэмхний үрийг 196 ногоочинд олгож, 65,4 га талбайд тариалалт хийсэн. Цаг агаарын өөрчлөлтийн улмаас хаврын тариалалт оройтож эрт тариалсан хүнсний ногооны соёололт удаашран тариалах талбайн хэмжээ буурсан ч га талбайгаас авсан ургацын үзүүлэлт өнгөрсөн онтой харьцуулахад 0.2 цн-ээр өссөн дүнтэй байна.

100%

	2021		2022		2023	
Улаан буудай	9662 га	11805тн	12822г а	23079тн	8399га	16706,1 тн
Арвай	-	-	49га	38тн	77га	70тн
Рапс	2842 га	2000 тн	2761га	1086тн	4766,6 га	1779,09 тн
овъёос	156 га	176тн	92га	111тн	77га	140тн
Ногоон тэжээл	481 га	325тн	617га	534тн	75га	90тн
төмс	63,4 га	761,8тн	67,2га	915тн	57,5га	575,3тн
Хүнсний ногоо	75,75 га	873тн	82,6га	842,9тн	65,4га	680,9тн
Уринш	10701 га		7501га		10448га	

- **Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолыг** хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.6.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах, хөрсний үржил шимийг сайжруулахаар тариалалтад зориулж бордоо худалдан авсан ААН, иргэнд үнийн дүнгийн 30 хүртэлх хувьд татаас олгох ажлын хүрээнд үр тарианы 9 ААНэгж хүсэлтээ илгээн хамрагдсан бөгөөд үүнтэй холбоотой энэ онд нэгж га талбайгаас хураан авсан улаан буудайн ургацын хэмжээ 19,9 цн буюу өмнөх онуудтай харьцуулахад өссөн дүнтэй байна.

2	4.1.2 Өвөл, зуны хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн тоог нэмэгдүүлж жилийн 4 улиралд сумын “Иргэдийг хүнсний ногоогоор хангаж” бүх төрлийн хүнсний ногооны суулгац, үрсэлгээгээр орон нутгийн хүнсний ногооны иргэдийг хангах бодлогыг барьж ажиллана.	<p>Зуны хүлэмжтэй 61 өрх , 1 хоршоо 1239 м2 бүхий талбайд нарийн ногооны тариалалт хийж орон нутгийн иргэдийг үр үрсэлгээгээр хангах зорилгоор 30 төрлийн 1200 ширхэг суулгацыг иргэдэд худалдаалахаас гадна сургууль, цэцэрлэг, ЗДТГазар, Эрүүл мэндийн төв зэрэгт мандлын цэцгийн 200 ширхэг үрсэлгээг өгч ногоон байгууламжийг нэмэгдүүлэхийг дэмжин ажиллаж байна.</p> <p>500м2 Нарлаг хүлэмжид Ургац Ерөө хоршооны гишүүд эхний тариалалтаар 5.20-06.30 хүртэлх хугацаанд Сонгино-4тн , 2 дахь тариалалт 07.10-09.15 хүртэл өргөст хэмх 8 тн тус тус хураан авч эрт ургацын ногоог БТЕГ болон иргэд худалдааны төвүүдэд нийлүүлсэн байна.</p> <p>УИХ-ын гишүүн Д.Өнөрболорын дэмжлэгээр 30 хүлэмжийг олгосныг Агро паркийн зориулалтаар иргэдэд гэрээгээр ашиглуулахаар төлөвлөн одоогоор 1,2-р багийн ажиллах хүсэлтэй иргэдийн нийт 16 өргөдлийг хүлээн аваад байна. Мөн УИХ-ын гишүүн Ч.Ундрэм 5 иргэнд 5 хүлэмжийг олго байна.</p> <p>Хүлэмжийн аж ахуй эрхэлж буй иргэд хүнсний ногоог ээлжлэн тариалалтаар 2-с 3-н удаагийн эргэлтэд оруулж ургацаа нэмэгдүүлэхээр ажилласан. Мөн хоршоологчид органик төмс хүнсний ногоогоор дотоод зах зээлээ хангаад зогсохгүй хаяг шошго бүхий стандартын шаардлага хангасан төмс хүнсний ногоо болон нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг аймаг, нийслэлийн иргэдэд худалдан борлуулж байна.</p> <p>Хавар, намрын улирлуудад хүнсний ногоо болон мод, жимс жимсгэнийн тарьц суулгацын үзэсгэлэн худалдааг 3 зохион байгуулж орон нутгийн иргэн ААНэгж, хоршоологчдын тарьц суулгац, бүтээгдэхүүнийг солилцох болон худалдаалах нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа.</p>	100%
3	4.1.3 Төмс, хүнсний ногоо тариалж буй иргэдийн ногоог хадгалах зорилгоор стандартын шаардлага хангасан “500тн зоорийг шинээр барьж” ашиглалтад оруулна.	<p>2022 оны 12 сард ашиглалтад орсон 100 тн багтаамжтай зооринд Ургац Ерөө хоршооны ногоочдын 4 тн төмс , хүнсний ногоог хадгалаад байна.</p> <p>2023 оны байдлаар Бугант тосгонд 8тн, 10тн , 20 тн-ны багтаамж бүхий 4 өрхийн нийтээрээ ашиглагдаж байгаа зоорь байна.</p>	30%
4	4.1.4 Ногоочдын хоршоо, холбооны үйл ажиллагааг эрчимжүүлж дэмжин орон нутгийн иргэдийн тариалсан төмс, хүнсний ногоог зах зээлд борлуулах сүлжээг бий болгоно.	<p>Органик тариалалт эрхлэгч хоршоо, компанийг газар тариалангийн https://plant.mofa.gov.mn/ программд бүртгэлжүүлэх, хүнсний ногооны урамшуулалд хамрагдах заавар зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж байна. Газар тариалангийн цахим программд 513 нэгж талбарын 23205,7 га талбайг бүртгэсэн байна. Үүнээс 23 хуулийн этгээд 67 тариаланч 418 нэгж талбарын 20498,9 га талбайг ашиглаж байна.</p> <p>Улаан буудай-13078 тн борлуулалтад, Төмс, хүнсний ногоо- 15 тн борлуулалтад, Хадлан- 3 иргэнд тус тус цахим гарал үүсэл олгосон.</p> <p>Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтын хүрээнд ногоочдын хоршоо, холбооны үйл ажиллагааг эрчимжүүлэн дэмжиж орон нутгийн иргэдийн тариалсан төмс, хүнсний ногоог зах зээлд борлуулах сүлжээг бий болгохоор худалдаа эрхлэх ТҮЦ-ийг хүлээлгэн өгсөн.</p> <p>Ургац Ерөө хоршооны ногоочид БТЕГ ХХК-тай гэрээ байгуулан улиралд дунджаар 10-15 тн төмс, хүнсний ногоог нийлүүлж байна. Суманд 9 хоршоо, хүнсний ногоо тариалагч 350 иргэд 62 төрлийн 54000 ширхэг даршилсан бүтээгдэхүүнийг өрхийн хэрэгцээндээ үйлдвэрлэж байна.</p> <p>Энэ онд улс аймгийн 10 үзэсгэлэн худалдаа, сумандаа зохион байгуулсан 3 үзэсгэлэн худалдаанд нийт 9 хоршоо, 24 иргэн оролцон нийт 10.400.000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.</p>	90%
5	4.1.5 Бэлчээр хадлангийн менежмент төлөвлөгөөг боловсруулан хянан баталгааг хийлгэж, талбайн ашиглалтыг сайжруулна	<p>Газар зохион байгуулалтын дунд хугацааны бодлогын бичиг баримт болох Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд бэлчээр ашиглалтыг сайжруулах арга хэмжээг тусгаад байна. Хадлангийн талбайн ашиглалтыг сайжруулах зорилгоор 350 малчин, мал бүхий өрхтэй гэрээ байгуулан, газрыг хуваарилан олгосон.</p> <p>Стрийм төсөлтэй хамтран хийгдсэн нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд бэлчээрийн доройтолд орсон газруудын ургамлын бүтцийг сайжруулах, нөхөн сэргээх ажлын хүрээнд Дааган дэл, Энх тал, Хужирт, Гэрэлт хайлааст гэсэн 4 байршилд координат цэг авч бэлчээрийн мониторингийн ажлыг гүйцэтгэхэд Хужирт хэсэгт ургамлын бүтэц алдагдан хүчтэй талхлалттай гарсан тул 2024 онд ургамлын бүтцийг сайжруулах зорилгоор бэлчээрийг өнжөөхөөр төлөвлөсөн.</p>	70%
6	4.1.6 Бэлчээрийн ургамлын бүтцийг сайжруулах	2 ААНэгж 75 га талбайгаас 90 тн ногоон тэжээл, 3 ААНэгж 77 га талбайгаас 140 тн овъёос тус тус хураан	90%

	чиглэлээр олон наст ургамал тариалсан малчид, хоршоог бодлогоор дэмжиж, дотооддоо ” Ногоон тэжээл ”-ийг үйлдвэрлэнэ.	авсан бөгөөд 2021, 2022, 2023 оны байдлаар нийт 1173 га талбайд тариалж 949 тн ногоон тэжээлийг дотооддоо үйлдвэрлээд байна.	
7	4.1.7 Сумын өвс, тэжээлийн фонд бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 221 тоот тогтоолын хүрээнд 2023 онд бизнесийн зориулалтаар хадлан бэлдэж буй 1 га талбайгаас 2 боодол өвсийг сумын өвсний фондод авахаар 35 иргэнтэй гэрээ байгуулсан. Одоогийн байдлаар 50 тн өвсийг бэлтгээд байна. Газар тариалангийн аж ахуйн нэгжүүдээс 4 тн тэжээлийг нөөцөлсөн. Малчин, мал бүхий 650 өрх 12800 тн хадлан бэлтгэсэн.	70%
8	4.1.8 Алтан намар”, “Сэлэнгэд үйлдвэрлэе”, “ Намрын ногоон өдрүүд” зэрэг уламжлал болгон зохион байгуулагддаг аймаг, улсын үзэсгэлэн худалдаанд ногоочид болон жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг тогтмол оролцуулж, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах замаар харилцан туршлага солилцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллана	2023 онд Улс, аймгийн 10 үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор 59 жижиг дунд бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж, хоршоод 158 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 22,640,200 төгрөгийн, Ерөөлтэй цагаан сар-2023, ургацын баяр, малчдын өдөрлөг арга хэмжээний үеэр 3 удаагийн үзэсгэлэн худалдааг сумандаа зохион байгуулж 24 иргэн 2 аж ахуй нэгж 72 төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож 10400000 төгрөгийн борлуулалт хийсэн байна	100%
9	4.1.9 Мал эмнэлгийн үйл ажиллагаанд төрөөс тавих хяналтыг сайжруулан урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанаржуулж “Эрүүл малтай” сум болно.	Мал эмнэлгийн үйл ажиллагаанд төрөөс тавих хяналтыг сайжруулан урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанаржуулж “Эрүүл малтай” сум болох ажлын хүрээнд энэ онд Улсын санхүүжилттэй тарилга-3, Орон нутгийн санхүүжилттэй тарилга- 6, Гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга-3 нийт 12 төрлийн тарилгыг 213'724 толгой мал, амьтанд хийгдэж одоогийн байдлаар гоц халдварт өвчин бүртгэгдээгүй эрүүл малтай сумын статусаа хадгалж байна.	100%
10	4.1.10 Ерөө үүлдрийн нарийн нарийвтар ноост хонийг өсгөн үржүүлэх, цөм сүргийг бүрдүүлж, удмын санг сэргээх, үржлийн ажил үйлчилгээг явуулахад дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллана.	Малын үүлдэр угсааг сайжруулах үржлийн цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор Сумын засаг даргын 2023 оны А/155 дугаартай захирамжаар 2023 оны 5-р сард 250 хуц, 200 ухна, 2500 Ерөө үүлдрийн хэсгийн хонинд үзлэг ангилалт хийгээд байна. Шинээр 12 хуцан хурга, 5 ухна ишиг шилэн сонголт хийж үржилд ашиглахаар болсон. Малын удмын сангийн үндэсний төвийн ОХУлсаас оруулж ирсэн “Цыга” үүлдрийн 1 хуцыг авчран 5 өрхийн 367 хонинд зохиомол хээлтүүлэг хийж, үлдсэн хоньтой өрхүүдэд Сэлэнгэ аймгийн Орхон суманд маллаж байсан Ерөө үүлдрийн хэсгийн 10 хуцыг авчирч технологит хугацаанд нь тарааж өгсөн.	100%
11	4.1.11 Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор сумандаа “Жишиг үржлийн нэгжийг цогцоор нь байгуулж” тухайн үржлийн нэгжид сумын хэмжээний хээлтүүлэгчийг гэрээгээр хариуцуулна.	Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор 2022 оны малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр баригдсан үржлийн нэгжид НҮБ-н ХХААБ-н Стрийм төслөөс 80 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлж 50 сая төгрөгийн өртөг бүхий хашаа барьсан. Үржлийн нэгжийн үйл ажиллагааны зардалд 37 сая төгрөг төсөвлөн 1 мэргэжилтэнг томилон ажиллуулж, үржлийн нэгжээр дамжуулан хээлтүүлэгч 250 хуц, 200 ухна, Ерөө үүлдрийн хэсгийн 2500 хонинд хавар, намрын үзлэг ангилалтыг хийж, малын удмын сантай хамтран 2-р багийн малчин Д.Доржсүрэн, н.Шийлэггаларай нарын 107 үнээ, Ерөө үүлдрийн хэсгийн 367 хонинд зохиомол хээлтүүлгийн ажлыг хийсэн. Ерөө үүлдрийн хэсгийн хоньтой өрхүүдийн дунд “Шилмэл мал 2023” уралдааныг зохион байгуулж нийт 8 өрхийн 24 эм хонь оролцож шалгарсан хонины амьдын жин 69кг, зохиомол хээлтүүлгийн хурга 35-40 кг татсан байна.	100%
12	4.1.12 Мах, сүүний чиглэлээр “үхрийн цөм сүрээ” -ийг бүрдүүлэх, малын үүлдэрлэг чанарыг голлон хөгжүүлэх үүднээс мах, сүүний чиглэлийн бухыг үржлийн нэгжид хариуцуулж зохиомол хээлтүүлэг хийж, эрлийз, цэвэр эрлийз малын тоо толгойг өсгөнө	Мах, сүүний чиглэлээр үхрийн цөм сүргийг бүрдүүлэх, малын үүлдэрлэг чанарыг голлон хөгжүүлэх үүднээс Орон нутгийн хөгжлийн сангийн 20.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Герфорд үүлдрийн 5 бух худалдан авах ажлыг “БИ БИ СКАЙ” ХХК гүйцэтгэн 1,2,3-р багийн мал бүхий 5 өрхөд хариуцуулаад байна. Мөн малын удмын сангийн хөрөнгө оруулалтаар 2-р багийн 107 үхэрт Ангус, Лимузин үүлдрийн гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийлгэж хээлийн шалгалтаар 70 хувийн хээлт авалттай байна.	100%

13	4.1.13 Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнүүдэд “Шинжилгээ хийх лаборатори” -ийг мал эмнэлэг үйлчилгээний нэгжийг түшиглэн байгуулж, шаардлагатай техник хэрэгслээр хангах замаар үйл ажиллагааг нь тогтмолжуулна.	Лабораторийн шинжилгээнд: Бруцеллөз лейкозын тандалт судалгааг 21 өрхийн 524 толгой бог бодоос цусны дээж авч Сэлэнгэ аймгийн мал эмнэлгийн лабораторийн шинжээчид дээжийг хүргүүлсэн байна. Мал амьтны гоц халдварт Шүлхий, Бог малын мялзан өвчний ийлдэс судлал, эмнэл зүйн тандалтыг түүврийн аргаар сонгогдсон Ерөө сумын 3-р багийн малчин В.Буянтогтохын 4 толгой үхэр, 6 толгой хонь, 6 толгой ямаа нийт-16 толгой малаас дээж авсан хариу сөрөг буюу эрүүл гарсан байна. Мөн суманд Шинжилгээний лаборатор барих зорилгоор “МАК” ХХК-нд газрын асуудлыг шийдвэрлэн ажиллаад байна.	50%
14	4.1.14 Мал эмнэлгийн үйлчилгээ, эмийн хангамжийг иргэдэд ойртуулах зорилгоор “Малын эмийн сан” -гийн эмийн хангамж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.	Монгол улсын зөвлөх малын эмч Д.Ууганбаярыг урьж авчран “Эмийн зохистой хэрэглээ дэлхийн стандарт” сэдэвт сургалтанд 50 гаруй малчин хамруулсан. Мөн суманд үйл ажиллагаа явуулдаг Лха-Чинбу, Таван Эрдэнэ Вэт МЭҮНэгжүүдээр дамжуулан эмийн сангийн үйл ажиллагааг сумын малчин, мал бүхий өрхүүдэд төрийн үйлчилгээг хүргээд байна. - Мал амьтаны туулгын бэлдмэл - Угаалгын бодис - Ариутгалын бодис - Үрэвслээс эсэргүүцэх антибиотукууд - Тосон түрхлэг - Мал амьтны багаж хэрэгсэл зэргийг худалдаалан борлуулж байна.	100%
15	4.1.15 “Мал угаалгын банн” -ыг хөдөөгийн хэсгүүдэд барьж байгуулна.	1-р багийн Хужиртад Мал угаалгын банн барих ажлыг малын тоо толгойн албан татварын 20.0 сая төгрөгийн хөрөнгөөр “Таван Эрдэнэ Вэт” ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.	100%
16	4.1.16 Бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор алсын бэлчээрт “Худаг ус гаргах” , зам давааг засан сайжруулах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлнэ	Бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор алсын бэлчээрт худаг ус гаргах ажлын хүрээнд малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр худаг ус гаргах ажлын тендерт “БОДИ ХАРАА” ХХК шалгарч 1-р багийн нарийн хөндийд гарган хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон. Мөн 1,2-р багийн малчин А.Эрдэнэдаваа, Н.Наранбаяр, Ц.Шинэбаяр нар нь Хужиртын ам, Баянцагааны энгэрт, Хөх чулуутын зүүн урд өөрсдийн хөрөнгө нийт 45 сая төгрөгөөр 2 гүний худаг гаргуулаад байна.	100%
17	4.1.17 Малын чанар, үүлдэр угсааг сайжруулах зорилгоор эрчимжсэн мал аж ахуйг уламжлалт мал аж ахуйтай хослуулан эрхлэхийг бодлогоор дэмжинэ.	Малын үүлдэр угсааг сайжруулахаар НҮБ-ын ХХААБ-ын Стрийм төслөөс 80 гаруй сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн бөгөөд эрчимжсэн мал аж ахуйг уламжлалт мал аж ахуйтай хослуулан эрхлэх чиглэлээр хавар намрын давхардсан тоогоор 250 хуц, 200 ухна, 2500 Ерөө үүлдрийн хэсгийн хонинд үзлэг ангилалт хийж малын удмын сантай хамтран 2-р багийн 2 малчин өрхийн 107 үнээ, Ерөө үүлдрийн хэсгийн 367 хонинд зохиомол хээлтүүлэг хийж үлдсэн хоньтой өрхүүдэд Сэлэнгэ аймгийн Орхон суманд маллаж байсан Ерөө үүлдрийн хэсгийн 10 хуцыг авчирч технологит хугацаанд нь тарааж өгсөн. Мөн мах, сүүний чиглэлээр үхрийн цөм сүргийг бүрдүүлэх, малын үүлдэрлэг чанарыг голлон хөгжүүлэх үүднээс Орон нутгийн хөгжлийн сангийн 20.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Герефорд үүлдрийн 5 бух худалдан авах ажлыг “БИ БИ СКАЙ” ХХК гүйцэтгэн 1,2,3-р багийн мал бүхий 5 өрхөд хариуцуулаад байна.	100%
18	4.1.18 Малчдын өвөлжөө, хаваржааны ойр “тариалангийн талбайг хашаажуулах” ажлыг үр тарианы аж ахуйн нэгжүүдээр хийлгэнэ.	2023 онд Малчдын өвөлжөө, хаваржааны ойр “тариалангийн талбайг хашаажуулах” ажлын хүрээнд Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 8 ААНэгж 2770 га талбайг өөрсдийн хөрөнгөөр хашаажуулаад байна.	100%
4.2 ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГЫН ХҮРЭЭНД			
1	4.2.1 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн их үүсвэрийг нэмэгдүүлж “Иргэдийнхээ жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх” үйл ажиллагааг дэмжинэ.	“Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлтэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу 2011-2022 оны үйл ажиллагааны тайланг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж 2023 оны төсвийг батлуулан батлуулан ажиллалаа. Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг сайжруулах олон нийтэд ил тод мэдээлэх зорилгоор Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох товыг 2023 оны 03 дугаар сарын 13-наас-04 дүгээр сарын 13-ны хооронд зарлаж нийтэд цахимаар, мэдээллийн самбаруудаар дамжуулан хүргэж 18 иргэн, аж ахуй нэгж, хоршооны төсөл ирсэн байна. Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хороо хуралдаж 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр төслийг хамгаалуулж дундаж оноогоор эрэмбэлэн Засаг даргад хүргүүлж	100%

		<p>ажиллаа. Засаг даргын захирамжаар 7 иргэн жижиг, дунд бизнес эрхлэгчдэд 13 ажлын байр бий болгох зорилгоор 70,000,000 төгрөгийн зээлийг олгож нийтэд ЗДТГ-ын мэдээ цахим сайтад, ЗДТГ-ын мэдээллийн самбарт мэдээллээ.</p> <p>Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг сайжруулах зорилгоор зээлдэгчидтэй утсаар сар бүр, биечлэн 3 удаа 34 зээлдэгчидтэй уулзаж нөхцөл байдалтай танилцан зээлээ хуваарийн дагуу төлөх талаар сануулж хяналтын хуудас хөтлөн ажиллаа. Мөн хоршоо хөгжүүлэх сангийн хяналт тавих орон тооны бус зөвлөл 2 удаа хуралдаж чанаргүй зээлийн ангилалд орсон 11 иргэнд мэдэгдэх хуудас өгч, энэ жилийн олголт 6 зээлдэгчдийн төсөл, зээл олголттой танилцаж зээлийг зориулалтын дагуу ашигласан эсэхэд хяналт шалгалт хийж ажиллаа. Энэ онд 5 зээлдэгч зээлээ бүрэн барагдуулсан. 10 сарын байдлаар сангийн 100130255401 тоот дансанд төгрөгийн 75,000,000 эргэн төлөлт орсон байна.</p> <p>Засаг даргын Тамгын газрын мэдээ цахим хуудсаар хоршоо хөгжүүлэх сан, хүнс жижиг дунд үйлдвэрлэл, стандарт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар 36 мэдээллийг оруулсан байна.</p> <p>Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, сангийн хөрөнгийн зарцуулалт, олгосон зээлийн талаарх мэдээллийг нийтэд ил тод болгож, дүн шинжилгээ хийх боломжийг олон нийтэд олгож зээлийн мэдээллийг цахим мэдээлж байна.</p> <p>Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газраас зохион байгуулсан “Бэст” хөтөлбөртэй хамтран Хоршоо хөгжүүлэх сангийн журам, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрт хэрхэн хамрагдах, төсөл бичихэд анхаарах асуудлын талаарх 2 удаагийн сургалтад давхардсан тоогоор сумын 59 иргэд, жижиг дунд бизнес эрхлэгч, хоршоодыг хамруулж үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна.</p> <p>Жижиг дунд бизнес эрхлэгчдийн борлуулалт марктенг, харилцаа хандлага, хоршооны хөгжлийн талаарх сургалтыг 2023 оны 11 сарын 20-24 хооронд суманд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p>	
2	4.2.2 Жимс, жимсгэнийг үржүүлэх, тарьц суулгацаар ханган ургуулах аж ахуйн нэгж, иргэдийн санал санаачилгыг дэмжиж ажиллана	<p>Сүүлийн 5 жилд нийт 176 өрх 45,8 га талбайд чацаргана, үхрийн нүд , бөөрөлзгөнө, алим болон бусад жимс жимсгэнийн суулгацыг тариалсан бөгөөд тариалалтын 87,7 %-ийг чацаргана, үхрийн нүдний мод, бут эзэлж байна.</p> <p>2023 оны байдлаар чацаргана – 3,2 тн , үхрийн нүд- 2,8 бөөрөлзгөнө- 5 кг, тэсэргэнэ- 7кг, улаалзгана- 15 кг, алим-5кг тус тус хураан авсан. Нийт өрхийн 10 орчим хувь нь жимсээр нь 230 кг, өрхийн хэрэгцээнд жимсгэнийн чанамал боловсруулан 0,5 гр-ийг дунджаар 10000-12000 төгрөгөөр үнэлэн үзэсгэлэн худалдаа болон хот суурин газрын иргэдэд захиалгаар нийлүүлэн борлуулж байна.</p> <p>2023 онд жимс жимсгэнийн тариалалтын төрлийг нэмэгдүүлэх зорилгоор ЗДТГ, “Хашаандаа сайхан амьдаръя” групп хамтран Булган голын алим ХХК-ний захирал Хумжаагийн Балжиннямаар “Алим тариалах аргачлал” онол практикийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтад идэвх санаачилгатай оролцсон 1, 2-р багийн нийт 42 иргэнд БТЕГ ХХК-ний Байгаль орчны албанаас бэсрэг алимны модны суулгацыг үнэ төлбөргүй олгон жимс, жимсгэнийн тариалалтыг дэмжин ажилласан.</p>	100%
3	4.2.3 Өрхийн үйлдвэрлэлээр гэрийн мод, гэр ахуйн модон эдлэл үйлдвэрлэх иргэдэд үйлдвэрлэлийн хэрэгцээний мод бэлтгэх боломжоор хангана.	<p>Уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар сумын ИТХ-ын 2023 оны 84 дугаартай тогтоолоор шинэс 200м3 /хэрэглээ/ , нарс 750м3 /хэрэглээгээ/ олгохоор баталж мод бэлтгэх боломжоор хангасан боловч журмын дагуу хүсэлт өгсөн өрхийн үйлдвэрлэгч байхгүй. Тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар сурталчлах ажлыг 2 удаа хийсэн. Өрхийн үйлдвэрлэгч иргэд бүтээгдэхүүний түүхий эд бэлдэцээ Хүдэр сум болон Ерөө сумын ойн мэргэжлийн байгууллагуудаас татан авч эцсийн бүтээгдэхүүн болгож зах зээлд нийлүүлж байна.</p>	30%
4	4.2.4 Худалдаа үйлчилгээний салбарын ажилтнуудыг үйлчилгээний чанар, боловсон хүчний чадавхыг сайжруулж үйлчилгээний соёл, стандарт	<p>Хөвсгөл аймгийн Мөрөн суманд зохион байгуулагдсан “ХҮСЭХҮЙН ЦОМ 2023” Төв Хангайн бүсийн тогоочийн ур чадварын уралдаан зохион байгуулагдаж Сэлэнгэ аймаг Ерөө сумаа төлөөлж ерөнхий боловсролын сургуулийн тогооч, жижиг дунд бизнес эрхлэгч К.Түмэнжаргал оролцож сургуулийн хоолны</p>	100%

	<p>мэдлэг мэдээллийг дээшлүүлэх сургалтад улирал бүр хамруулж “Ур чадвар, соёлыг дээшлүүлнэ”.</p>	<p>төрөлд мөнгөн медаль, Орон нутгийн онцлог төрөлд хүрэл медаль хүртэж амжилттай оролцлоо.</p> <p>Аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны 20 жилийн ойн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, оролцогчдын идэвх оролцоог сайжруулах, орон нутгийн тариаланчдын бүтээгдэхүүн, үйл ажиллагааг сурталчлах, эрүүл зохистой хооллолтыг дэмжих, аймгийн орон нутгийн онцлогтой хоол, идээ ундааг хөгжүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, төрийн үйлчилгээний байгууллагуудын тогоочдын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Ургацын далай” тогоочдын ур чадварын тэмцээнийг 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр болж сумаас Ерөө сумын Ерөнхий боловсролын тогооч К.Түмэнжаргал, Өндөр тулгатан хоршооноос Ц.Өрнөх, ахмад тогооч Ц.Уранбилэг нар оролцлоо.</p> <p>Дэлхийн тогооч нарын өдрийг угтан сургууль, цэцэрлэгийн тогооч нарын ур чадварын улсын уралдаанд ЕБС-ийн хүүхдийн хоолны төрөлд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах тогооч К.Түмэнжаргал “Тусгай” байр эзэллээ.</p> <p>Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан болон Хоршоо хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээлийн мэдээллийг хүргэн, хүртээмжийг нэмэгдүүлэх, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, төсөл бичих тухай 2 удаагийн цахим сургалтад худалдаа үйлчилгээний аж ахуй нэгжээс давхардсан тоогоор 9 иргэн аж ахуй нэгж хамрагдсан.</p> <p>Хүнсний аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан хоол хүнсээр дамжих, өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, бараа бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зорилгоор сумын засаг даргын 2023 оны А/10 дугаартай захирамжийн дагуу 3 удаа давхардсан тоогоор суманд үйл ажиллагаа явуулдаг худалдаа үйлчилгээний 27 аж ахуй нэгж байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгууллаа. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж, заавар зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаа. Мөн хүүхдийн баяр болохтой холбогдуулж Аймгийн Эрүүл мэндийн газрын эрүүл ахуйн байцаагчтай хамтран сумын 1 супер маркет 2 мини маркетад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж заавар зөвлөгөө өгч газар дээр нь зөрчлийг арилгуулж ажиллаа.Хүнсний чанарын стандартын талаарх мэдээллийг цахимаар 12 удаа хүргэж ажилласан байна. Мөн аймгийн Засаг даргын захирамж, аймгийн хүнс хөдөө аж ахуйн газрын зөвлөмж, аймгийн эрүүл мэндийн төвийн байцаагчийн зөвлөмж, зөвлөгөөг 4 удаа давхардсан тоогоор 51 аж ахуй нэгж иргэдэд хүргэсэн.</p>	
5	<p>4.2.5 Иргэдэд үйлчилгээ үзүүлж буй ахуйн үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж “Үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх” /Гутал, гар утас засвар, хими цэвэрлэгээ, хивс цэвэрлэгээ цахилгаан хэрэгслийн засвар / гэх мэт санал санаачилга гаргасан иргэдийг дэмжиж төсөл хөтөлбөрт хамруулж ажлын байрыг нэмэгдүүлэн ахуйн үйлчилгээний болон тосгоны худалдааны төвийн бараа үйлчилгээний төрлийг төрөлжүүлэн барилга байгууламжуудыг сэргээн засварлана.</p>	<p>Сумын төв дээр иргэдийн хэрэгцээ шаардлага дээр тулгуурласан ахуй үйлчилгээний дараах төрлүүдээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: Үсчин-3, оёдол-3, зурагчин-2, гар утасны худалдаа, канон эх бэлтгэл-2, комиссын бараа-4, шуудан холбоо-1, гоо сайхны бараа-1, гоо сайхан-1, ахуйн бараа-1, цайны газар -3, талх нарийн боов-4, хэрчсэн гурил-3, давсан урлал-1, гутал-1, дугуй засвар-4 16 чиглэлд 56 иргэн үйл ажиллагаа тогтмол явуулж байна. Ахуй үйлчилгээнд өнгө үзэмжээ сайжруулж урсгал засвар хийсэн байна. Энэ онд шинээр цайны газар-1, гоо сайхан газар 1, оёдол-1, дугуй засвар авто угаалга-1 нийт 4 газар нэмэгдсэн байна.</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор сумын хэмжээнд нийт 46 аж ахуйн нэгж, 86 иргэн, 2 ахуйн үйлчилгээний төв үйл ажиллагаа явуулж байгааг дэмжин ажиллаж байна.</p> <p>“Таныг сонсьё” ажлаар ахуй үйлчилгээг хүргэх зорилгоор төвөөс алслагдсан Тавин багийн 5 чиглэлд 12 өрхийн 24 иргэдэд үсчин Х.Золзаяа 400,000 төгрөгийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлж алслагдсан багийн иргэдэд ахуй үйлчилгээг хүргэх арга хэмжээг зохион байгууллаа.</p>	90%
6	<p>4.2.6 “Сум бүрд нэг үйлдвэрлэл-үйлчилгээ” хөтөлбөрийн хүрээнд сумынхаа үйлдвэржилтийн бодлого зорилтыг шинээр тодорхойлж, сумандаа иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан үйлдвэрлэл-үйлчилгээг бий болгоход иргэдтэй хамтарч ажиллана.</p>	<p>Энэ онд шинээр цайны газар-1, гоо сайхан-1 нэмэгдсэн байна. Талх нарийн боовны үйлдвэрлэлийг сав баглаа, нэр төрлийг нэмэгдүүлэхээр халамжийн сангаас 10,000,000 төгрөгийн зээл олгосон. Хоршоо хөгжүүлэх сангаас модон эдлэл-7,000,000, эсгий урлал-10,000,000 төгрөгийн зээл олгон дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор сумын хэмжээнд нийт 46 аж ахуйн нэгж, 86 иргэн 2 ахуйн үйлчилгээний төв үйл ажиллагаа явуулж байгааг дэмжин ажиллаж байна.</p> <p>Энэ онд шинээр цайны газар-1, гоо сайхан газар 1, оёдол-1, дугуй засвар авто угаалга-1 нийт 4 газар нэмэгдсэн байна</p>	90%

		Жижиг дунд бизнес эрхлэгчдийн борлуулалт марктенг, харилцаа хандлага, хоршооны хөгжлийн талаарх сургалтыг 2023 оны 11 сарын 20-24 хооронд суманд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	
7	4.2.7 “Сумын брэнд” бүтээгдэхүүн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж сумандаа үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн бүрийг “Ерөөд үйлдвэрлэв” ижил шошго, хаяг сав баглаа боодолтой болгож бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж “Баялаг бүтээгчдийн холбоо”-ны үйл ажиллагааг идэвхжүүлж, бүтээгдэхүүнээ бусад аймаг сумдад сурталчилж нийлүүлэх бодлого баримтална.	Сумын брэнд талх аймгийн брэнд болгох сав баглааг сайжруулах зорилгоор халамжийн сангаас 10,000,000 төгрөгийн зээлийг олгосон. Цахир хоршоо нь зөгийн бал цэцгийн тоосонцор желли багц бүтээгдэхүүн, Примагултур ХХК-ийн цэцэг зөгийн бал 3 төрөл, Ургац Ерөө хоршооны шинэ ногооны сет, Ургац Ерөө, Цахир хоршооны даршилсан ногооны сет, Давсан урлал нийт 6 төрлийн сумын онцлох брэнд бүтээгдэхүүнээр бэлгийн багц гарган сумын иргэд болон үзэсгэлэн худалдаа, гэрээт байгууллагуудаар борлуулалт хийгдэж байна. Суманд Ерөөлтэй цагаан сар-2023 үзэсгэлэн худалдааг Ерөөд үйлдвэрлэсэн байраа бүтээгдэхүүнээр 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж 14 иргэн 2 аж ахуй нэгж 52 төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож 6400000 төгрөгийн борлуулалт хийсэн байна. 2023 онд Улс, аймаг, сумын 8 үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор 59 жижиг дунд бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж, хоршоод 158 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 14,392,000 төгрөгийн орлого олсон байна.	90%
8	4.2.8 Малчид болон иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран орон нутагтаа “Мах махан таташ бэлтгэх, нөөшлөх цех”-ийг байгуулж иргэдийг өдөр бүр шинэ махаар хангах тал дээр анхаарч ажиллах	Хоршоо хөгжүүлэх сангаас энэ онд мах, махан бүтээгдэхүүн боловсруулах, бэлтгэх зорилгоор 1 иргэнд 6000,0000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн мөн Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зорилгоор 2 иргэнд 18,000,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. Буман Ерөө ХХК, П.Гантулга нар нь 1-2 настай хонь, үхрийг бордож хавар сумын иргэд, дархан уул аймагт борлуулж махны нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Б.Отгонхишиг, Г.Мэндбаатар, нартай сумын мах нөөц бүрдүүлэх гэрээг байгуулан ажиллаж байна.	90%
9	4.2.9 Ногоочдын холбоог түшиглэн “Ногоо боловсруулах цех”-ийг шинээр байгуулах замаар орон нутагтаа ажлын байрыг нэмэгдүүлнэ.	Ногоочдын холбоо хоршоодыг хөгжлийг дэмжин ургац Ерөө хоршооны 400,000,000 төгрөгийн зорь ашиглалтад орлоо мөн ургац Ерөө хоршоотой хамтран 16 төрлийн ногооны үрслэгээний үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан байна. Ургац Ерөө хоршоо иргэд өдөр бүр шинэ ногоор хангах зорилгоор борлуулалтын 2 түц сумандаа авч ирсэн байна. Суманд 9 хоршоо, хүнсний ногоо тариалагч 350 иргэд 62 төрлийн 54000 ширхэг даршилсан бүтээгдэхүүнийг сум орон нутаг болон аймаг, улсын хэмжээнд борлуулж өрхийн орлого нэмэгдүүлэн ажиллаж байна.	90%
10	4.2.10 Малчин, мал бүхий иргэдийн сүү цагаан идээг боловсруулах зорилгоор бага оврын сүүг тээвэрлэж борлуулах “Сүү хөргөлтийн цех”-ийг сумандаа байгуулж, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.	Энэ жил Өгөөж ерөө сүү хоршоо шинээр байгуулагдаж НҮБ-ийн Хүнс хөдөө аж ахуйн байгууллагаас 140,000,000 төгрөгийн өртөг бүхий сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжийг уг хоршоонд олгож үйл ажиллагаа эхлүүлэхэд бэлэн болоод байна. Мөн сумын удирдлагууд АПУ ХХК тай гэрээ хэлцэл хийж сүү хөргөлтийн танк сумандаа байршуулахаар төлөвлөн ажиллаж байна.	70%
11	4.2.11 Малын гаралтай түүхий эдийг боловсруулах цехийг орон нутагтаа байгуулж ажлын байрыг нэмэгдүүлэх	Арьс шир боловсруулах тоног төхөөрөмжийг зээлээр авах тухай мэдээллийг 2 удаа цахимаар мэдээлж ажиллаа.	30%
4.3 НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД			
1	4.3.1 Газар өмчлөл, эзэмшил, ашиглалттай холбогдсон мэдээллийн ил тод байдлыг хангаж, “Шинээр өмчлүүлэх ажлыг эрчимжүүлж”, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг www.gazar.gov.mn хуудсанд газрын харилцаатай холбоотой мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд иргэдэд нээлттэй байршуулан ажиллалаа. “Шинээр өмчлүүлэх ажлыг эрчимжүүлж” ажлын хүрээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 09 сарын 30-ны өдрийн 69 дугаар “2023 онд иргэнд өмчүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг батлах тухай” тогтоолыг батлуулан ажилласан бөгөөд Монгол улсын иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай Монгол улсын Засгийн газрын 2023 оны 03 сарын 22-ны өдрийн 105 дугаар тогтоол батлагдан гарснаас хойш дээрх тогтоол шийдвэрүүдийг үндэслэн сумын Засаг даргын 10 удаагийн захирамжаар нийт 89 иргэнд 17.86 га буюу 224.35 сая төгрөг бүхий газрыг гэр бүлийн	100%

		хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэгүй өмчлүүлж газрыг эдийн засгийн эргэлтэд оруулаад байна. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хүрээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар Ерөө суманд нийт 2825 иргэнд 631.66 га газар өмчлүүлсэн байгаа бөгөөд газар өмчлөлийн явц 39.75 хувьтай явагдаж байна.	
2	4.3.2 Сумын газар эзэмшүүлэх, ашиглуулах “Дуудлага худалдааны үйл ажиллагааг олон нийтэд ил болгож”, цахим биржийн үйл ажиллагааг бүрэн нэвтрүүлнэ.	Газар эзэмшүүлэх, ашиглуулах “Дуудлага худалдааны үйл ажиллагааг олон нийтэд ил болгох” газрын цахим биржийн үйл ажиллагааг сум орон нутагтаа бүрэн нэвтрүүлэх хүрээнд тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 23 байршилд сумын Засаг даргын 2023 оны А/100, А/182, А/183 тоот захирамжуудаар “Газар эзэмших эрхийн дуудлага худалдаа”-г зарлан явуулж, 7 байршлын дуудлага худалдааны ялагчтай ялагчийн гэрээ байгуулан, гэрээ гэрчилгээ олгож, орон нутгийн төсөвт 60.89 сая төгрөгийг төвлөрүүлээд байна. Дуудлага худалдааны зарыг “Зууны мэдээ” өдөр тутмын сонин, сумын иргэдийн цахим хуудсууд болон ЗДТГ-ын мэдээллийн самбар, газрын цахим биржийн www.mle.mn хаягуудад тус тус байршуулан дуудлага худалдааны үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй ил тод байлгах байдлыг ханган ажилласан бөгөөд цахим биржийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.	100%
3	4.3.3 Ойн нөөцийг хамгаалах, үр өгөөжтэй ашиглах, нөхөн сэргээх мэргэжлийн байгууллагуудын менежментийг сайжруулах, жил бүр орон нутаг, улсын төсөв болон өөрсдийн хөрөнгөөр “Ойжуулалтын ажлыг хийлгэж” хүлээн авна.	Ерөө сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг нийт 32 аж ахуй нэгж, 1 ойн нөхөрлөл мод бэлтгэлийн хуваарь болон ойн менежмент төлөвлөгөөний дагуу өөрийн хөрөнгөөр 498.3 га талбайд ойжуулалт хийхээс 517.9 га талбайд ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Ойжуулалтын ажил нь 119,7% хувийн гүйцэтгэлтэй байна. “Болд төмөр Ерөө гол” ХХК-нь 150га талбайд 370,000,000 ширхэг мод суулгасан. Улсын төсвийн хөрөнгөөр болон төслийн хүрээнд Ерөө сумын 2 дугаар баг Хонгорын нуруунд “Ойн хүрмэн” ХХК 120 га, “Ногоон хэрэм” төслийн хүрээнд 2 дугаар баг Баянгол Гээг толгойг 30 га талбайг хашаажуулж 2 настай 2578 ширхэг нарс мод тарьж ойжуулалт хийсэн.	100%
4	4.3.4 Сумандаа “Ойн цэвэрлэгээ”-ний ажлыг зохион байгуулж ажил хайгч иргэдийг түр ажлын байраар хангахын зэрэгцээ ахмад настан болон зорилтот бүлгийн өрхийг хямд үнэтэй түлшний модоор хангаж ажиллана.	Бугант тосгонд үйл ажиллагаа явуулдаг 13 Аж ахуйн нэгжүүд мод бэлтгэлийн талбайгаа цэвэрлэн ахмад настан болон зорилтот бүлгийн 12 өрхөд үнэгүй түлшний мод өгөхөөр ажиллаж байна.	30%
5	4.3.5 Ерөө, Бугантын байгалийн үзэсгэлэнт газруудад “Аялал жуулчлалын бааз хотхон”-ыг байгуулж дотоодын аялал, жуулчлалыг орон нутагт хөгжих боломжийг бүрдүүлж, санаачилга гаргасан иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.	“Бугант Нандин” ХХК-нь аялал жуулчлалын баазыг Ерөө сумын 3 дугаар баг Бугант тосгон Хайгуулчин хэсэгт байгуулж аялагч амрагчдыг хүлээн авч эхлээд байна.	50%
6	4.3.6 “Булаг шандын эх, ундаргыг хамгаалах”, ойжуулах арга хэмжээг төсөл хөтөлбөрт хамруулах замаар шат дараатайгаар хэрэгжүүлж ажиллана.	Баян хангай” ойн нөхөрлөл нь Ерөө сумын 1 дүгээр баг Хужиртын булгийг хашааг сэргээн засварлаж орчны хог хаягдлыг түүж цэвэрлэсэн. Мөн “БТЕГ” ХХК-нь Ерөө сумын 2 дугаар баг Баянголын рашаан орчмыг сэргээн засварлаж тохижилтыг нэмэгдүүлсэн.	70%
7	4.3.7 Сум, тосгоны нэгдсэн хогийн цэгийг нүүлгэн шилжүүлж хог хаягдлыг цэгцэлж байнгын харуул хамгаалалттай болгон хашаажуулан, “Камер суурилуулж хяналтыг сайжруулж” ажиллана	Сумын нэгдсэн хогийн цэгийн хогийг нийт 15 удаа түрж булшлах ажил хийж гүйцэтгэлээ. Нийт 16000м ² талбайн 128000м ³ хогийг түрж булшилсан байна. Сумын төвийн айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэн ажиллаж оны эхнээс 251 өдөр 1200 айл өрх, 30 байгууллагын хог хаягдал цуглуулж ойролцоогоор 1150 тн хог хаягдал тээвэрлэн хогийн цэгт хүргэсэн байна Аймгийн Засаг даргын 2023 оны “Бүх нийтийн хог цэвэрлэгээ арга хэмжээ зохион байгуулах тухай” А/156 дугаар захирамжийн хүрээнд Ерөө самбараас БТЕГ ХХК-ний зогсоол хүртэлх 9,9 км хатуу хучилттай автозамын хоёр талаар хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж 5 орчим тонн хог хаягдлыг цуглуулан тээвэрлэж төвлөрсөн хогийн цэгт буулгасан. Мөн хавар, намар 2 удаа аж ахуйн нэгж	100%

		байгууллагууд, айл өрх, ЕБС-ын сурагчдыг дайчлан бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулж сумын төвийн эзэнгүй хог хаягдал, гудамж талбай, голын ай сав газрыг цэвэрлэж 5 тн орчим хог хаягдал цуглуулж тээвэрлэн нэгдсэн хогийн цэгт буулгасан.	
8	4.3.8 "Ногоон Ерөө" хөдөлгөөнийг эрчимжүүлж, өрх бүрийг ногоон байгууламжтай болгох замаар сумын төвийн болон нийтийн эзэмшлийн зам талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.	"БУХ НИЙТЭЭР МОД ТАРИХ" арга хэмжээг 2023 оны 05 дугаар сарын 17- н, 10 дугаар сарын 17- ний өдрүүдэд тус тус зохион байгууллаа. Уг арга хэмжээнд "БТЕГ" ХХК, ойн мэргэжлийн байгууллагуудын модны тарьцыг "Эзэнтэй мод" уриан дор нийтийн эзэмшлийн зам талбайд нөхөн тарилтаар 25 ш нарс мод, шинээр "Төгөлдөр Ерөө" ОНӨАТҮГ-тай хамтран Гэрэлт гудамжинд 1000 ш хайлаас, Трактортой толгойд 1250 ш гүйлс, голт бор мөн албан байгууллага болон айл өрхүүдэд 4000 ширхэг хайлаас, өрөл, монос, агч зэрэг модыг тараан тарьж ургуулах ажлыг зохион байгуулж заавар зөвлөгөөг өгч ажиллалаа. Сумын хэмжээнд нийт шинээр болон нөхөн тарилтаар 8 төрлийн 6275 ширхэг мод тарилаа. БТЕГол ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд Ерөө сум хүртэлх 3,7 км авто зам дагуу ногоон байгууламжийг хамгаалах хашаа барьж, мод тарьсан. /17,0 сая₮/	100%
9	4.3.9 Байгаль хамгаалах, байгалийг нөхөн сэргээх ажил эрхэлж байгаа иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжиж уул уурхайн эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх болон ойн цэвэрлэгээг зохион байгуулан орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, өрхийн орлогыг дээшлүүлэх аливаа үйл ажиллагааг дэмжиж хамтарч ажиллана.	Техникийн нөхөн сэргээлт. /дүйцүүлэн / 3-р баг Их өлөнт гэх газарт: "Ди Зэт -Элд -Ай" ХХК 3,5 га талбай, "Хонгорын орд" ХХК 3,5 га талбай, "Цемент шохой" ХХК 6 га талбай, "Чамин алт" ХХК 3 га талбай, "Сонор трейд" ХХК 3 га талбайд тус тус техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. Нийт 19га талбай Бэрлэгийн цагаан тохой: "Бэрлэг майнинг" ХХК 1,68га талбай техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. Өлөнтөд: Монлид Трейд ХХК 6 га талбай Баянгол: "БТЕГ" ХХК 2,6 га талбай, "Инфинити спейс" ХХК 6,5га талбайд тус тус техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. Биологийн нөхөн сэргээлт: Бэрлэгийн цагаан тохой: "Бэрлэг майнинг" ХХК 4,0га талбайд, "БТЕГ" ХХК Баянголд 4,6 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн. Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн нөхөн сэргээлт: "Тотал Идеал" ХХК-ны техникийн нөхөн сэргээлт хийсэн га талбай: Өвөр залаат 53,36 га талбай, Гозон 109,84 га талбай, Угтаал гол 27,2 га талбай, Цамхаг 183 га талбай, Могой 56,4 га талбай нийт 429,1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. "Жинжий майнинг" ХХК-ны техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай Харганат гэх газарт 650 га талбай, 36,6 га талбай, Могой 118 га талбай нийт 800,7 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. Оюу толгой ХХК-ны хөрөнгө оруулалтаар хийсэн нөхөн сэргээлт Ялбаг гэх газарт: "Бугант нандин" ХХК 140га талбай, "Үзэгт дэлгэрэх" ХХК 125,65 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн.	100%
10	4.3.10 Ерөө гол түүний цутгал голууд, Ерөө, Бугант голыг цэвэр урсгах зорилгоор болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх санал санаачилга гарган ажиллаж буй иргэн ААН, ТББ-ын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах.	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нартай хамтран 7 удаагийн 96 цагийн эргүүл, хяналтын шалгалтын ажлыг зохион байгуулж, хууль бусаар ашигт малтмал олборлосон 8 гэмт хэргийн шинжтэй үйлдлийг илрүүлэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж,	70%
11	4.3.11 "Ан амьтныг хамгаалах" зүй зохистой ашиглах, агнуурын бүс нутгийг хариуцуулах замаар эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэн ан амьтны тооллого явуулж, нэн ховордсон амьтны тархац нутгийг нэмэгдүүлэх талаар санал гаргаж буй иргэд ААН, нөхөрлөлүүдийг дэмжин ажиллах.	Сэлэнгэ аймгийн ИТХ-аас баталсан хувиарын дагуу зэрлэг гахай 4 ширхэг, загас 100 ширхэг эрхийн бичгийг бичиж 1,177,000 төгрөгийг бүрдүүлсэн.Мөн ангийн нийгэмлэгтэй Сэлэнгэ аймгийн байгаль орчин аялал жуулалын газартай хамтран ан агнуурын бүс газруудаар ангийн тооллогыг 10 сард хийж гүйцэтгэлээ.	100%

12	4.3.12 Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажилд ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа аж ахуйн нэгжүүдийг татан оролцуулж, тэдэнтэй хамтран ажиллах гэрээг жил бүр байгуулан, гэрээг дүгнэж хамтран ажиллана.	<p>Ойн мэргэжлийн 18 аж ахуйн нэгж, ойн санг гэрээгээр эзэмшигч 10 нөхөрлөлтэй түймрийн хариуцлагын гэрээ хийж, хуваарийн дагуу түймрийн эргүүлийг давхардсан тоогоор 16 удаа хийж Улаан гүүрэн дээр ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын постыг батлагдсан хуваарийн дагуу ажиллуулалаа.</p> <p>Мод бэлтгэх тусгай зөвшөөрөлтэй 14 аж ахуйн нэгжийн, ой хээрийн түймрийн үед хэрэглэх багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангуулж ажиллалаа.</p> <p>2023 оны 4 сарын 1-нээс 6 дугаар сарын 10-ны хооронд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Ерөө бүсийн сум дундын ойн анги, ХХУТХГ-ын Ерөө хэсэг ойн мэргэжлийн 14 аж ахуйн нэгж хамтарсан хуваарь гаргаж, ойн сан бүхий газруудад эргүүл хяналтын ажлуудыг хуваарийн дагуу хяналтын эргүүл шалгалтыг нийт 16 удаа хийж гүйцэтгэсэн. Бугант тосгоны нутагт дэвсгэр болох 35-ын аманд ойн түймэр гарч Сэлэнгэ аймгийн онцгой байдлын газар, ойн санг гэрээгээр эзэмшдэг аж ахуй нэгжүүдтэй хохирол багатай унтраасан.Ерөө сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт гарсан хээрийн 2 түймэрт Бугантаас 2 автомашин, 8 хүн явж тухайн гарсан түймрийг түргэн шуурхай унтраасан.</p>	100%
13	4.3.13 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг жил бүр батлуулан ажиллана.	Байгаль орчныг хамгаалах 2023 оны төлөвлөгөөг сумын засаг даргаар батлуулж ажиллаж байна.	70%
14	4.3.14 Засгийн газрын 2014 оны 43-р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 100,0 сая төг төлөвлөснөөс байгаль орчинд хэрэглэгдэх 3 автомашины засварт, зөөврийн компьютер 1, өнгөт принтер 1, GPS 1, Гэрээт байгаль хамгаалагчийн цалин, шатахуунд 87 сая төгрөг зарцуулсан байна. 2023 онд самрын нөөц тогтоогдоогүй. Энэ төрлийн орлого ороогүй.	70%
15	4.3.15 “БТЕГ” ХХК болон Ашиглалтын лицензтэй ААН-үүд дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ойжуулалтын ажлыг Монгол Улсдаа жишиг болохуйцаар хийлгэх.	<p>Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтээр: Их Өлөнтөд дараах аж ахуйн нэгжүүд нийт 19 га талбайд нөхөн сэргээлт хийсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.“ДИ ЗЭТ-ЭНД-АЙ” ХХК 3.5 га 2.“Хонгорын орд” ХХК 3.5 га 3.“Цемент шохой” ХК 6 га 4.“Чамин алт” ХХК 3 га 5.“Сонор трейд” ХХК 3га. <p>2023 оны 04 дүгээр сарын 18-19 өдрүүдэд Байгаль орчин аялал жуулчлалын яам, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хамтарсан “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт”-ийн хөтөлбөрийн дагуу уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орхигдсон газарт хийгдэх техникийн нөхөн сэргээлтийн талбайг хүлээлгэж өгөхөөр БОАЖЯам, Сэлэнгэ аймгийн БОАЖГазар, Ерөө сумын Засаг дарга, БОХУБайцаагч, Эрдэнэт үйлдвэрийн БОХэлтсүүд “Жинжий майнинг” ххк-д Ерөө сумын 2-р багийн нутаг Харгана, Могой гэх газруудад нийт 807га, “Total lideal” ххк-нь Цамхаг, Могойн гол, Уггаал гол, Гозон шар, Өвөр залаатад нийт 429га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.</p>	100%
16	4.3.16 Ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, ААН-үүд өөрийн ойн санд байгаа булаг рашааны эхийг хамгаалж хашаажуулах	“Баян хангай” ойн нөхөрлөл нь Ерөө сумын 1 дүгээр баг Хужиртын булгийг хашааг сэргээн засварлаж орчны хог хаягдлыг түүж цэвэрлэсэн. Мөн “БТЕГ” ХХК-нь Ерөө сумын 2 дугаар баг Баянголын рашаан орчмыг сэргээн засварлаж тохижилтыг нэмэгдүүлсэн.	50%
17	4.3.17 Ойжуулалт хийсэн газар 3-5 жил малчдыг буулгахгүй байх	Ойжуулалт хийгдсэн газар малчдыг буулгаагүй байна.	70%
18	4.3.18 Тариалангийн талбайг хамгаалах зорилгоор ойн зурвас байгуулах	“Баян Шугуй” ойн нөхөрлөл нь Ерөө сумын 2 дугаар баг Карнековд 8,5 га талбайд 3000 ширхэг хайлаас модыг тарихаар бэлтгэл ажил бүрэн хангагдсан. /2024 оны 5 дугаар сард тарьц суулгалтын ажил эхэлнэ /	50%
19	4.3.19 Тариалангийн талбайн тооллого явуулах	Сумын үр тарианы зориулалттай 431 нэгж талбарыг Sentinel-2 хиймэл дагуулын 2018.09.30 болон 2022.10.09-ны өдрийн агаар сансрын зураг дээр давхцуулан үзэж дүн шинжилгээ хийн зөрчлийн судалгааг гарган Сэлэнгэ аймгийн ГХБХБГазрын улсын байцаагчид зөрчил арилгуулахаар шилжүүлсэн.	70%

ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО			
5.1 МЭРГЭШСЭН ЁС ЗҮЙТЭЙ ТӨРИЙН АЛБА			
1	5.1.1 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх чиглэлээр төрөл бүрийн ажил үйлчилгээг нэвтрүүлж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг “Нийтэд ил тод, нээлттэй, хяналттай болгоно” .	<p>Төр, төсвийн байгууллагууд тус бүр цахим сайт болон фейсбүүк пейж хуудсыг өдөр тутам хөтлөн иргэдэд шуурхай ил тод, нээлттэй мэдээ мэдээлэл оруулж ажиллаж байна.</p> <p>Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай хүргэх, иргэдэд мэдээ мэдээллийг цаг алдалгүй мэдээлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Ерөө сумын албан ёсны веб сайт “eruu.se.gov.mn” - Ерөө сумын “ЗДТГ-ын мэдээ” фейсбүүк пэйж хуудас - Ерөө сумын “Ерөө сум ЗДТГ” фейсбүүк хуудас - Соёлын төв фейсбүүк хуудас зэрэг мэдээллийн хэрэгслийг идэвхжүүлэн ажиллуулсан. <p>Ерөө сумын албан ёсны веб сайт “eruu.se.gov.mn” болон “Ерөө сумын ЗДТГ-н мэдээ” фейсбүүк хуудсанд энэ онд салбар, салбарын 1080 гаруй мэдээ, мэдээлэл нийтлэгдэж иргэдэд хүрсэн. /Хандалт 4518/</p>	100%
2	5.1.2 Төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлж, хариуцлага, үр дүнг тооцох арга хэлбэрийг сайжруулж, мэдлэг, хандлагад суурилсан “Мэргэшсэн төрийн албан хаагч” -даар бүрдүүлж ажиллана.	<p>Төр, төсвийн 12 байгууллагад 273 төрийн албан хаагч, үйлчилгээний ажилтан ажиллаж байна. 7 байгууллагын Ёс зүйн зөвлөлд 34 албан хаагч гишүүнээр ажиллаж, Зөвлөл бүр тайлант онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулан ажиллаж байна.</p> <p>Засаг даргын Тамгын газар болон Захирагчийн албанд бий болсон 4 сул орон тооны захиалгыг ТАЗ-ийн Салбар зөвлөлд хүргүүлж, төрийн албаны тусгай шалгалтад 4 иргэн тэнцэж ТАЗ-ийн салбар зөвлөлийн “Нэр дэвшүүлэх тухай” тогтоолын дагуу холбогдох албан тушаалд томилогдон ажиллаж байна.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн хүрээнд төрийн албан хаагч нар албан тушаалын чиг үүргийн хүрээнд хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хагас болон бүтэн жилээр ажлаа тайлагнан үнэлүүлж, үр дүнгээс шалтгаалан үндсэн цалингийн 40 хүртэл хувиар урамшуулал авч байна. 2023 оны байдлаар төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний 5 албан хаагч А, В үнэлүүлж 30-40 хүртэл хувийн урамшуулал олгосон байна.</p> <p>Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмын болзол хангасан 5 албан хаагчийн материалыг ТАЗөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлснээр аймгийн Засаг даргын 2023 оны А/100 дугаартай захирамжаар холбогдох зэрэг дэвийг олгосон. Мөн Төрийн албаны тухай хуулийн хүрээнд ТАЗөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлийн шийдвэрээр Ерөө сумын төрийн захиргааны 3 албан хаагч Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөлөө.</p> <p>Албан хаагчдыг мэргэшүүлэх зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтан бэлтгэх сургалтад 1, Архивын ерөнхий газрын архив бичиг хэргийн эрхлэгчийн мэргэшүүлэх сургалтад 1 албан хаагч, хамрагдлаа. Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2 албан хаагчийн хамруусан.</p> <p>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагддаг 7:4:10 вебинар 11 удаагийн сургалтад давхардсан тоогоор төр, төсвийн байгууллагуудын 486 албан хаагч хамрагдсан. Бусад салбарын хуулийн талаарх өөрчлөлт мэдлэгийг олгох 20 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1089 албан хаагч хамрагдсан байна.</p>	100%
3	5.1.3 Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай хүргэх, иргэдэд мэдээ мэдээллийг цаг алдалгүй мэдээлэх зорилгоор “Цахим Ерөө” хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнг дээшлүүлнэ.	<p>Төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, шуурхай хүргэж, цаг алдалгүй мэдээллээр хангах ажлын хүрээнд Ерөө сумын веб сайт /eruu.se.gov.mn/, Бугант тосгоны вэб сайт /bugant.se.gov.mn/, Ерөө сумын ЗДТГ-ын мэдээ цахим хуудас зэрэг мэдээллийн сувгуудыг идэвхжүүлэн, нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, албан хаагчдын харилцах утасны дугаар, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаягийг сумын вэб сайт, мэдээллийн самбар, албаны хэвлэмэл хуудаст байршуулж тайлант хугацаанд “Таныг сонсьё” (9 уулзалт, 68 өрх, 771 иргэн), Нээлттэй хаалга” (103 иргэн)-ны арга хэмжээгээр төрөөс баримталж буй бодлого шийдвэр, ажил үйлчилгээтэй</p>	100%

		<p>холбоотой 1080 гаруй мэдээ, мэдээлэл нийтэлсэн.</p> <p>Төрийн ажил үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнгийн талаар хэрэглэгчийн санал асуулгыг салбар бүрд цахимаар 4, санал асуулгын хуудсаар 1 удаа явуулж нийт 772 өрх, иргэнээс санал авч дүн шинжилгээ хийн ажил үйлчилгээндээ тусган хэрэгжүүлэн ажилласан. Иргэдээс ирсэн санал хүсэлтийн дийлэнх нь хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, сумын өнгө үзэмж, ажлын байрны санал санаачилга байна. Сумын төр, төсвийн байгууллагуудын ажил үйлчилгээ хангалттай хэмжээнд үнэлэгдсэн.</p> <p>Тоон гарын үсгийн тухай хууль, түүнийг хэрхэн авах, ашиглах, ач холбогдол талаар цахимаар болон хурал, зөвлөгөөнөөр хүргэж ажилласнаар Цэцэрлэг, Эмнэлэг, ЗДТГазар, Соёлын төв, ХААН, Төрийн банкууд, 12 жилийн сургуулийн сурагчид бүрэн хамрагдаж 552 иргэн тоон гарын үсгээ авснаас 345 нь иргэний үнэмлэхээр, 207 иргэн мобайл апп.аар авсан ба сумын нийт 16-аас дээш настай иргэдийн 68,9 хувь буюу 1352 иргэн тоон гарын үсгээ авснаар цахим орчинд иргэд өөрсдийн мэдээллийг хамгаалах, өөрийгөө таниулах, төрийн үйлчилгээг авах боломж бүрдэж байна.</p> <p>Мөн иргэний гадаад паспортын үйлчилгээг сумдад нэвтрүүлэх зорилтын хүрээнд 957000 төгрөгийн өртөг бүхий гэрэлтүүлгийн төхөөрөмжийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлүүлснээр иргэд гадаад паспортыг сумандаа захиалан авах боломж бүрдэж байна.</p>	
4	5.1.4 Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг цахимаар хүлээн авч, хариуг нь өгөх арга хэлбэрийг нэвтрүүлж гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллана.	<p>Төрийн байгууллагад хандсан иргэний өргөдөл, гомдлыг цаасаар болон цахимаар хүлээн авч бүртгэлжүүлэн шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. 3 дугаар улирлын байдлаар 139 өргөдөл хүлээн авснаас шийдвэрлэсэн 128, хүлээгдэж байгаа 11, шийдвэрлэлт 90 хувьтай байна. Нийт өргөдөл, гомдол, санал хүсэлтийг ирсэн хэлбэрээр нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> • Бичгээр- 114 • Утсаар хандсан - 9 • Биечлэн уулзсан – 16 байгаагаас харахад ихэнх өргөдөл, гомдлыг бичгээр гаргасан байна. 	90%
5	5.1.5 “Сумын архив”-ын байрыг засварлаж, зориулалтын техник тоног төхөөрөмжөөр хангаж тохижуулна. Үйл ажиллагааг нээлттэй явуулна.	<p>Сумын архивын байрыг засварлах, зориулалтын техник, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг орон нутгийн төсвийн 19,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Ногун” ХХК шалгарч гүйцэтгэлээ. Тус ажлаар архивын сан хөмрөгийг хадгалах зориулалтын тавиур, иж бүрэн компьютер, түргэн скайнер, хагас автомат үдэгч, архивын зориулалттай шат, баримт ариутгагч, цаас хэрчигч зэрэг тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй боллоо.</p>	100%
6	5.1.6 Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг анхан шатны нэгж болох баг, тосгоны бие даасан байдлыг бэхжүүлж, багийн төвийн байрыг ашиглалтад оруулж төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.	<p>Ерөө сумын 1, 2-р багийн “Багийн төвийн байр”-ыг түшиглэн малчдад төрийн үйлчилгээг хүргэх “Таныг сонсьё” арга хэмжээг 2 удаа зохион байгуулж 42 өрхийн 56 иргэнийг хамруулсан.</p>	70%
7	5.1.7 Баянголын хэсэгт малчдад мэдээлэл өгөх “Багийн төв”-ийн байрыг шинээр байгуулна.	<p>Баянгол хэсэгт багийн төв барих ажлын 115.0 сая төгрөгийн төсвийг “Сэлэнгэ эгшиг” ХХК-аар гүйцэтгүүлсэн.</p>	30%
8	5.1.8 Төрийн албан хаагчдын ажлын арга туршлагыг харилцан солилцох бүсийн уулзалт цугларалтыг жил бүр зохион байгуулж бие биенээсээ суралцах боломжийг бүрдүүлнэ.	<ul style="list-style-type: none"> • Жил бүр уламжлан болгон зохион байгуулагддаг “Ерөө бүсийн төрийн албан хаагчдын спортын нөхөрсөг тэмцээн”-н 2023.10.13-14-ны өдрүүдэд Хүдэр суманд зохион байгуулагдлаа. • Бугант тосгоны захирагчийн алба Хэрх тосгонд зохион байгуулагдсан тосгодын уулзалтад оролцсон. • Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын лаборатори 4-р сургуулийн багш нар Medle.mn платформд цахим хичээл байршуулах ажлын хүрээнд “Цахим хичээл боловсруулах арга зүй” сэдэвт сургалтыг Ерөө ЕБСургууль дээр зохион байгуулан багш нар харилцан туршлага судалж ажиллалаа. • Англи хэлний багш Н.Энхцэцэг СИИ сургалтын сургагч багшаар Булган аймагт 2023 оны 11-р сарын 8-11 хүртэл ажиллаж туршлагаа түгээн дэлгэрүүлсэн. • “Багш солилцоо” хөтөлбөрийн хүрээнд Дархан-Уул аймгийн 11 дүгээр цэцэрлэгийн ахлах бэлтгэл бүлгийн багш Б.Нордогсүрэн, Б.Ариунцэцэг нарын 2 өдрийн үйл ажиллагаатай 1-р цэцэрлэгийн багш 	100%

		Т.Майцэцэг, Д.Түмэнжаргал, Эрхлэгч Д.Туул нар танилцаж, багшийн хөгжлийг дэмжих, хүүхэд бүрийг хөгжүүлэх сургалтын арга зүйг сайжруулах, багш нар харилцан бие биеэсээ суралцах, туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлэх ажлыг хийсэн.	
9	5.1.9 Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг эрэлт, хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцүүлэн сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж төр, төсвийн байгууллагын “Шинэ залуу боловсон хүчнүүдийн нийгмийн асуудал” -ыг бодлогоор дэмжинэ.	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд 3 төрийн албан хаагчийн орон сууцны барилгын ажилд зориулж 80 ширхэг палкийг үнэ төлбөргүй олгосон, 16 албан хаагчид 59 толгой ямааг хямдралтай үнээр олгосон. Мөн 16 албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулсан. Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар “Ерөө цагдаагийн албан хаагчийн байр” төсөл арга хэмжээний ажилд 39,5 сая төгрөгөөр “Халиун уул” ХХК шалгарч 5 давхар орон сууцны 5 давхарт 45 м2 талбай бүхий 2 өрөө орон сууцыг Ерөө Цагдаагийн хэсэгт хүлээлгэн өгсөн. Ахуйн түймэрт байшин нь шатсан 2 албан хаагчид сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс тус бүрт 1000.0 сая төгрөг олгосон. Төрийн албан хаагчийн шинэ төрсөн хүүхэд, ар гэрийн буяны ажил болон тэтгэвэрт гарсан нийт 10 албан хаагчид 3,1 сая төгрөгийн мөнгөн тусламж, 5 албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгосон.	100%
10	5.1.10 Аливаа эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах зорилгоор сумандаа “Онцгой байдлын хэсэгтэй” болох асуудлыг холбогдох шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.	Сумын гамшгаас хамгаалах штаб, мэргэжлийн ерөнхий анги болон гал унтраах сайн дурын бүлгийн гишүүнээр давхардсан тоогоор 98 албан хаагч болон иргэд томилогдсон. Онцгой нөхцөл байдалд ашиглах тусгай зориулалтын гал унтраах 1, бохирын 1, хогны 1, өөрөө өргөгчтэй 1 машин, 3 механизм болон түймэртэй тэмцэх үлээгч, хөөсөн хор болон бусад хэрэгслүүдийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Тусгай зориулалтын тээврийн хэрэгслүүд ялангуяа гал унтраах машин дулаан грашт бэлэн байдалд байх шаардлагатай тул 9x17x3,5 харьцаатай грашийн ажлыг “Төгөлдөр-Ерөө ОНӨААТҮГазар” барьж бүрэн ашиглалтад оруулсан. Цаашид манай суманд онцгой нөхцөлд ажиллах мэргэжлийн албан хаагч шаардлагатай тул суманд Онцгой байдлын хэсэг болон ажилтан ажиллуулах тухай хүсэлт албан бичгийг аймгийн Засаг дарга болон Онцгой байдлын газарт хүргүүлээд байна.	90%
11	5.1.11 Гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, нийгмийг хамарсан цар тахлын эрсдэлийг бууруулах зорилгоор шаардлагатай, “Нөөц хөрөнгийг төвлөрүүлэн төсөөт суулгах” , багаж техник, тоног төхөөрөмж, хувцас хэрэгслээр албан хаагчдыг хангах ажлыг шат дараатайгаар авч хэрэгжүүлнэ	Ерөө сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, Ерөө сумын Засаг даргын 2023 оны А/104 дугаартай захирамжаар Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийх ажлын хэсэг байгуулж Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын мэргэжилтэн, дэслэгч Б.Анхныбаярын заавар, чиглэлээр Ерөө сумын гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийсэн. Сумын Засаг даргын 2023 оны А/105, А/106, А/156 дугаартай захирамжаар Сумын онцгой комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, Гамшгаас хамгаалах сайн дурын ажилтныг бүртгэх, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах ажлын хэсэг, сайн дурын ажилтны ажлын чиг үүрэг, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг тус тус байгуулж, сайн дурын хэсгийн гишүүдэд чиг үүргийг танилцуулан баталгаажуулсан. Зарлан мэдээллийн дохио дамжуулах СИРЕНЬ дохиоллын төхөөрөмжийг сумын ЗДТГ-ын өмнөх талбайд байрлуулж бэлэн байдлыг хангалаа. Зарлан мэдээллийн дохиогоор аюулгүй байдлаа ханган гэр, ажлын байраа орхин гарах, аюулгүй цэгт цугларах арга ажиллагааны дадлагыг 1 удаа хийллээ. Сумын онцгой комисс, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд тодотгол хийж томилгоожуулан, техник хэрэгсэл, багажийн жагсаалтыг гаргалаа. Гамшгийн дайчилгаа зарласан үед татан нийлүүлэх бараа, бүтээгдэхүүнээр хангах гэрээг Хүнсний 3 дэлгүүр, Шатахуун түгээх 1 станц, 1 эмийн сантай байгуулж баталгаажуулсан. Гамшгийн үед дайчлах хүн, хүч, техник хэрэгсэл, шатахуун, хоол хүнс, орон байр, зэрэг 17 төрлийн судалгааг тодотгон гаргасан. Гамшгаас хамгаалах команд штабын сургалтын бэлтгэл ажлыг ханган 2023 оны 6 сарын 7,8-ны өдрүүдэд сургалтад хамрагдаж, “Газар хөдлөлтийн гамшгийн үеийн хариу арга хэмжээ” команд штабын сургуулиар өгөгдсөн цагийн байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийж өгөгдсөн цагуудад авах хариу арга хэмжээг авч мэдээллийг аймгийн онцгой комисст тухай бүр хүргүүлэн ажилласан. 2023 оны 6-р сарын 08-ны өдрийн 16:00 цагт гамшгийн зарлан мэдээллийн дуут дохиог 1 минутын хугацаатай 3 удаа дуугарган, түр цуглах талбайд нүүлгэн шилжүүлэх дадлага сургуулийг	90%

		<p>зохион байгууллаа. Тус ажиллагааны хүрээнд сумын төвд түр цуглах 11 цэг, Бугант тосгоны цугларах талбайд гамшгаас хамгаалах дуут дохиогоор түр цугларах цэгт нүүн шилжих дадлага ажил хийгдэж гүйцэтгэлийн хувь 38.5 хувьтай байлаа. Цугласан иргэдэд гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлын талаар мэдээлэл өгч тус ажилласан.</p> <p>1. Аймгийн Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн "Хяналт шалгалт зохион байгуулах тухай" А/154 дүгээр захирамжийн дагуу Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, хошууч Г.Батсүхээр ахлуулсан ажлын хэсэг 4 дугаар сарын 10, 11-ны өдрүүдэд Ерөө суманд ажиллалаа.</p> <p>Ажлын хэсэг болзошгүй гамшгийн аюул, хүн ам, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд аж ахуй нэгж, байгууллага, иргэдийг сургах, харилцан ажиллагааг сайжруулах, 2023 оны 6 дугаар сард зохион байгуулагдах стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор бэлэн байдлын үзлэг, хяналт шалгалт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж сургалт зохион байгууллаа.</p> <p>Ерөө сумын Засаг даргын Тамгын газраас Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газарт уламжилсан хүсэлтийн дагуу "ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХҮҮДИЙН ГАЛ ТҮЙМРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ" 2023 оны 04 дүгээр сарын 10 өдөр зохион байгуулагдлаа. Тус ажлын хүрээнд Онцгой байдлын газрын 21 албан хаагч, Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын 9 албан хаагч, "ДСЦШС"ХХК-ны 3 албан хаагч, 1,2-р багийн хэсгийн дарга нартай хамтран Ерөө сумын 473 айл өрхөд галын аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг хийж, пийшин, зуух, яндангийн аюулгүй байдал, стандарт, норм, нормативыг мөрдүүлэх, галын аюулгүй ажиллагааны зааварчилгааг таниулан сурталчлах ажлыг зохион байгууллаа.</p> <p>Онцгой комиссын гишүүд болон ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах тухай" сургалтад хамрууллаа.</p>	
12	5.1.12 Бугант тосгоны Захирагчийн ажлын албаны байрыг өргөтгөх ажлыг хийж гүйцэтгэнэ.	<p>Бугант тосгоны захирагчийн албаны барилгын дээвэр их хэмжээний бороо орж дусаал гоожсоноор төрийн үйлчилгээг хэвийн явуулах боломжгүй болсон тул сумын ИТХ-ын 2023 оны 8 сарын 16-ны өдрийн 115 дугаартай тогтоолоор сумын төсвийн 20,0 сая төгрөг, нийгмийн хариуцлагын хүрээнд ойн мэргэжлийн байгууллагуудын хандиваар 20,0 сая буюу нийт 40,0 сая төгрөгийн өртөгтэй мембран дээврээр солих ажлыг "Азийн баялаг" ХХК 100% гүйцэтгэсэн. 401,0 сая төгрөгийн өртөгтэй барилгын өргөтгөлийн зураг төсвийг "Зөв чиглэл" ХХК гүйцэтгэсэн.</p>	70%
13	5.1.13 Шаазгайтын багийн төвийн байрыг ажиллуулах.	<p>Ерөө сумын 1, 2-р багийн "Багийн төвийн байр"-ыг түшиглэн малчдад төрийн үйлчилгээг хүргэх "Таныг сонсьё" арга хэмжээг 2 удаа зохион байгуулж 42 өрхийн 56 иргэнийг хамруулсан.</p>	100%
5.2 ИРГЭНД ЭЭЛТЭЙ ТӨР			
1	5.1.1 Иргэний эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд "Нийтийн сонсголын цаг" арга хэмжээг сар бүрийн 3 дахь 7 хоногт зохион байгуулж иргэдэд хууль эрхзүйн мэдлэгийг олгоно.	<p>Иргэний эрхзүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> o Монгол Улсын Үндсэн хуулийн талаарх ойлголт мэдлэгийг цахимаар сурталчилж, Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ. o Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах болон бусад хуулийн талаар зөвлөгөөг 12 иргэнд, цахимаар 24 төрлийн мэдээлэл хүргэж ажилласан. o Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагддаг 7:4:10 вебинар сургалт 11 удаа зохион байгуулагдахад давхардсан тоогоор 486 албан хаагч хамрагдсан. o Бусад салбар салбарын хуулийн талаарх өөрчлөлт мэдлэгийг олгох 20 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1089 албан хаагч хамрагдсан. <p>Нийтийн сонсголын цагийг малчид, багийн хэсгийн дарга нар, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд, бичил уурхай эрхлэгч нар, сурагчдад, төрийн албан хаагчдад гэсэн бүлгээр зохион байгуулж 430 иргэнд орон нутагт хийгдэж байгаа ажил, төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг танилцуулж, санал хүсэлтийг сонсож ажиллалаа.</p>	90%

		<p>о “Таныг сонсъё” аяныг зохион байгуулж 76 өрхийн 128 иргэнд цаг үеийн мэдээ мэдээллийг хүргэж холбогдох төрийн үйлчилгээг үзүүлж ажилласан.</p> <p>о “Малчдын өдөрлөг”, “Малчин залуусын өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулснаар 151 малчин оролцож мал аж ахуйн талаар төрөөс баримталж буй бодлого шийдвэр, малын үүлдэрлэг, эрчимжсэн байдалд хэрхэн анхаарч ажиллах, малчид, тариаланчдын дунд үүсдэг зөрчлийг хэрхэн зохицуулах вэ зэрэг асуудлыг ярилцаж санал бодлоо солилцон, харилцан арга туршлагаа хуваалцсан арга хэмжээ болсон байна.</p>	
2	5.2.2 Улсын бүртгэлийн ажил үйлчилгээний шуурхай байдлыг хангаж, цахим үйлчилгээний төрлийг сурталчлах замаар бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэх боломж нөхцөлийг бүрдүүлэн ажиллана.	<p>“Цахим үндэстэн” хөтөлбөрийн хэрэгжилт, цахим үйлчилгээний төрлүүдийг сурталчлах, E-MONGOLIA портал сайтаас үйлчилгээ авах заавар, цахим гарын үсгийн тухай хууль, цахим гарын үсгийг ашиглах, ач холбогдол, хэрхэн авах талаар видео хичээлүүд, бусад мэдээллийг бэлтгэн Ерөө. Бугантын цахим хаягууд, төсвийн байгууллагын ажиллагсад танхимаар хүргэж ажилласан.</p> <p>Улсын бүртгэлд бүртгэлийн эх нотлох баримтуудыг цахимжуулах, тоон гарын үсгийг олгох ажлууд шинээр нэвтэрсэн нь иргэд бүртгэлийн үйлчилгээг шуурхай авах, хэзээ ч хаанаас авч болох цахим үйлчилгээнүүд бүрэн нэвтэрсэн.</p> <p>Тайлант хугацаанд 640 иргэнд иргэний бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, 545 иргэнд тоон гарын үсэг олгож 131 иргэнд эд хөрөнгийн бүртгэлийн, 18 иргэнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр зөвлөгөө өгч, 490 иргэнд гарын авлага, зөвлөмжөөр, 51 иргэнд танхимаар, 200 орчим иргэнд цахимаар хууль эрхзүйн сургалт сурталчилгаа хийсэн байна хууль эрхзүйн сургалт сурталчилгаа хийн ажиллалаа.</p>	100%
3	5.2.3 Төрийн үйлчилгээний “Хур” системээр дамжуулан иргэдэд лавлагаа мэдээллийг үзүүлж, төрийн үйлчилгээг ойртуулна.	<p>Төрийн үйлчилгээний оператороос Төрийн үйлчилгээний e-mongolia буюу Хур системээр дамжуулан иргэдэд лавлагаа мэдээллийг тогтмол олгон ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд :</p> <ul style="list-style-type: none"> • Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа – 105 • Оршин суугаа хаягийн лавлагаа – 30 • Иргэний үнэмлэхийн лавлагаа - 53 • Зээлийн лавлагаа – 3 • Жолоочийн лавлагаа – 5 • Үл хөдлөх хөрөнгөтэй эсэх лавлагаа- 5 • Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоосон акт-1 • Төрсний бүртгэлийн лавлагаа-1 • Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа-1 • Хүүхдийн төрсний лавлагаа-4 • Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагаа-3 • Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт-2 • Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт- 1 • Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэлгүй тухай тодорхойлолт-1 нийтдээ 215 төрлийн лавлагаа мэдээллийг тус тус олгоод байна 	100%
4	5.2.4 Бугант тосгоны бүртгэлийг улсын бүртгэлийн “Нэгдсэн сүлжээнд холбох” ажлыг хийж гүйцэтгэнэ.	Бугант тосгоны улсын бүртгэлийн мэдээллийг 2021 онд “Нэгдсэн сүлжээнд холбосон. Улсын бүртгэлийн цахимаар хүргэх үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.	100%
5	5.2.5 Бугант тосгонд “АТМ “ суурилуулах ажлыг холбогдох байгууллагад уламжилна		0%
6	5.2.6 ЗДТГ-ын дэргэдэх “Иргэний танхим”-ыг интернэтэд холбож, шаардлагатай хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмжөөр ханган иргэд цахим орчноос мэдээлэл авах нөхцөл бололцоог	ЗДТГ-ын иргэний танхимыг интернэтэд холбож цахим хурал хийх зориулалттай төхөөрөмжөөр ханган байнгын үйл ажиллагаа явуулж байна. Иргэний танхимд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах ажлыг орон нутгийн төсвийн 13,6 сая төгрөгийн өртгөөр Магнай жонон ХХК гүйцэтгэлээ. Цахим төхөөрөмжөөр дамжуулан 46 удаагийн хурал, цуглаан, 48 удаагийн цахим сургалтыг тус тус зохион	100%

	хангана.	байгуулсан байна.	
7	5.2.7 Сум, тосгоны гудамж талбайд “Гэрэлт Мэдээллийн самбар” шинээр хийж байрлуулан иргэдийг шаардлагатай мэдээ мэдээллээр түргэн шуурхай хангаж ажиллана.	Сумын төвийн 6 байршилд Гэрэлт мэдээллийн самбар хийх ажлыг ОНХСангийн 16,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Лайт бокс монголиа профейшнл” ХХК гүйцэтгэн хүлээлгэн өглөө. Бугант захирагчийн алба гэрэлт мэдээллийн цахим урсдаг самбараар иргэдэд мэдээллийг хүргэн ажиллаж байна.	100%
8	5.2.8 Авлигаас урьдчилан сэргийлэх, иргэдийг соён гэгээрүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлж “Авлигагүй орчин бүрдүүлнэ”	“Авлигын эсрэг нэгдье” соён гэгээрүүлэх аяны хүрээнд “АВЛИГЫН ЭСРЭГ НЭГДЬЕ” анонс хэвлүүлэн байршуулсан. Мөн байгууллагын цахим хуудсанд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 17 төрлийн мэдээ мэдээллийг иргэдэд тогтмол хүргэн ажиллаж байна. “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлын тухай” сургалтыг Засаг даргын Тамгын газрын албан хаагчид болон төр, төсвийн байгууллагын дарга эрхлэгч нийт 43 ажилтан албан хаагчдад хүргэсэн. Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр алба хаагчдаас ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх тухай баталгаа авч, ажлын чиглэлийг өгч ажилласан. Мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-л зааснаар эрх бүхий 23 алба хаагчийн хөрөнгө оруулгын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүргүүлсэн. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд алба хаагчдын мэдлэгийг шалгах шалгалтыг цахимаар авсан.	90%
9	5.2.9 Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх , нийгмийн хэв журмыг сахиулах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, “Иргэд, олон нийттэй хамтарч” ажиллана.	Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан “Анхаар хүүхэд”, “Илрүүлэлт-Шийдвэрлэлт”, “Мал хулгайлах ГХУС”, “Мод”, “Нуугдмал”, “Оргодол-1”, “Үзлэг шалгалт”, “Хяналт”, “Хүн бүр байгаль хамгаалагч”, “Уусан бол бүү жолоод”, “Анзаар”, “Мал мах-2023”, “Зэвсэг-2023”, “Зөрчлийн шийдвэрлэлт”, “Илрүүлэлт-Оргодол-Шийдвэрлэлт” зэрэг нөлөөллийн арга хэмжээг хариуцсан сум орон нутгийн хэмжээнд зохион байгуулан, эргүүл хяналт шалгалтаар 150 удаа 900 цагийн давхардсан тоогоор 1200 алба хаагч эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 650 зөрчлийг илрүүлэн 51.473.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 70 зөрчил илрүүлэн ЗТХ-ийн 14.7 дугаар зүйлийн 3 дах хэсгийн 3.1 дэх хэсэгт заасан 1 жил эрх хасах 400 нэгжээр торгох арга хэмжээ авч шийдвэрлэсэн бол захиргааны журмаар 31 иргэнийг аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр оруулж 7-30 хоногийн хугацаатай баривчлуулах шийтгэл оногдуулсан байна. Ерөө суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага иргэнд тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 10 төрлийн 2023001, 07, 23, 27, 34, 36, 39, 68, 72, 73 дугаартай мэдэгдэл хүргүүлж, үр дүнг тооцсон. Цагдаагийн байгууллагаас өгсөн мэдэгдлийн хүрээнд мод бэлтгэн нийлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Номин Од ХХК, ЭБНЗ ХХК, Сэлэнгэ Бугант ХХК, Монгол улсын стандарт MNS 6423:2019 шаардлага хангасан 35 ширхэг 35.000.000 төгрөгний хяналтын камер суурилуулсан. Мөн Ерөө сумын 3 дугаар баг Бугант тосгоны нутаг дэвсгэр гудамж талбай олон нийтийн газарт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийгмийн хариуцлагын хүрээнд модны аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл 12.893.500 төгрөгийн өртөг бүхий 7 чиглэлд 19 хяналтын камер /чигийн 16, 360 градус эргэдэг 3/ тавьж суурилуулан, Бугант тосгоны цагдаагийн хэсэгт хүлээлгэн өгсөн. Сэлэнгэ аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга Б.Нарантуяагийн 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 40 дугаартай “Хамтдаа шалгая, хамгаалъя” арга хэмжээ зохион байгуулах тухай, мөн аймгийн Засаг даргын энэ оны 03 дугаартай албан даалгаврын хүрээнд хүүхдийг ахуйн осол гэмтэл, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, орчны эрсдэлийг бууруулах чиглэлээр сум, тосгоны хамтарсан баг, төр төсвийн байгууллагын ажилтан, алба хаагч нарыг цагдаагийн алба хаагчдын хамтаар нэгдсэн эргүүлийн хуваарьт оруулсан. Эргүүл хяналт шалгалтад өнөөдрийн байдлаар 38 удаа давхардсан тоогоор 131 алба хаагч, 152 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэн, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж болзошгүй айл өрх, хараа хяналт сул	100%

		<p>хүүхдийн гэрээр орж, ярилцлага зохион байгуулсан. Мөн хүүхэд унаж бэртэж болзошгүй ухсан нүх, цахилгааны ил гарсан утас, эвдэрсэн тоглоом болон золбин нохойнуудын судалгааг гаргаж, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар эрх бүхий байгууллагад мэдэгдсэний дүнд Бугант тосгонд нохой устгах тухай Захирагчийн албанаас шийдвэр гаргуулан ажилласан.</p> <p>Улсын хэмжээнд зохион байгуулж байгаа “Анзаар” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Цагдаагийн Ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас Ерөө сумын ерөнхий боловсролын сургуулийн 200 сурагч, 100 гаруй эцэг, эх, багш сурган хүмүүжүүлэгч нарт “Хар тамхины өнөөгийн нөхцөл байдал, сөрөг үр дагавар” сэдэвт сургалтыг зохион байгуулахад тус цагдаагийн тасгийн алба хаагчид хамтран ажилласан.</p> <p>Мөн ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газар, Урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэн гаргасан видео шторк, контентыг тухай тасгийн пейж хуудас, алба хаагчид өөрсдийн фейсбүүк хаягаас сумын олон дагагчтай группүүдэд түгээлт хийж, олон нийтэд сурталчилж ажилласан.</p> <p>Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нартай хамтран 7 удаагийн 96 цагийн эргүүл, хяналтын шалгалтын ажлыг зохион байгуулж, хууль бусаар ашигт малтмал олборлосон 8 гэмт хэргийн шинжтэй үйлдлийг илрүүлэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.</p> <p>Сэлэнгэ аймгийн прокурорын газар, Ерөө сумын цагдаагийн тасгаас сум, тосгоны иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, шалтгаан нөхцөлийн талаар энэ оны 05 дугаар сарын 29-ны өдөр Бугант тосгоны соёлын төвд сургалт орж, нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулсан. Энэхүү сургалтаар Монгол улсын Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэгт хамаарах хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн тухай ойлголт, хуулийн хариуцлагын талаар дэлгэрэнгүй байдлаар сургалт зохион байгуулж, 80 орчим иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл хамрагдсан.</p> <p>Хариуцсан сумын хэмжээнд энэ оны 11 сарын байдлаар 53 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 27 нэгжээр буюу 33.7 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.</p>	
10	5.2.10 Архидан согтуурахтай тэмцэх хяналт шалгалтыг тогтмолжуулж, “Архигүй орчин” хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдэд энэ талын мэдлэг мэдээллийг олгож хамтарч ажиллана.	<p>Хариуцсан суманд архи согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэдэг, архины хамааралтай 6 иргэнийг 05 дугаар сарын 18-ны өдөр архины албадан эмчилгээнд хамруулах ажлын хүрээнд аймгийн эрүүл мэндийн төвийн нэгдсэн эмнэлгийн эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.</p> <p>Архины албадан эмчилгээнд явуулахаар эмнэлгийн үзлэгт хамруулсан боловч эрүүл мэндийн шалтгаанаар тэнцээгүй архины хамааралтай гэр бүлийн хүчирхийлэл удаа дараа үйлдэн шүүхээр 2023 онд 2 удаа арга хэмжээ авагдаж байсан Ерөө сумын иргэн Ж.Баттөмөрийг 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдөр Ерөө сумын хэсгийн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Ганзориг сумын ГХУСАЗСЗөвлөл, Хамтарсан багтай хамтран эмчилгээний 650.000 төгрөг, 50 литр шатахууныг шийдүүлж, Дархан-Уул аймгийн СЭМҮТөвийн наркологийн тасагт хүргэн архины сайн дурын эмчилгээнд хамруулсан.</p> <p>Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаартай албан даалгавар, мөн даргын А/519 дугаартай захирамжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Бугант тосгоны Захирагчийн алба, хяналтын камерын Прожект девелопмент тотал соллюшнс ХХК-тай хамтран энэ оны 11 дүгээр сарын 09-ны өдөр Ерөө сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын танхимд, 11-р дүгээр сарын 10-ны өдөр Бугант тосгоны соёлын төвд хариуцсан сум орон нутагт архи согтууруулах ундааны зүйл худалдан борлуулдаг болон түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагад Монгол улсын Зөрчлийн тухай хууль, Архи согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай, Монгол улсын хяналтын камерын стандарт MNS 6423:2019, “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн тухай ойлголт, хууль эрх зүйн орчин”, Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаартай албан даалгавар, А/519 дугаартай Захирамжийн талаар яриа таниулга хийж, стандартын шаардлага хангасан хяналтын камер тавих талаар тасгийн даргын 72,73 дугаартай хугацаатай мэдэгдэл хүргүүлсэн.</p>	100%

11	<p>5.2.11 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор “Хамтарсан баг”-ийн хяналтын үйл ажиллагааг сайжруулж, хамтарч ажиллана.</p>	<p>Гэр бүл, хүүхдийн хүчирхийлэлтэй тэмцэх зорилгоор сумын хэмжээнд 2 хамтарсан баг ажилладаг. Ерөө сумын хамтарсан баг нь Ерөө сумын Засаг даргын баталсан хамтарсан багийн 2023 оны ажлын төлөвлөгөөнд заасан 36 төрлийн ажил арга хэмжээг хэрэгжүүлэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бусаар нийтдээ 23 удаа хуралдсан.</p> <p>Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах үүрэг бүхий хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах чиглэлээр аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 4 удаа, Дэлхийн зөн ОУБ-аас 2 удаа зохион байгуулсан сургалтад тус тус хамрагдсан.</p> <p>УИХ-ын гишүүн Б.Өнөрболорын санаачилгаар зохион байгуулсан Сэлэнгэ аймгийн 17 сум 6 тосгоны хамтарсан багийн гишүүдийн сэтгэл зүйн сургалтад 150 орчим гишүүд хамрагдсан ба уг сургалт Ерөө суманд зохион байгуулагдсан.</p> <p>Хүүхдийн тусламжийн 108 утсанд 5 дуудлага мэдээлэл ирснийг 100 хувь шийдвэрлэн дуусгавар болгосон. Хамтарсан багийн гишүүдийн илрүүлсэн 11 мэдээлэлд кэйс нээн ажиллаж 10 кэйсийг дуусгавар болгосон, одоогийн байдлаар 1 идэвхтэй кэйсийн үлдэгдэлтэй байгаа ба Зөрчлийн тухай хуулиар 5 кэйс шийдвэрлэгдсэн.</p> <p>Ерөө сумын Хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлснээр 2021-2023 онд гэр бүл, хүүхдийн хүчирхийллийн дуудлага 14 хувиар буурч, илрүүлэг жилд дунджаар 8-12-ийн хооронд хэлбэлзэж байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийг хувийн хэрэгжүүлэн нэг бүрчлэн төлөвлөгөө гарган ажилласнаар гэр бүлийн хүчирхийлэл 82,8 хувь, эрсдэл 40 хувиар тус тус буурсан. Архины хамааралтай иргэдийн зан үйлд нөлөөлснөөр 2023 онд 5 иргэн архинаас гарсан.</p> <p>Хамтарсан баг нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйл, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлүүдэд заасан үйлчилгээнүүдийг үзүүлэн ажиллалаа. Үүнд</p> <ol style="list-style-type: none"> 1. Эргүүл хяналтыг давхардсан тоогоор 14 өрхийн 49 хүүхдийн аюулгүй байдалд 23 удаа үзүүлсэн. 2. Холбон зуучлах үйлчилгээг- 12 иргэнд 3. Сэтгэл зүйн үйлчилгээг 15 иргэнд 4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг 11 иргэнд 5. Нийгмийн халамжийн үйлчилгээг 5 иргэнд 6. Эрх зүйн туслалцааны үйлчилгээг 118 иргэнд 7. Буруутай этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх үйлчилгээг 5 иргэнд 8. Хамтарсан багийн хурлаар иргэн гэр бүлийг оруулах үйлчилгээг 3 гэр бүлд үзүүлсэн. <p>Хамтарсан баг нь Хууль зүй дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк хамтран хэрэгжүүлж буй G9198/9221 MON “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд аймгийн хэмжээнд зохион байгуулсан Шилдэг хамтарсан баг болзолт уралдаанд 2023 оны ажлаараа шалгарч ДЭД БАЙР эзэлсэн.</p> <p>Мөн Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас “Хүчирхийлэлгүй аймаг” зорилтын хүрээнд 2022 оны ажлаараа “Шилдэг сум”-аар шалгарсан.</p>	100%
12	<p>5.2.12 Хүүхдийг цахим гэмт хэрэг, мэдээллийн хадлага, ахуйн ослоос урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг зохион байгуулж, энэ талын мэдлэг мэдээллийг эцэг, эх, хүүхдүүдэд байнга өгч, хамтарч ажиллана.</p>	<p>Хүүхэд гэмтэж бэртэж болзошгүй хүүхдийн тоглоомын талбай, тоглоом, ухсан нүх, овоолго шороо, эзэнгүй орхигдсон объект зэрэг газруудаар хамтарсан багийн гишүүдийн хамт хяналт шалгалтыг 1 удаа зохион байгуулсан ба 2024 онд стандартын шаардлагад нийцсэн 1 хүүхдийн тоглоомын талбай баригдахаар төлөвлөгдсөн.</p> <p>“Хичээл эхэллээ” аяныг хүрээнд Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн камерын бүрэн бүтэн байдлыг хянасан ба 2022 онд Цэцэрлэг, 2023 онд сургуулийг дуу болон дүрсийг хамт бичих хүчин чадалтай камераар камержуулсан.</p>	100%

		<p>2023 онд зохион байгуулагдсан хурдан морины “Eguu cup” уралдаанд 3 насны ангилалд 27 , Их Буурагчин хайрханы тахилгын уралдаанд 1 насны ангилалд 38, Үндэсний их баяр наадмын уралдаанд 9 насны ангилалд 211 хүүхэд уралдаж оролцсон ба давхардсан тоогоор 276 хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан.</p> <p>Иргэдээ соён гэгээрүүлэх чиглэлээр чиглэлээр хийгдсэн гэр бүлийн хүчирхийлэл, авлига, малын хулгай, цахим гэмт хэрэг, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, архидалт, замын хөдөлгөөний аюулгүй байдал, орон байрны хулгай, мансууруулах бодисын хор хөнөөл сэдэвт 10 төрлийн шторжийг “Сэлэнгэ Түмэн” пэйжийн сэтгүүлчээр 300,000 төгрөгийн өртөгтэйгөөр хийлгэн нийтэд түгээн ажилласан.</p>	
13	5.2.13 Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Малчдын бүлгэм” байгуулж, малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлнэ.	Малчин айл өрхүүдээр зочилж мал хулгайлах гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх таслан зогсоох цагдаагийн байгууллагатай хэрхэн хамтарч ажиллах талаар болон хөдөө хээр малын бэлчээрт бага оврын ачааны тээврийн хэрэгсэл зүс танихгүй хүн явсан тохиолдолд боломжтой бол утсаар зургийг нь дарж баримтжуулан тэмдэглэн авч цагдаагийн байгууллагад мэдээлэл дамжуулан хамтран ажиллах мөн ойр хотны малчин айл өрхүүдийн малд алдуул мал ирж нийлсэн эсэх талаар асууж тодруулан сонор сэрэмжтэй байх талаар ухуулга яриа хийн санамж сэрэмжлүүлэг тараан ажилласан. Мөн энэ чиглэлээр бэлтгэсэн нэвтрүүлэг, шторк, постерыг /Ерөө сумын нэгдсэн зар/, / Бугант тосгоны нэгдсэн зар/ гэх тус сумын хандалт ихтэй цахим хаягуудаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг тухай бүр нь хийж гүйцэтгэн ажилласан.	70%
14	5.2.14 Байгаль орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх , хууль тогтоомжийг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгжийн “Үйл ажиллагааг таслан зогсоож” , хяналтыг сайжруулж ажиллана.	<p>Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил тэр дундаа хууль бусаар мод бэлтгэх, хууль бусаар ан агнах зэрэг тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр Ерөө сумын нутаг дэвсгэрт мод бэлтгэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 17, Мандал сумын нутаг дэвсгэрт мод бэлтгэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг боловч Ерөө сумын нутаг дэвсгэрт ойн сан эзэмшдэг, мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулдаг 15, нийт 32 аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөлд энэ оны 01 дүгээр сарын 15-ны өдөр, 11 дүгээр сарын 09, 10-ны өдөр 3 удаа сургалт, яриа таниулга хийж, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Ерөө сумын цагдаагийн тасгийн даргын 07, 72 дугаартай мэдэгдлийг хүргүүлж үр дүнг тооцон ажилласан.</p> <p>Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Экологийн цагдаагийн алба, сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, ойн ангийн ажилтан, алба хаагч нартай хамтран 15 удаагийн 120 цагийн хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж ажилласан.</p> <p>Хууль бусаар ашигт малтмал олборлох төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хууль бусаар ашигт малтмал олборлож байгаад цагдаагийн байгууллагад шалгагдаж байсан болон үйлдэж болзошгүй 20 гаруй иргэнд “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн тухай ойлголт, хууль эрх зүйн орчин” сэдвээр сургалт зохион байгуулж, дахин энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил үйлдэхгүй байх тухай тасгийн даргын 23, 68 дугаартай, уул уурхай ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 10 аж ахуйн нэгж, байгууллагад 27, 39 дугаартай мэдэгдлийг хүргүүлж, үр дүнг тооцсон.</p> <p>Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр бүлэг, Зөрчлийн тухай хуулийн 7 дүгээр бүлэгт заасан Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн зүйл, заалтаар постер бэлтгэн, цагдаагийн тасгийн пейж хуудсанд давхардсан тоогоор 50 удаа нийтэлж, сумын хүн ихээр дагадаг фейсбүүкийн группт байршуулж, иргэд олон нийтэд сурталчлан ажилласан.</p> <p>Өнгөрсөн жил Ерөө сумын 3 дугаар баг Бугант тосгоны нутаг “Толгойтын даваа” гэх газарт их хэмжээний алт гарч, иргэд хууль бусаар ашигт малтмал олборлох төрлийн гэмт хэрэг үйлдэж, эрүү болон хэв журмын нөхцөл байдлыг хүндрүүлсэн. Үүнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын Захирамжаар түр</p>	100%

		<p>хяналтын цэг байгуулах, хамгаалалтад авсан. Өнөөдрийн байдлаар “Толгойтын даваа” хяналтын постонд аймгийн цагдаагийн газраас 4, Онцгой байдлын газраас 2, Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 1 нийт 7 алба хаагч 14 хоногийн хугацаатай ээлжлэн давхардсан тоогоор 2940 алба хаагч, 10080 цагийн үүрэг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналтын постод үүрэг гүйцэтгэж байна.</p> <p>“Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Ерөө сумын нутаг Харганатын ам, Могойн ам, Гозонгийн ам, Цамхаг, Өвөрзалаат, Угтаал зэрэг газарт “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-нь техникийн сэргээлт хийлгэх тендерийг 2022, 2023 онд зарлаж, “Жинжий майнинг” ХХК 800.7 га талбайд, “Тотал Идеал” ХХК 429.14 га талбайд, Ялбаг гэх газарт Оюу толгой ХК-ны тендерийн сонгон шалгаруулалтад “Бугант нандин” ХХК 208.8 га талбайгаас энэ онд 150.8 га талбайг, “Үзэгт Дэлгэрэх” ХХК 190 га талбайгаас энэ онд 116 га талбайг үүн дээр нэмээд нийгмийн хариуцлагын хүрээнд 1.6 га талбайд тус тус техникийн нөхөн сэргээлт хийсэн байна. Дээрх нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага 2023 онд нийт 1498.24 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж, захиалагч байгууллага болон сум орон нутагт нь хүлээлгэж өгөөд байна. Мөн тус аймагт уул уурхай, ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Ди зэт энд ай” ХХК, “Хонгорын орд” ХХК, “Цемент шохой” ТӨҮГ, “Чамин алт” ХХК, “Сонор трейд”, “Монлид” ХХК, “Бэрлэг майнинг” ХХК зэрэг аж ахуй нэгж, байгууллага ашиглалтын талбайдаа болон дүйцүүлэхээр Ерөө сумын нутагт нийт 28 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэн холбогдох албаны хүмүүст хүлээлгэн өгсөн байна</p> <p>Дээр ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажилласны үр дүнд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг энэ оны 11 сарын байдлаар 30 бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 17 нэгжээр буюу 36 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.</p>	
15	5.2.15 Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хууль дүрмийг сурталчлах, хяналт шалгалтыг сайжруулах чиглэлээр төрөл бүрийн ажил арга хэмжээг зохион байгуулан нийтэд сурталчилж, “Замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулна” .	<p>Хариуцсан сум орон нутгийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, тээврийн хэрэгсэл, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 200 удаа 600 цагийн эргүүл хяналтын шалгалтыг зохион байгуулж Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн 100 зөрчилд 33.485.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна. Үүнээс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 72 жолоочийн эрхийг 1 жилийн хугацаагаар хасч, жолоодон эрхийн үнэмлэхгүй согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 19 иргэнийг аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр оруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулах шийтгэл оногдуулсан байна.</p> <p>Насанд хүрээгүй хүүхэд зам тээврийн осол аваарт өртөж болзошгүй газрууд болон сургууль, цэцэрлэгийн орчим хүүхэд, зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлж эргүүл хяналт шалгалтыг тогтмол хийж гүйцэтгэн. Ерөө сумын ГХУСАЗСЗ-с 350.000 мянган төгрөгийн төсвийг гаргуулан Анхаар хүүхэд нөлөөллийн зурагт самбарыг хийлгэж ЕБС-н урд замын гарц хэсэгт байршуулсан.</p> <p>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ойр орчим хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллуулж буй “School police” буюу эцэг, эхчүүдийн эргүүлийн үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагаас өдөр тутам мэргэжил арга зүйгээр ханган, хамтран үүрэг гүйцэтгэж байна.</p> <p>Ерөө сум, Бугант тосгоны төвд сумын 100 жилийн ойг угтан төвд хатуу хучилттай асфальтан зам тавьсантай холбогдуулан 36 ширхэг замын тэмдэг, стандартын шаардлага хангасан 2 хурд сааруулагч, 5 явган хүний гарцыг шинээр будаж, хүлээлгэн өгсөн.</p>	100%
16	5.2.16 Бусдын эд хөрөнгийг залилах, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд энэ чиглэлийн мэдлэг мэдээллийг олгох ажлыг зохион байгуулж ажиллана	<p>Монгол улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын алба, Цагдаагийн Ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газар, Мөрдөн байцаах алба, Эрүүгийн цагдаагийн алба болон Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэн гаргасан видео шторк, зураг хуудас, зөвлөмжийг сумын хүн ихээр дагадаг фейсбүүк цахим хуудасны группт түгээж ажиллахын зэрэгцээ хүн ихээр явдаг томоохон худалдааны төв, зах, хүнсний дэлгүүр, Сумын Засаг даргын тамгын газар, Захирагчийн албаны мэдээллийн самбарт байршуулж, иргэд олон нийтэд мэдээ, мэдээлэл хүргүүлж ажилласан.</p> <p>Сумын Bugant zar, Бугант зарлал, Ерөө сумын зарлал, Ерөө сумын авто зарлал зэрэг хүн ихээр</p>	70%

		<p>дагадаг фейсбүүк цахим хуудсанд байршуулсан, цахим залилангийн шинжтэй байж болзошгүй 50 орчим мэдээ, мэдээллийг группийн админд хэлж, устгуулах ажлыг тухай бүр зохион байгуулсан.</p> <p>Мөн Ерөө сум, Бугант тосгоны төрийн алба хаагчдын цугларалт, иргэдийн уулзалт болон томоохон арга хэмжээнд цагдаагийн байгууллагаас цахим орчны залилан мэхлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар яриа таниулга тогтмол зохион байгуулж байгаа болно.</p> <p>Сүүлийн үед иргэд фейсбүүкийн нууц үгээ алдаж, хакердуулах улмаар тэдний фейсбүүкийн чатаар ойр дотны хүмүүсээс нь мөнгө нэхэх, гуйх, зээлэх нэрийдлээр цахим залилан мэхлэх гэмт хэргийн хохирогч болж байна. Иймд сумын иргэдэд ойр дотны хүмүүс, найз нөхөд, хамаарал бүхий этгээд нартаа анхааруулж хэлэх, мөнгө гуйхдаа фейсбүүк чатаар бус, утсаар залгаж тодруулах зэрэг зөвлөмжийг цагдаагийн байгууллагаас амаар болон цахим хуудсаар иргэд, олон нийтэд сурталчилж ажиллаж байна.</p>	
--	--	---	--